

Гэрлэлт ба Гэр Бүхийн марилцаа:

Багшийн Гарын Авлага



ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦАА:

БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

Есүс Христийн Хожмын Үеийн
Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэв
Юта, Солт Лейк Хот

Тайлбар ба Санал

Энэ суралцах гарын авлагын талаарх таны тайлбар болон санал зөвлөмжийг талархан хүлээн авах болно. Тэдгээрийг дараах хаягаар илгээнэ үү:

Curriculum Planning
50 East North Temple Street, Floor 24
Salt Lake City, UT 84150-3200
USA

Электрон шуудан: cur-development@ldschurch.org

Нэр, хаяг, хэсэг болон гадасны нэрийг жагсаан бичнэ үү. Суралцах гарын авлагын гарчгийг бичсэн байхаа анхаараарай. Тэгээд дараа нь суралцах гарын авлагын давуу тал болон сайжруулах боломжтой хэсгүүдийн талаарх тайлбар хийгээд зөвлөмжөө санал болгоно уу.

© 2000 by Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Англи эхийн зөвшөөрөл: 8/97

Орчуулгын зөвшөөрөл: 8/97

Marriage and Family Relations: Participant's Study Guide-ын орчуулга
Mongolian

ЕРӨНХИЙ ЗААВРУУД

Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцааны Цуврал Хичээлийг хэрхэн ашиглах вэ?

Энэ цуврал хичээл нь Сүмийн гишүүдэд гэрлэлт хийгээд гэр бүлүүдийг бэхжүүлэх мөн гэр бүлийн харилцаандаа баяр баясгаланг олоход нь туслахад зориулагдсан болно. Бишопын зөвлөл болон салбарын ерөнхийлөгчийн зөвлөл цуврал хичээлийг үр дүнтэй хэрэгжиж байгаад хяналт тавих үүрэгтэй.

Сүмийн гишүүд өөр өөр хэрэгцээнүүдтэй бөгөөд гэр бүлийн өөр өөр нөхцөл байдлаас гаралтай байдаг учраас цуврал хичээл хоёр хэсэгт хуваагддаг. “Гэрлэлтийг Бэхжүүлэх нь” гэсэн Хэсэг А нь ялангуяа гэрлэсэн хосууд болон гэрлэхээр зэхэж буй гишүүдэд тус болох юм. “Гэр Бүлийг Бэхжүүлэхэд Эцэг Эхийн Үүрэг Хариуцлагууд” гэсэн Хэсэг Б нь эцэг эх болон өвөө эмээ нарт “[хүүхдүүдийг] Их Эзэний дэг журам болон сургамж дотор хүмүүжүүлэх” (Ефес 6:4) хичээл зүтгэлд нь тусална. Цуврал хичээлд оролцож байгаа гишүүд хувийнхаа хэрэгцээнийхээ дагуу оролцох эсэхээ сонгож болно гэдгийг ойлгох хэрэгтэй. Жишээлбэл, хүүхэдгүй байгаа гэрлэсэн хосууд хэсэг Б биш, А хэсэгт оролцохыг хүсч болно. Ганц бие эцэг эх зөвхөн Б хэсгийн хичээлүүдэд оролцохоор шийдэж болно.

Хэсэг болон салбарын удирдагчид цуврал хичээлийг ашиглахдаа Сүнсний өдөөлт болон гишүүн бүрийнхээ хэрэгцээний дагуу уян хатан байж болох юм. Тэд дараах санаануудыг авч үзэж болно:

- Бишопын зөвлөл болон салбарын ерөнхийлөгчийн зөвлөл уг цуврал хичээлд Ням Гарагийн Сургуулийн анги шиг хуваарь гаргаж болно. Сүнсний удирдамжаар удирдагчид нь тодорхой гишүүдийг хичээлд суухыг урьж болно.
- Дээд санваартнуудын бүлгийн удирдагч, ахлагчдын чуулгын ерөнхийлөгчид, Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчид хичээл бүрийг сар бүрийн эхний Ням Гарагт өгөх зааварчилгаанд зориулан ашиглаж болно. Тохиромжтой бол тэд хичээлүүдийг галын дэргэдэх ярилцлагууд болон долоо хоногийн үдшүүд буюу Бямба гарагуудад заах боломжтой үедээ ашиглаж болох юм.
- Бишопын зөвлөл болон салбарын ерөнхийлөгчийн зөвлөл тав дахь Ням Гарагт Мелкизедек Санваартан—Нийгмийн Халамжийн Бүлгийн нэгдсэн цуглаануудад тусдаа хичээлүүдийг ашиглаж болно. Тэд бас хичээлүүдийг залуу эрэгтэйчүүд болон залуу эмэгтэйчүүдэд зориулсан галын дэргэдэх ярилцлагад хэрэглэж болно.
- Аароны Санваартны болон Залуу Эмэгтэйчүүдийн зөвлөхүүд уг гарын авлагыг Мючелын үдэшт зориулсан эх сурвалж болгон ашиглаж болно. Тэд хичээлүүдийг залуу эрэгтэйчүүд болон залуу эмэгтэйчүүдийг хамтад нь эсвэл тус тусынх нь байгууллагуудад заахад ашиглаж болох юм.
- Хувь хүмүүс болон хосууд цуврал хичээлийг өөрсдөө судалж болно.

Цуврал хичээлд зориулсан материалуудыг хэн авч болох вэ?

Хэсэг болон салбарын доор жагсаасан гишүүн бүр *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Багийн Гарын Авлагын* нэг хувь, мөн *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын* нэг хувийг авах ёстой:

Бишоп болон салбарын
ерөнхийлөгч

Дээд санваартнуудын бүлгийн
удирдагч

Ахлагчдын чуулгын ерөнхийлөгч

Залуу Эрэгтэйчүүдийн
ерөнхийлөгч

Нийгмийн Халамжийн Бүлгийн
ерөнхийлөгч

Залуу Эмэгтэйчүүдийн
ерөнхийлөгч

Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцааны

Цуврал Хичээлийн багш

Цуврал хичээлд оролцогч бүр судлах гарын авлагын нэг хувийг хүлээн авах ёстой.

Ерөнхий Зааврууд	iii
“Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”	ix
Удиртгал	x
Энэхүү Цуврал Хичээлийн Зорилго	x
Багшийн Хувьд Таны Үүрэг Хариуцлагууд	x
Гэр Бүлийн Бэрхшээлтэй Асуудлуудыг Зохицуулах нь	xiii
Таны Хэрэглэх Ёстой Материалууд	xiii
Нэмэлт Эх Сурвалжууд	xiii

ХЭСЭГ А: ГЭРЛЭЛТИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

1. “Гэр Бүл Бүтээгчийн Төлөвлөгөөний Төвд Байдаг”	3
Хожмын үеийн бошиглогчид гэрлэлт болон гэр бүлийн мөнхийн ач холбогдлыг тунхагладаг	3
Мөнхийн гэрлэлт нь энэ амьдралд болон үүрд мөнхөд баяр баясгалан хийгээд агуу адислалуудыг авчирч чадна	4
Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцааны цуврал хичээл нь бидэнд гэр бүлийн харилцаандаа баяр баясгаланг олоход туслах зорилготой	6
Бид “Гэтэлгэгчийнхээ хадан дээр” барьснаар бидний гэр орон “тэнгэрийн хэсэг” байж чадна	7
2. Гэрлэлтэд Эв Нэгдлийг Хөгжүүлэх нь	10
Их Эзэн эхнэр нөхрүүдийг нэгдмэл байхыг зарлигласан	10
Эхнэр нөхрүүд бие биенээ тэгш эрхт хамтрагчийн хувьд үнэлэх ёстой	10
Эхнэр нөхрүүд хувийн чанар хийгээд чадвараараа нэг нэгнийгээ нөхөн дэмжиж байх хэрэгтэй	12
Эхнэр нөхрүүд бие биендээ үнэнч байх ёстой	12
3. Гэрлэлтэд Хайр хийгээд Нөхөрлөлийг Хөгжүүлэх нь	14
Эхнэр нөхрүүд бие биенээ хайрлах хайраа хөгжүүлж байх ёстой	14
Хайрын нөлөө, нинжин сэтгэлийн илрэл нь гэрлэлтэд хайр болон нөхөрсөг байдлыг мөхөөхгүйгээр хадгалдаг	15
Гэрлэлт дэх зохих ёсны ойр дотно байдал бол хайрын илрэл мөн	16
Гэрлэсэн хосууд энэрэл, Христийн цэвэр хайрыг өөрсдөдөө байлгахын төлөө хичээн чармайх хэрэгтэй	18

4. Гэрлэлт дэх Бэрхшээлүүдэд Хандах Хандлага	21
Бүх гэрлэсэн хосод бэрхшээл тохиолдох болно	21
Хэрэв эхнэр нөхрүүд гэрлэлтийг гэрээний харилцаа хэмээн үздэг бол тэд ямар ч бэрхшээлийг даван туулж чадна	22
Бэрхшээл бий болоход бид урам хугаралт, эсвэл уур уцаараас илүүтэйгээр тэвчээр хийгээд хайраар хариулахаар сонгож болно . . .	22
5. Эерэг Харилцаагаар Дамжуулан Бэрхшээлүүдэд Хариулах нь . . .	27
Гэрлэсэн хос бүрд санаа бодлын зарим ялгаа байх болно	27
Эхнэр нөхрүүд нэг нэгнээсээ гайхалтай чанаруудыг хайх хэрэгтэй . . .	27
Эерэг харилцаа нь бэрхшээлүүдээс урьдчилан сэргийлж, тэдгээрийг шийдвэрлэхэд тусалдаг	28
6. Итгэл хийгээд Залбирлаар Дамжуулан Гэрлэлтийг Бэхжүүлэх нь	32
Эхнэр нөхрүүд Есүс Христэд итгэх итгэлээ өсгөн нэмэгдүүлэхийн тулд хамтдаа ажиллах хэрэгтэй	32
Эхнэр, нөхрүүд хамтдаа залбирах үед адислагддаг	34
7. Уучлалын Эдгээх Хүч	37
Эхнэр нөхрүүдийн хоорондох уучлалын сүнс амар амгалан, итгэл хийгээд аюулгүй байдлын мэдрэмж авчирдаг	37
Эхнэр нөхрүүд өөрсдийн сул тал, дутагдал доголдлыг уучлахыг эрэлхийлж, сайжрахын төлөө чин сэтгэлийн хүч чармайлт гаргах хэрэгтэй	38
Эхнэр нөхрүүд бие биенээ уучлахыг эрэлхийлж байх хэрэгтэй.	39
8. Гэр Бүлийн Санхүүг Зохицуулах нь	42
Аз жаргалтай гэрлэлтэд санхүүгийн зөв зохицуулалт амин чухал байдаг	42
Эхнэр нөхрүүд мөнгөний зохицуулалтын үндсэн зарчмуудыг баримтлахын тулд хамтран ажиллах хэрэгтэй	43

**ХЭСЭГ Б: ГЭР БҮЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ
ЭЦЭГ ЭХИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГУУД**

9. “Үр Хүүхэд бол Их Эзэний Өв Юм”	51
Тэнгэрлэг Эцэг Өөрийн сүнсэн хүүхдүүдийг дэлхийн эцэг эхчүүдэд итгэл хүлээлгэн өгдөг	51
Эцэг эхчүүд хүүхэд бүрийн хувийн хэрэгцээг хангахыг эрмэлзэх ёстой	52
Хүүхдүүд эцэг эхчүүдтэйгээ хайрын харилцаатай байх эрхтэй	54
Хүүхэдтэй зүй бусаар харьцах нь Бурханыг гомдоодог	55
Хүүхдүүд эцэг эхчүүдийнхээ амьдралд агуу баяр хөөр авчирдаг.	56

10. Эцэг Эхчүүдийн Ариун Үүргүүд (Хэсэг 1: Эцгийн Үүргүүд)	58
Эцэг эхчүүд хүүхэд бүрээ итгэлийн бамбайгаар хангахын тулд хамтран ажиллах ёстой	58
Эцгүүд хайр хийгээд зөв шударга ёсоор тэргүүлэх ёстой	59
Эцгүүд гэр бүлээ амьдралын хэрэгцээт зүйлүүдээр ханган тэтгэж, хамгаалж байх ёстой	61
11. Эцэг Эхчүүдийн Ариун Үүргүүд (Хэсэг 2: Эхчүүдийн Үүргүүд) . . .	63
Эхчүүд Бурханы ажилд оролцдог	63
Эхчүүдийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ өсгөн хүмүүжүүлэх явдал юм	64
Эцэг эхчүүд тэгш эрхт хамтрагчдын хувьд бие биендээ туслах ёстой	66
12. Үлгэр Жишээ хийгээд Заавраар	
Дамжуулан Хүүхдүүдэд Заах нь	68
Эцэг эхчүүд хүүхдүүддээ заах үүрэгтэй	68
Эцэг эхчүүд хүүхдүүддээ заахдаа бурханлиг нөлөөг хүлээн авч болно	69
Эцэг эхчүүд үлгэр жишээ хийгээд заавраар дамжуулан заадаг	70
13. Сайн Мэдээний Зарчмуудыг Хүүхдүүдэд Заах нь (Хэсэг 1)	73
Эцэг эхчүүдийн заадаг зүйлүүд нь хүүхдүүдийг итгэлд бат бөх байхад тусалж чадна	73
Эцэг эхчүүд сайн мэдээний анхдагч зарчмууд хийгээд ёслолуудыг хүүхдүүддээ заах ёстой	74
Эцэг эхчүүд “хүүхдүүддээ залбирахыг, мөн Их Эзэний өмнө тууштай алхахыг заах” ёстой	75
14. Сайн Мэдээний Зарчмуудыг Хүүхдүүдэд Заах нь (Хэсэг 2)	77
Эцэг эхчүүд хүүхдүүддээ заах үедээ тэдэнд хайраа харуулдаг	77
Эцэг эхчүүд өрөвч сэтгэл ба үйлчлэлийг хүүхдүүдэд заах ёстой	78
Эцэг эхчүүд хүүхдүүдэд бусдын өмч хөрөнгөнд үнэнч, хүндэтгэлтэй хандахыг заах ёстой	79
Эцэг эхчүүд шударга хөдөлмөрийн шагналын талаар хүүхдүүдэд заах ёстой	79
Эцэг эхчүүд цэвэр ариун ёс суртахууныг хүүхдүүдэд заах ёстой	81
15. Хүүхдүүдийг Шийдвэр Гаргахад Удирдах нь	84
Хүүхдүүдэд шийдвэр гаргахад нь удирдамж хэрэгтэй	84
Эцэг эхчүүд хүүхдүүдэд сонгох эрхээ зөвөөр хэрэгжүүлэхэд нь тусалж чадна	85
Эцэг эхчүүд хүүхдүүдэд ухаалаг бус шийдвэрийн үр дагавруудаас сургамж авах боломжийг олгох ёстой	88
Эцэг эхчүүд буруу замд орж байгаа хүүхдүүдэд унтаршгүй хайраа үзүүлэх ёстой	89

16. Гэр Бүлийн Залбирал,	
Гэр Бүлээрээ Судар Судлах болон Гэр Бүлийн Үдэш	91
Гэр бүлийн залбирал, судар судлах болон гэр бүлийн үдэш нь Хожмын Үеийн Гэгээнтэн гэр бүл бүрийн эн тэргүүнд тавих зүйл байх ёстой	91
Гэр бүлүүд хамтдаа залбирах үедээ агуу адислалууд хүлээн авдаг	92
Гэр бүлээрээ судар судлах нь гэр бүлүүдийг Бурхантай илүү ойр болоход тусалдаг	92
Гэр бүлийн үдэш нь гэр бүлүүдэд өөрсдийгөө дэлхийн нөлөөний эсрэг хүчирхэг болгоход тусалдаг	94

ГЭР БҮЛ

ДЭЛХИЙ ДАХИНАА ӨРГӨХ ТУНХАГ

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Тэргүүн Зөвлөл ба Арван Хоёр Төлөөлөгчийн Зөвлөл

Есүс христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмийн тэргүүн зөвлөл ба Арван Хоёр Төлөөлөгчийн Зөвлөлийнхөн бид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтийг Бурхан заяасан бөгөөд гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг чин сэтгэлээсээ тунхаглаж байна.

Бурхан бүх хүн төрөлхтөн, эрэгтэй эмэгтэй хүмүүсийг өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн. Хүн бүр тэнгэрлэг эцэг эхийн хайртай сүнслэг хүү, охин нь бөгөөд ийм учраас хүн бүр бурханлаг шинж чанар, хувь тавилантай юм. Хүйс бол хувь хүний мөнх бус байдлын өмнөх, мөнх бус болон мөнхийн амьдралын тодорхойлолт ба зорилгын салшгүй шинж чанар юм.

Мөнх бус байдлын өмнөх амьдралдаа сүнслэг хөвгүүд, охид Бурханыг Мөнхийн Эцэг хэмээн мэдэж, биширдэг байсан бөгөөд мөнхийн амьдралыг өвлөн авах тэнгэрлэг хувь заяагаа бүрэн дүүрэн ухааран ойлгож төгс төгөлдөр болон хөгжин дэвшихийн тулд бие махбодтой болж энэ дэлхийд амьдрах тухай Түүний төлөвлөгөөг хүлээн зөвшөөрсөн юм. Аз жаргалын тэнгэрлэг төлөвлөгөө нь насан эцэслэсний дараа гэр бүлийн холбоог мөнхжих боломж олгодог. Ариун Сүмүүдэд гүйцэтгэдэг нандин ёслол ба гэрээнүүд нь хувь хүмүүс Бурханы хүрээлэлд эргэн очих, гэр бүлүүд мөнхөд нэгдэх боломжтой болгодог.

Бурханы Адам, Ева хоёрт өгсөн анхны зарлиг нь тэд эхнэр нөхрийн хувьд эцэг эх болж чадах боломжийн талаар байлаа. Өөрийн хүүхдүүддээ, өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж газар дэлхийг дүүргэ хэмээсэн Бурханы зарлиг нь хүчин төгөлдөр байгааг бид тунхаглаж байна. Түүнчлэн үр удмаа үлдээх энэхүү нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр нөхөр болох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой хэмээн Бурхан зарлигласныг тунхаглаж байна.

Мөнх бус амьдралыг бий болгох арга зам нь Тэнгэрээс тогтоогдсон гэдгийг бид тунхагладаг. Бурханы мөнхийн төлөвлөгөөн дэх амьдралын цэвэр ариун байдал болон үүний чухал ач холбогдлын талаар бид батлан хэлж байна.

Нөхөр, эхнэр хоёр нь бие биенээ болон үр хүүхдээ хайрлан, халамжлах албан ёсны хариуцлага хүлээнэ. “Үр хүүхэд бол Их Эзэний өв юм” (Дуулал 127:3).

Эцэг эхчүүд хүүхдүүдээ хайраар болон зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлж бие бялдар болон оюун санааных нь хэрэгцээг хангаж, бие биенээ хайрлан, үйлчилж, Бурханы зарлигуудыг дагаж, хаана ч амьдарсан хуулиа хүндэтгэн сахидаг иргэд байхыг зааж сургах нандин үүрэгтэй юм. Эхнэр, нөхөр—эцэг, эхчүүд үүргээ хэрхэн биелүүлснээрээ Бурханы өмнө хариуцлага хүлээнэ.

Гэр бүл Бурханаас заяагддаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүл болох нь Түүний мөнхийн төлөвлөгөөний зайлшгүй нэг хэсэг юм. Хүүхдүүд нь гэр бүлийн дотор төрж, гэрлэлтийн тангаргаа үнэнчээр сахидаг эцэг эхээр өсгүүлэх эрхтэй юм. Их Эзэн Есүс Христийн сургаалд үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно. Аз жаргалтай гэрлэлт болон гэр бүлүүд нь итгэл, залбирал, наманчлал, өршөөл, хүндэтгэл, хайр энэрэл, өрөвч сэтгэл, ажил хөдөлмөр ба гэр бүлээрээ үр бүтээлтэй ажиллах зарчмуудын дор оршин амьдарна. Тэнгэрийн загвараар эцэг нь өрх гэрээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, амьдралын хэрэгцээт зүйлсээр нь хангаж гэр бүлээ хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал юм. Энэхүү нандин үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой. Тахир дутуу болох, нас нөгчих болон бусад нөхцөл байдалд хувь хүн зайлшгүй дасан зохицох шаардлага гарч болно. Төрөл төрөгсөд нь эрэгтэй үед туслан дэмжвэл зохино.

Ариун явдлын гэрээгээ зөрчин, хань ижил, үр хүүхэдтэйгээ зүй бусаар харьцсан, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй хувь хүн хожмын нэг өдөр Бурханы өмнө өчиг мэдүүлэх болохыг бид анхааруулж байна. Түүнчлэн гэр бүлээ сарниулбал эрт эдүгээгийн бошиглогчдын зөгнөн хэлснээр хувь хүн, нийгэм, улс үндэстнүүдэд гай гамшиг авчрах болно гэдгийг бид сануулж байна.

Итгэл хүлээсэн иргэд, төрийн албан хаагч та бүхнийг нийгмийн үндсэн нэгж болох гэр бүлийг бэхжүүлэн авч явах эдгээр арга замыг ямагт хэрэгжүүлэгтүн хэмээн уриалан дуудаж байна.

Энэхүү тунхгийг Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли Юта дахь Солт Лэйк Ситид 1995 оны 9-р сарын 23-нд болсон Нийгмийн Халамжийн Бүлгийн Ерөнхий Уулзалтан дээр захиасынхаа нэгэн хэсэг болгон уншсан юм.

Энэ Цуврал Хичээлийн Зорилго

Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцааны Цуврал Хичээл нь Сүмийн гишүүдэд гэрлэлт хийгээд гэр бүлүүдийг бэхжүүлэх мөн гэр бүлийн харилцаандаа баяр баясгаланг олоход нь туслахад зориулагдсан болно. Энэ нь хоёр хэсэгт хуваагддаг. “Гэрлэлтийг Бэхжүүлэх нь” гэсэн А хэсэг нь ялангуяа гэрлэсэн хосууд болон гэрлэхээр зэхэж буй гишүүдэд тус болох юм. “Гэр Бүлийг Бэхжүүлэх Эцэг Эхийн Үүрэг Хариуцлагууд” гэсэн Б хэсэг нь эцэг эх болон өвөө эмээ нарт “[хүүхдүүдийг] Их Эзэний дэг журам болон сургамж дотор хүмүүжүүлэх” (Ефес 6:4) хичээл зүтгэлд нь тусална.

Уг цуврал хичээл нь судруудад болон хожмын үеийн бошиглогч, төлөөлөгчдийн заасан сургаал болон зарчмууд дээр үндэслэгдсэн юм. Энэ нь уг суралцах гарын авлагын их хуудсанд оруулсан “Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”-ийг онцлон тэмдэглэсэн байдаг.

Багшийн Хувьд Таны Үүрэг Хариуцлагууд

Та гэрлэлт ба гэр бүлийн мөнхийн ач холбогдол хийгээд гэрлэлт ба гэр бүлийг бэхжүүлэх агуу хэрэгцээний талаар тунгаан бодсоноор энэ цуврал хичээлийг заах дуудлагынхаа бүрэн ач холбогдлыг ухаарч эхлэх болно. Таны өөрийгөө зориулах байдал болон залбирал бүхий бэлтгэл нь цуврал хичээлд оролцож байгаа хүмүүсийн адилаар танд болон таны гэр бүлд адислалуудыг авчирна. Та нар дуудлагаа хичээнгүйлэн гүйцэтгэхээр мэрийхдээ v-xiii хуудсан дээрх тоймлон үзүүлсэн зарчмуудыг санаарай.

Өөрийгөө Заахад Бэлтгэ

Энэ цуврал хичээлийн багшийн хувьд таны үүрэг хариуцлага бол Ариун Сүнсний хүчээр сайн мэдээний сургаалуудыг заах явдал юм. Танд гэр бүлийн зөвлөгөөний талаар мэргэжлийн сургалт ч хэрэггүй, гэр бүлд тохиолдож болох бүх сорилтуудад шийдвэр гаргах чадвартай байх ч албагүй. Ангийн ярилцлагууд нь оролцогчдыг өөрийн амьдралын тухай мөн гэр бүлдээ ахиц дэвшил гаргах талаар тунгаан бодож залбирахад нь хөтлөх ёстой.

Хувийн бэлтгэл, зааж байгаа хүмүүсээ хайрлах, Сүнсээр заах зэрэг сайн мэдээг заах үндсэн, гол чухал зарчмуудад тусламж авахын тулд дараах эх сурвалжуудад хандаарай:

- *Сүмийн Зааварчилгааны Гарын Авлага, Ном 2-ын: “Сайн Мэдээг Заах болон Удирдлага” хэсэг 16, Санваартан болон Хавсралт Байгууллагуудын Удирдагчид (35209 эсвэл 35903).*
- *The Teaching, No Greater Call (36123).*
- *Заах Удирдамж (34595).*

Цуврал Хичээлийн Өргөн Цар Хүрээг Сана

Эхний хичээлийг заахаасаа өмнө цуврал хичээлийг бүхэлд нь тоймлон үзэх цаг гарга. Энэ нь танд уг хичээлүүд нь гэрлэлт ба гэр бүлүүдийг бэхжүүлэхэд хэрхэн хамтдаа ажиллаж байгааг харахад тусална.

Та хичээл бүрийг бэлтгэхдээ цуврал хичээлийн тоймыг харуулсан гарчгийг (хуудас 0-00 (v-viii)), эргэн харах нь танд туслах болно. Аль хэдийн заасан мөн сурсан зүйлсээ эргэн хараад хичээл бүр дэх сургаалууд болон зарчмууд нь цуврал хичээлийг цогц байдалд нь хэрхэн дэмжиж байгааг эргэцүүлэн бод.

Хичээлийн Бэлтгэлээ Эртнээс Эхэл

Хэрэв та хичээл бүрээ эрт бэлтгэж эхлэх юм бол таны бэлтгэл илүү амжилттай байна. Хичээл заасныхаа дараа удалгүй дараагийнхаа хичээлийг тоймлон хар. Хэрэв та юу заах вэ гэдгээ мэдэж байх юм бол долоо хоногийн турш тэр хичээлийг эргэцүүлэн бодож чадна. Энэ нь танд онцлон хэлэх ёстой зарчмуудыг мөн таны ашиглаж болох аргууд болон хуваалцах тохиолдлуудыг илүү сайн мэдэхэд тусалж чадна.

Оролцогчийн Хэрэгцээнд Хамгийн Сайн Тохирох Хичээлийн Материалуудыг Сонго

Оролцогчийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалуудыг сонгоход туслах Сүнсний удирдамжийг эрэлхийлэн хичээл бүр дэх сургаалууд болон зарчмуудыг анхааралтай судал. “Хичээлийн амжилт нь зааж байгаа хүмүүст та хэрхэн нөлөөлснөөр хэмжигдэнэ” гэдгийг санаарай (*Teaching, No Greater Call* [1999], 103).

Хичээлүүдээ Хэрхэн Заахаа Тодорхойл

Хичээл дээрээ юу заах гэж байгаагаа тодорхойлохоос гадна үүнийгээ хэрхэн заахаа шийдэх нь чухал юм. Та оролцогчдоо сурсан сургаал болон зарчмуудаа хэрэгжүүлэхэд нь урамшуулах арга замаар заахыг хичээх ёстой.

Энэ цуврал хичээлүүд дэх хичээлүүд лекц байхаасаа илүү ярилцлагын журмаар өгөгдөх ёстой. Зааж байгаа сургаал болон зарчмуудыг ярилцахад гишүүд утга учиртайгаар оролцоход нь тусал. Анги дахь ярилцлагын талаарх Их Эзэний зөвлөгөө Сургаал ба Гэрээний 88:122-т байдаг: “Өөрсдийнхөө дунд багшийг томил, мөн бүгдээрээ нэг зэрэг яригчид бүү байг; бүгдээрээ ярихад бүгдээрээ бүхнээс сэнхэрсэн байж болохын тулд, мөн хүн болгон тэгш боломжтой байж болохын тулд харин нэг нь хэсэг хугацаанд ярьж, мөн бүгдээрээ түүний хэлэхийг сонсог.”

Боломжтой бол оролцогчдод хичээл дэх зарчмуудыг сурч, ойлгоход нь туслах олон янзын арга замуудыг ашиглаарай. Жишээлбэл, самбарт бичих, үзүүлэнт хичээл ашиглах, мөн зураг үзүүлэх гэх мэт боломжуудыг эрж хай.

Оролцогчдыг Сурсан Зүйлээ Хэрэгжүүлэхэд Урь

Сайн мэдээний багшийн хувьд та хэдийгээр маш сайн, сонирхолтой аргаар зааж байгаа ч гэсэн зөвхөн мэдээлэл хуваалцах нь хангалттай биш юм. Таны зорилго бол бусдад сурч буй сургаал хийгээд зарчмуудын дагуу амьдрахад нь туслах явдал юм. Сүмийн 11 дэх Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Харольд Б.Лий ингэж зөвлөжээ:

“Сайн мэдээний бүх зарчмууд болон ёслолууд сайн мэдээний заасан зүйлсийг хэрэгжүүлэн суралцах урилга мэт байдаг. Ямар ч хүн аравны нэгийг төлөх хүртлээ аравны нэгийн зарчмыг мэддэггүй. Ямар ч хүн Мэргэн Ухааны Үгийг сахих хүртлээ Мэргэн Ухааны Үгийн зарчмыг мэддэггүй. Хүүхдүүд буюу энэ асуудалд хамаатай өсвөр насныхан эдгээр зарчмуудын талаар хэн нэгний ярьж байхыг сонсоод аравны нэг, Мэргэн Ухааны Үг, Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь хадгалахад буюу залбиралд өөрчлөгдөөгүй байдаг. Бид сайн мэдээний дагуу амьдарснаар үүнийг сурдаг билээ. . . .

“ . . . Бид зарчим бүрийн дагуу амьдарснаар ирдэг адислалуудыг мэдрэх хүртлээ сайн мэдээний заасан зүйлсийн талаар ямар ч зүйлийг үнэхээр мэдэж авч чадахгүй” (*Stand Ye in Holy Places* [1974], 215).

Сүмийн сэтгүүлүүд нь ихэвчлэн Сүмийн гишүүд сайн мэдээгээр амьдарснаараа хэрхэн адислагдаж байгааг үзүүлсэн урам хайрласан түүхүүдийг агуулдаг. Та сэтгүүлийн лавлагаанаас эрж хайснаар тодорхой сургаалууд болон зарчмуудыг заадаг түүхүүдийг олж чадна. Эдгээр түүхүүдийн заримыг нь ангид хуваалцахыг бодолцоорой.

Хичээл бүрийн төгсгөлд оролцогчдоо сурсан зүйлээ амьдралд хэрэгжүүлэхийг урь. Тэднийг хэрэгжүүлэхэд урамшуулах урилга өгөх хангалттай хугацаа үлдээ. Иймэрхүү урилгуудыг илэрхийлэх арга замуудыг төлөвлө. Жишээлбэл, “Үр Хүүхэд бол Их Эзэний Өв юм” хэмээх 9-р хичээлийн ерөнхий зарчмуудыг үзсэний дараа оролцогчдыг хүүхэд бүртэйгээ ганцаарчлан цагийг өнгөрөөх амлалт өгөхийг урь.

Цуврал Хичээлд Зориулсан Судлах Гарын Авлагыг Ашиглахад нь Оролцогчдыг Урамшуулан Дэмж

Хичээл бүрийн бэлтгэлийнхээ нэг хэсэг болгон *та Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага* (36357) дахь холбогдох материалуудыг тоймлон үзэх ёстой. Оролцогчдыг “Хэрэгжүүлэхэд Зориулсан Санаануудаас” доод тал нь нэг зөвлөгөөг дагаж, (2) хичээл бүрт дагалдах нэг, эсвэл хэд, хэдэн өгүүллэгийг уншихад нь урамшуулах арга замуудыг төлөвлө. Гэрлэсэн хосууд судлах гарын авлага дахь өгүүллэгүүдийг уншиж, ярилцсанаар агуу ашиг тусыг авч чадна гэдгийг онцгойлон хэл.

Оролцогчид хичээл бүртээ судлах гарын авлагыг авчрах ёстой.

Гэр Бүлийн Уламжлалт Байдалд Байдаггүй Хүмүүсийн Хэрэгцээнд Хариул

Зарим нь гэрлээгүй, бэлэвсэн, салсан, эсвэл гэр бүлийн бусад хүнд хэцүү нөхцөл байдалд байж болох оролцогчдынхоо хувийн нөхцөл байдалд мэдрэмжтэй бай. Сүмийн 12 дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын хэлсэн дараах үгсийг санаж яваарай:

“Бид . . . үргэлжлүүлэн Хожмын Үеийн Гэгээнтэн гэр бүлийн төгс жишээ байсаар байх хэрэгтэй. Ийм гэр бүлд амьдрах боломжгүй хүмүүсийн хувьд энэ баримт нь үүний тухай ярихгүй байх хангалттай шалтгаан биш юм. Бид гэр бүлийн амьдралын тухай ярихдаа олон нь одоогоор ийм гэр бүлүүдэд харъяалагдаагүй юмуу хувь нэмрээ оруулаагүй байж болно гэдгийг мэдээд үүний талаар мэдрэмжтэй байх хэрэгтэй. Гэхдээ бусад маш олон зүйл үүнээс хамаардаг учраас бид энэ жишгийг хойш нь тавьж болохгүй” (*The Teachings of Spencer W. Kimball*, хянан тохиолдуулсан Эдвард Л.Кимбалл [1982], 294–95).

**Гэр Бүлийн
Бэрхшээлтэй
Асуудлуудыг
Зохицуулах нь**

Ярилцахыг урамшуулж байхдаа оролцогчиддоо гэр бүлийн бэрхшээлтэй асуудлуудыг нарийвчлан тодорхой хуваалцах нь зохимжгүй гэдгийг ойлгуулаарай. Хэрэв оролцогчид ноцтой хүндрэлүүдийн тухайд зөвлөмж эрэлхийлж байвал тэдэнд бишоптой хувьчлан ярилцахыг найрсгаар урамшуулан дэмжээрэй. Тэр тэдэнд зөвлөгөө өгч чадах болно. Тэрээр Сүмийн жишгүүдэд нийцдэг зөвлөмжөөр хангадаг олон нийтийн эх сурвалжуудыг бас санал болгож болно.

**Таны Хэрэглэх Ёс-
той Материалууд**

Сүм нь гэрлэлт ба гэр бүлийн тухай үнэн сургаалууд болон зарчмуудыг заахад тань туслах хангалттай эх сурвалжуудыг гаргасан болно. Бэлтгэл болон заалтандаа худалдааны зориулалтаар гаргасан материалуудыг ашиглахыг цээрлээрэй. Цуврал хичээлийг заахад тань зориулсан хамгийн гол эх сурвалжууд бол судрууд, энэхүү гарын авлага, *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага* юм. Энэ цуврал хичээлд зориулсан материалын бэлтгэлд чухал бодлууд болон залбирлууд орсон байгаа.

**Нэмэлт Эх
Сурвалжууд**

Сүмээс хэвлэн гаргасан дараах эх сурвалжууд нь энэ цуврал хичээлд ярилцах сэдвүүдийн талаар нэмэлт мэдээллийг өгдөг. Эдгээр эх сурвалжуудыг Сүмийн материал хангамжийн төвүүдээр дамжуулан авах боломжтой. Та оролцогчоо эдгээр хэвлэл нийтлэлүүдийг гэр бүлдээ ашиглахыг урамшуулан дэмжихийг хүсч болно (тэдгээр нь *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага* дахь vi хуудсанд жагсаагдсан болно).

- *Гэр Бүлийн Удирдамж* (31180). Энэхүү удирдамж нь гэр бүлийн зохион байгуулалтыг тайлбарлаж, сайн мэдээг гэртээ заах тухай мэдээллээр хангадаг бөгөөд санваарын адислалууд болон ёслолуудын үйл явцыг тоймлож өгдөг.
- Сүмийн сэтгүүлүүд дэх гэрлэлт болон гэр бүлийн тухай өгүүлүүд.
- *Гэр Бүлийн Үдшийн Эх Сурвалж Ном* (31106). Энэ ном нь эцэг эх болон хүүхдүүдэд гэр бүлийн үдэшт зориулан хичээлүүдэд бэлтгэхэд нь тусалдаг (х.3–160, 173–232). Энэ нь гэр бүлийн үдшийг хийхэд зориулсан санаанууд болон хүүхдүүдэд тодорхой зарчмууд ба үүрэг хариуцлагуудын талаар заахад зориулсан зөвлөгөөнүүдийг агуулдаг (х.235–62). Энэ нь бас гэр бүлийн үйл ажиллагаануудад зориулсан санаануудыг агуулдаг (х.265–340).
- *Teaching, No Greater Call* (36123). Энэ эх сурвалж нь Сүмийн гишүүдийг сайн мэдээний багш нарын адил өсөн хөгжихөд нь туслах зарчмууд болон практик зөвлөмжүүдийг агуулдаг. “Гэрт Заах нь” гэсэн Хэсэг Г нь ялангуяа эцэг эхчүүдэд тустай.
- *Заах Удирдамж* (34595). Энэхүү удирдамж нь сайн мэдээг сайжруулан зааж, суралцах тухай санал, зөвлөмжөөр хангах болно.

- *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* (34285). Энэ товхимол нь болзоо, хувцаслалт ба гадаад төрх, нөхөрлөл, шударга зан, хэл яриа, мэдээллийн хэрэгсэл, оюун санаа болон биеийн эрүүл мэнд, хөгжим, бүжиг, бэлгийн харилцааны цэвэр ариун байдал, Хүндэтгэлийн өдөр баримтлах зүйл, наманчлал, зохистой байдал ба үйлчлэлийн талаарх Сүмийн жишгүүдийг тоймлож өгдөг.
- *Эцэг Эхчүүдийн Удирдамж* (31125). Энэ гарын авлага нь эцэг эхчүүдийг хүүхдүүддээ бие махбодийн хөгжлийн талаар заахад туслах зөвлөмжүүдийг агуулдаг.
- *Аз Жаргалтай Гэр Бүлийн Тулгын Чулуу* (33108). Энэ товхимол нь Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли Тэргүүн Зөвлөлд Хоёрдугаар Зөвлөхөөр үйлчилж байхдаа хэлсэн үгийг агуулдаг.
- “Гэр Бүлийн Санхүүгийн Удирдамж” Лиахона, 2000 оны Дөрөвдүгээр сар. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Марвин Ж.Аштоны энэхүү өгүүлэл нь гэр бүлийн Санхүүг зохицуулах тухай бодит зөвлөмжүүдийг өгдөг.

Хэсэг А ГЭРЛЭЛТИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ



“ГЭР БҮЛ БҮТЭЭГЧИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨВД БАЙДАГ”

Хичээл

1

Зорилго

Гэр бүлийн мөнхийн ач холбогдлыг онцгойлон хэлэх хийгээд Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцааны тухай цуврал хичээлийн бүрэн ашиг тусыг хүлээн авахын тулд юу хийх хэрэгтэйгээ мэдэхэд нь оролцогчдод туслах.

Бэлтгэл

1. “Багшийн Хувьд Таны Үүрэг Хариуцлагууд” дахь зарчмуудыг тоймлон үз (энэ гарын авлагын хуудас х–хiii). Заах бэлтгэлийнхээ эдгээр зарчмуудыг ашиглах арга замуудыг хай.
2. Хичээл дэх сургаалууд болон зарчмуудыг тоймлон үзүүлэх тодоор бичсэн хичээлийн гарчгуудыг унш. Бэлтгэлийнхээ нэг хэсэг болгон эдгээр сургаалууд болон зарчмуудыг долоо хоногийн турш эргэцүүлэн бодоод, оролцогчдын хэрэгцээнд тохируулан юуг онцлон хэлэхээ шийдэхэд Сүнсний удирдамжийг эрэлхийл.
3. Энэ гарын авлагын хуудас ix дахь болон *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын* хуудас iv дэх “Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”-ийг залбирч судал.
4. Оролцогч бүрт зориулан *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын* (36357) нэг хувийг ав. Та эдгээр хувиудыг Ням Гарагийн Сургуулийн ерөнхийлөгчийн зөвлөл, хэсгийн санхүүч, эсвэл материал хариуцахаар томилогдсон хэсгийн бичиг хэргийн ажилтнаас авч болно.
5. Нэг, эсвэл хоёр оролцогчийг ариун сүмд гэрлэхдээ ямар сэтгэгдэлтэй байснаа товчхон ярихаар бэлтгэхийг урьдчилан хүс. Тэднийг бас хань ижилтэйгээ мөнхөд холбогдсоноор энэ амьдралд хүлээн авч байгаа баяр баясгалан хийгээд адислалуудынхаа тухай ярихаар бэлтгэхийг хүс. Та энэ даалгаврыг гүйцэтгэхийн тулд хэнээс асуух талаар шийдэхдээ Сүнсний удирдамжийг эрэлхийл.
6. Хичээл эхлэхээс өмнө дараах ишлэлийг самбарт бич (*Stand Ye in Holy Places*-ээс [1974], 255):

Та нар болон миний хэзээ нэгэн цагт хийх Их Эзэний хамгийн чухал ажил нь бидний өөрсдийн гэрийн ханануудын дунд хийгдэх болно.

*Ерөнхийлөгч Харольд Б.Лий
Сүмийн 11 дэх Ерөнхийлөгч*

Энэ хичээлийг заах зөвлөмж

Хожмын үеийн бошиглогчид гэрлэлт болон гэр бүлийн мөнхийн ач холбогдлыг тунхагладаг.

Дараах болсон түүхийг хуваалц:

Нэгэн эрд аюулт үерт бүх зүйлсээ алдсан мэт санагджээ. Тэр дэлхийн эд зүйлсээ алдсандаа биш, харин хайрт эхнэр, дөрвөн хүүтэйгээ дахин хамт

байхгүй нь гээд уйлсан ажээ. Тэд үнэхээр үерт үйсэн байж болох байлаа. Удалгүй түүнд тэднийг амьд байгаа бөгөөд ойролцоох түргэн тусламжийн хэсэгт түүнийг хүлээж байгаа тухай хэл иржээ. Тэр гэр бүл дахин хамт байх болсон нь юутай баясгалантай хэрэг вэ! Тэднийг баярлан хөөрч байхад тэр эр ингэж хэлжээ, “Би дахин гэр бүлтэйгээ хамт байх боллоо, хэдийгээр надад өөрийн гэсэн дэлхийн нэг ч эд баялаг байхгүй ч гэсэн, би яг л саятан шиг байна” (Robert L. Simpson, Conference Report-аас иш татав, 1980 оны 10 сар, 11–12; *Ensign*, 1980 оны 11 сар, 11).

Өөрийн гэрлэлт ба гэр бүлийн тухай итгэл үнэмшил хийгээд гэрчлэлээ товчхон хуваалц. Тохиромжтой бол гэр бүлийнхээ тухай сэтгэгдлээ хуваалц. Тэгээд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Бойд К.Пакерын хэлсэн дараах мэдэгдлийг унш:

“Сүмийн голт зүрх нь гадасны [төв] биш; цуглааны байрууд ч биш. . . . Дэлхий дээрх хамгийн ариун нандин газар нь заавал ариун сүм биш байж болно. Цуглааны байр, гадасны [төв] болон ариун сүм нь Сүмийн хамгийн ариун нандин байгууллагын байр болох гэр, Сүмийн хамгийн ариун нандин хэлхээ холбооны адислал болох гэр бүлийг дэмжихийнхээ хирээр ариун нандин юм” (“*That All May Be Edified*” [1982], 234–35).

Оролцогч бүрт *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын* нэг хувийг өг. Оролцогчдоор хуудас iv-г гаргуул. 1995 онд Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга гэрлэлт ба гэр бүлийн талаар бүх дэлхийд тунхаг гаргасныг тайлбарла. Уг Тунхагт заагдсан сургаал болон зарчмуудаас олон нь энэ цуврал хичээл дээр яригдах болно. Өөр өөр оролцогчдыг догол мөр бүрийг уншихыг урьж, тунхгийг оролцогчид-той хамт унш.

- Гэр бүлийн тухай тунхагт зарим ямар сургаал болон зарчмуудыг заадаг вэ? (Оролцогчдын хариултыг самбарт жагсаан бичихээр төлөвлө.) Дэлхийд яагаад энэхүү зөвлөгөө, сэрэмжлүүлэг хэрэгтэй вэ?

Сүмийн 15 дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли: “Бидэнд одоо яагаад гэр бүлийн тухай тунхаг байна вэ? Яагаад гэвэл гэр бүл дайралтын дор байна. Бүх дэлхий даяар гэр бүлүүд салж сарниж байна. Нийгмийг сайжруулж эхлэх газар нь гэр орон юм. Хүүхдүүд ихэнхдээ юу заалгаснаа хийдэг. Бид гэр бүлийг хүчтэй болгосноор дэлхийг арай илүү дээр болгохыг хичээж байна” гэж тайлбарлажээ (“*Inspirational Thoughts*,” *Ensign*, 1997 оны 8 сар, 5).

- Энэ тунхаг дээрх зөвлөгөөг дагаснаар та нар болон танай гэр бүлийнхэн хэрхэн бэхэжсэн бэ?

Мөнхийн гэрлэлт нь энэ амьдралд болон үүрд мөнхөд баяр баясгалан хийгээд агуу адислалуудыг авчирч чадна.

Мөнхийн гэрлэлт нь Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын агуу төлөвлөгөөний гол төв нь юм гэдгийг онцлон хэл. Энэ нь гэр бүлүүдийг энэ амьдралд жинхэнэ баяр баясгаланг олох хийгээд үүрд мөнхөд үргэлжлүүлэх мөн хөгжин дэвжих боломжтой болгодог.

- Бид үүрд мөнхөд гэрлэснээрээ энэ амьдралд ямар адислалуудыг хүлээн авч болох вэ?

Товлосон оролцогчдыг ариун сүмд гэрлэхдээ ямар сэтгэгдэлтэй байсан болон хань ижилтэйгээ мөнхөд холбогдсоноор энэ амьдралд хүлээн авч байгаа баяр баясгалан хийгээд адислалуудынхаа тухай товчхон ярихыг урь (“Бэлтгэл,” зүйл 5-ыг үз).

Дараах мэдэгдлүүдээс нэг, эсвэл түүнээс олныг хуваалцахаар төлөвлө:

Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Жеймс Е. Фауст ингэж заажээ: “Эндэх болон үүний дараах аз жаргалд олон гэрээ чухал шаардлагатай байдаг. Хамгийн чухлуудынх нь дунд эхнэр нөхрийн хооронд хийгддэг гэрлэлтийн гэрээнүүд ордог. Эдгээр гэрээнүүдээс л амьдралын хамгийн агуу баяр баясгалангууд урсан гарч байдаг” (Conference Report, 1998 оны 4 сар, 19; *Ensign*, 1998 оны 5 сар, 17).

Ахлагч Боид К. Пакер хэлэхдээ, “романтик туршлага, хайр, гэрлэлт болон эцэг эх байх” нь “хамгийн цэвэр, гоёмсог мөн амьдралын гоо үзэсгэлэн юм” гэжээ (Conference Report, 1993 оны 10 сар, 28; *Ensign*, 1993 оны 11 сар, 21).

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жозеф Б. Вортлин ингэж илэрхийлжээ: “Мөнхийн гэрлэлтийн халуун дотно харьцаа нь Бурханаас Өөрийн хүүхдүүдэд өгсөн агуу адислалуудын нэг юм. Мэдээж гайхамшигтай хамтрагчтайгаа өнгөрүүлсэн олон жил нь миний амьдралд хамгийн гүн баяр баясгаланг авчирсан. Цаг хугацааны эхлэлээс л эхнэр нөхрийн гэрлэлтийн харьцаа нь Тэнгэрлэг Эцэгийн маань аз жаргалын агуу төлөвлөгөөний суурь байсаар ирсэн билээ. Бидний амьдрал сайн сайхныг хүртэж, гэр бүлийнхээ эрхэм гишүүдтэй нийцтэй хандсанаар ирэх адислалуудыг амталснаар сургамжлагдаж мөн сайн сайхан болдог” (Conference Report, 1997 оны 10 сар, 42; *Ensign*, 1997 оны 11 сар, 32).

Ерөнхийлөгч Гордон Б. Хинкли Сүмийн Ерөнхийлөгчийн хувьд Сүмийн ерөнхий гишүүнчлэлд хандан хэлсэн анхныхаа үгэнд: “Би хайрт эхнэртээ тавин найман жилийн дараа энэ сард талархлаа илэрхийлсэн. . . . Би нарны гэрэл хийгээд шуурган дундуур миний дэргэд алхаж байсан энэ үнэ цэнэтэй эмэгтэйд ямар их талархалтай байна вэ. Бид урьдынх шигээ цэх зогсож чадахгүй болсон. Гэвч бие биенээ хайрлах бидний хайранд ямар ч агшилт гараагүй юм” гэжээ (Conference Report, 1995 оны 4 сар, 93; *Ensign*, 1995 оны 5 сар, 70).

Ихэнх хүмүүс гэрлэлт ба гэр бүлийн амьдрал нь зуурдын л явдал гэдэгт итгэдгийг тайлбарла. Гэвч Сүмийн гишүүдийн хувьд бид зохистой хосууд ариун сүмд орж, санваарын ариун ёслолоор дамжуулан эхнэр нөхрийн хувьд мөнхөд хамтдаа холбогдож чадна гэдгийг мэднэ. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс энэ маягаар гэрлэх үед гэр бүлийн мөнхийн эв нэгдэл эхэлдэг.

- Санваарын хүчээр холбогдоод, гэрээндээ итгэлтэй үлдэх гэрлэсэн хосүүдэд ямар мөнхийн адислалууд амлагддаг вэ? (Оролцогчидтой хамт Сургаал ба Гэрээ 131:1–4; 132:19–24, 30–31-ийг унш. Дараах жагсаалтад самбарт бичиж болох зарим хариултуудыг оруулав.)
 - а. Тэд Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христтэй хамт селестиел хаант улсын хамгийн дээд түвшинд өргөмжлөгдөнө (С ба Г 131:1–3; 132:20–24).
 - б. Тэд “энэ амьдралд болон бүх үүрд мөнхөд хамт байх болно” (С ба Г 132:19). Тэдний хүүхдүүд бас мөнхийн гэр бүлийнх нь нэг хэсэг байж

болно. (С ба Г 132:19-д дурдагддаг Амлалтын Ариун Сүнс нь Ариун Сүнс юм гэдгийг тайлбарла. Бидний хүлээн авсан санваарын ёслолууд болон хийсэн гэрээнүүд нь итгэлтэй байдлын маань дагуу Бурханд хүлээн зөвшөөрөгдөнө гэдгийг Ариун Сүнс баталдаг.)

в. Тэд “хаан ширээнүүд, хаант улсууд, вант улсууд болон хүчүүдийг өвлөх болно” (С ба Г 132:19).

г. Тэд үүрд мөнхөд үргэлжлүүлэн үр удам, эсвэл сүнсэн хүүхдүүдтэй байх болно (С ба Г 132:19, 30–31; мөн С ба Г 131:4-ийг үз).

- Энэ нь таныг гэр бүлүүд мөнхөд хамт байж чадна гэдгийг мэдэхэд хэрхэн туслах вэ?

Өөрсдийн буруугаас болоогүйгээр энэ амьдралдаа мөнхийн гэрлэлтийн адислалуудыг хүлээн авах боломжгүй байдаг Хожмын Үеийн олон итгэлтэй Гэгээнтнүүд байдгийг онцлон хэл. Их Эзэн бүх итгэлтэй Гэгээнтнүүдийг яаж ийгээд эдгээр адислалуудыг хүлээн авах болно гэж амласныг онцлон хэл. Хэрэв та оролцогчдод энэ зарчмыг ойлгоход нь туслах хэрэгтэй гэж бодвол Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүксийн дараах мэдэгдлийг унш:

“Одоо Хожмын Үеийн зохистой, гайхамшигтай олон Гэгээнтэн өөрсдийн өсөлт дэвшилтийн төлөөх туйлын боломжууд болон чухал шаардлагуудаар дутагдаж байдгийг бид мэднэ. Ганц бие байх, хүүхэдгүй байх, үхэл болон гэр бүл салалт нь туйлын зорилгыг хясаж, амлагдсан адислалуудын гүйцэтгэлийг хойшлуулдаг. Түүнчлэн бүрэн цагаар эх болон гэрийн ажилтан байхыг хүсдэг зарим эмэгтэйчүүд албан шаардлагаар бүрэн цагийн ажиллах хүч рүү татагдан ордог. Гэвч эдгээр гачигдал нь ердөө л түр зуурын зүйл юм. Зарлигуудыг дагадаг, гэрээндээ үнэнч байдаг, мөн зөв зүйлийг хүсдэг тэдгээр хөвгүүд, охидод үүрд мөнхөд аливаа адислалууд өгөгдөхгүй байна гэж байхгүй хэмээн Их Эзэн амласан билээ.

“Мөнх бус байдлын хамгийн гол гачигдал дутагдал нь Эцэгийн зохистой бүх хүүхдүүдээ зориулсан аз жаргалын агуу төлөвлөгөөн дэх дуусгавар болгогдоогүй бүхнийг гүйцэтгэх тэр цаг хугацаа болох Мянган Жилд хангагдана. Тэр нь ариун сүмийн ёслолуудын хувьд үнэн байх болно гэдгийг бид мэднэ. Энэ нь бас гэр бүлийн харилцаа болон тохиолдлуудын хувьд үнэн байх болно гэдэгт би итгэдэг” (Conference Report, 1993 оны 10 сар, 101; *Ensign*, 1993 оны 11 сар, 75).

Оролцогч бүрийн нөхцөл байдалд тохируулахын тулд хуудас 9-ийн “Нэмэлт Эх Сурвалж Материал” дахь мэдэгдлүүдийн нэгийг, эсвэл хоёуланг нь унших нь тустай байж болох юм.

Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцааны цуврал хичээл нь бидэнд гэр бүлийн харилцаандаа баяр баясгаланг олоход туслах зорилготой.

Нэг оролцогчийг дараах мэдэгдлийг чангаар уншихыг урь:

Сүмийн 11 дэх Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Харольд Б.Лий, “Та нар болон миний хийх Их Эзэний хамгийн чухал ажил нь бидний өөрсдийн маань гэрийн ханан дунд байх болно” гэж хэлжээ (*Stand Ye in Holy Places*, 255).

- Хэрэв бүх хүн энэ энгийн тунхгийн дагуу амьдарвал дэлхий ямар байдлаар өөр байх вэ?

Энэ цуврал хичээл нь биднийг гэрлэлт болон гэр бүлээ бэхжүүлж, мөн гэр бүлийн харилцаандаа баяр хөөрийг олоход туслахаар зохион байгуулагдсаныг тайлбарла. Хичээлүүд нь судар дээр болоод хожмын үеийн бошиглогчдоор заагдсан сургаалууд болон зарчмууд дээр үндэслэгдсэн болно.

Энэ цуврал хичээлд оролцохоор сонгосноор гишүүд гэр бүлүүдээ бэхжүүлэх хүслээ харуулсныг онцлон хэл. Тэд энэ цуврал хичээлээс бүрэн дүүрэн ашиг тусыг авахын тулд хийх ёстой гурван зүйл байдаг:

1. Хичээлд оролц.

Цуврал хичээлд оролцох бүх хүн гэрлэлт, эсвэл хүүхэд өсгөх талаар туршлагатай эсэхээсээ үл хамааран бие биенээсээ суралцаж чадна гэдгийг онцлон хэл. Оролцогчдыг өөрсдийн ярилцдаг үнэнүүдийн тухай гэрчилж, мөн хичээлүүдтэй зохих ёсоор холбогдож байгаа туршлагаудаасаа хуваалцахыг урь.

2. Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Гарын Авлагыг ашигла.

Оролцогчдоор *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Гарын Авлагын* хувиудыг нь нээлгүүл. Гарын авлага нь хичээл бүртээ оролцогчдоод сурсан сургаалууд болон зарчмуудыг хэрэгжүүлэхэд нь туслах зөвлөмжүүд болох “Хэрэгжүүлэхэд Зориулсан Санаанууд” байдгийг онцлон хэл. Нэмж хэлэхэд хичээл бүрд Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн нэг, эсвэл хоёр өгүүлэл дагалддаг. Хичээл бүрийн дараа оролцогчид санал болгосон үйл ажиллагаанаас доод тал нь нэгийг гүйцээн хийж, өгүүлэл бүрээс суралцах хэрэгтэй. Гэрлэсэн хосууд өгүүлүүдийг хамтдаа уншиж, ярилцсанаар маш их тусламж авч чадна.

Гарын авлага дахь хуудас 3—8-ыг үз. Оролцогчдыг (1) “Хэрэгжүүлэхэд Зориулсан Санаанууд” дахь зөвлөгөөнүүдийн доод тал нь нэгийг дагаж, (2) Ахлагч Боид К.Пакерын “For Time and Eternity” өгүүлээс суралцаж, энэ хичээл дэх сургаалууд болон зарчмуудыг хянаж үз.

Оролцогчдыг хичээл бүрд ангидаа суралцах гарын авлагуудаа авчрахыг урамшуулан дэмж.

3. Хичээлүүд дэх сургаалууд болон зарчмуудын дагуу амьдрахыг хичээ.

Сайн мэдээг зөвхөн сурах нь хангалттай биш юм. Сайн мэдээг амьдралдаа ашигтай байлгахын тулд та сурч буй зүйлийнхээ дагуу амьдрах ёстой. Ерөнхийлөгч Харольд Б.Лий мэдэгдэхдээ: “. . . Бид зарчим бүрийн дагуу амьдарснаар ирдэг адислалуудыг мэдрэх хүртлээ сайн мэдээний заадаг зүйлүүдийн талаар ямар ч зүйлийг үнэхээр мэдэж авч чадахгүй” гэжээ (*Stand Ye in Holy Places*, 215).

Орон гэрээ “Тэтэлгэгчийн маань хадан дээр” баривал “тэнгэрийн хэсэг” байх болно.

Өнөөгийн дэлхийд гэр бол бидний амар амгаланг олж чадах цөөн хэдэн газруудын нэг юм гэдгийг онцлон хэл. Дараа нь Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Томас С.Монсоны дараах мэдэгдлийг унш:

“Хэрэв бид үнэхээр хичээвэл гэр орон нь газар дэлхий дээр тэнгэрийн хэсэг болдог юм. Бидний бодлууд, бидний хийдэг үйл хэргүүд, бидний амьдардаг амьдралууд зөвхөн газар дэлхий дээрх аяллын маань амжилтуудад нөлөөлөөд

зогсохгүй, тэдгээр нь мөнхийн зорилгууддаа хүрэх замыг маань тэмдэглэдэг билээ” (in Conference Report, 1988 оны 10-р сар, 80–81; *Ensign*, 1988 оны 11-р сар, 69).

- Гэр орон ямар байдлаар “тэнгэрийн хэсэг” байж чадах вэ?

Оролцогчдыг энэ асуултад хариулсны дараа гэр орон хэрхэн тэнгэрийн хэсэг байж чадах талаарх өөрийнхөө итгэл үнэмшлийг хуваалц. Тохиромжтой бол хувийн нэг, эсвэл хоёр туршлагаа гэрчлэлийнхээ нэг хэсэг болгон хуваалц.

Сүмийн 12 дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын дараах мэдэгдлийг хуваалц:

“Өнгөрсөн үе дэх нийгмийн олон хязгаарлалтууд цуцлагдаж мөн үгүй болж буй гэр бүлийг эргэн батжуулж мөн дэмжлэг үзүүлэхэд тус болсон билээ. Гэр бүлд гүн бөгөөд үр дүнтэй итгэдэг зөвхөн тэдгээр хүмүүс л бидний эргэн тойронд цугларсан муу муухай зүйлийн дунд гэр бүлүүдээ хамгаалан үлдэж чадах үе ирэх болно” (in Conference Report, 1980 оны 10-р сар, 3; *Ensign*, 1980 оны 11-р сар, 4).

Оролцогчидтой хамт Хиламан 5:12-ыг унш. Дараа нь Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Иосеф Б.Вортлиний дараах мэдэгдлийг унш:

“Хэрэв та нар орон гэрээ Гэтэлгэгчийн маань хадан суурь болон сайн мэдээн дээр баривал тэдгээр нь гэр бүлүүд тань амьдралын ширүүн шуургануудаас хоргодож болох ариун газар байж чадна” (in Conference Report, 1993 оны 4-р сар, 88; *Ensign*, 1993 оны 5-р сар, 71).

- Орон гэрээ “Гэтэлгэгчийн маань хадан суурин дээр” барина гэдэг нь таны хувьд ямар утгатай вэ? Хэрэв тэд Христэд төвлөрсөн гэр оронтой бол гэр бүлүүд ямар тодорхой зүйлсийг хийх вэ?

Энэ цуврал хичээл нь гэрлэлтүүд болон гэр бүлүүдийг бэхжүүлэхэд туслах зарчмуудын талаар ярилцдаг гэдгийг онцлон хэл. Бид гэр орондоо Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэд ойр байж чадах учраас эдгээр зарчмуудыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Биднийг гэр бүлүүдтэйгээ үүрд мөнхөд хамт байх боломжтой болгодог Аврагчийн хэмжээлшгүй Гэтэлгэлийн үзэгдлийг бид хэзээ ч зүгээр орхиж болохгүй.

Дүгнэлт

Энэ цуврал хичээлийн талаарх бахархлаа илэрхийлээд оролцогчид танаас багшийн хувьд хүсэн хүлээж болох зүйлийг мэдэгд. Жишээ нь: Та заахын тулд өөрийгөө бэлтгэж, мөн та тэднийг хичээл бүр дэх зарчмуудыг хэрэгжүүлж *Гэрлэлт ба Гэр бүлийн Харилцаа: Оролцогчийн Гарын Авлагыг* ашиглахад нь тэдэнтэй нэгдэнэ гэдгээ тэдэнд батлан хэлж болно. Заадаг хүмүүсээ хичээлд оролцох, суралцах гарын авлагыг ашиглах, мөн сурч байгаа сургаал болон зарчмуудаа хэрэгжүүлэхэд нь урамшуулан дэмж.

Сүнсээр өдөөгдөх үедээ гэр бүлийн агуу ач холбогдлын талаар гэрчил. Гэр бүл тань үүрд мөнхөд хамт байж чадна гэсэн мэдлэгтээ талархдаг талархлаа илэрхийл.

Нэмэлт Эх
Сурвалж
Материал

Гэр бүлийн уламжлалт нөхцөл байдлуудад амьдардаггүй хүмүүсийн хэрэгцээнд тохируулан хэлэх мэдэгдлүүд

Гэр бүлийн уламжлалт нөхцөл байдлуудад амьдардаггүй оролцогчдын байр байдалд тохируулан ярихын тулд дараах мэдэглүүдийн нэгийг нь, эсвэл хоёуланг нь унш:

Сүмийн 13 дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон Сүмийн ганц бие эгч нарт хандан хэлэхдээ: “Бид та нарыг Сүмийн үндсэн чавхдасны амин чухал хэсэг мэт хардаг. Гэр бүлүүдийн талаар бидний байнга онцлон хэлдэг зүйлс нь та нарт өөрсдийгөө Их Эзэн, эсвэл Түүний Сүмд хэрэгцээ багатай буюу үнэлэмж багатай гэж бодоход бүү хүргээсэй гэж бид залбирдаг. Сүмийн гишүүнчлэлийн ариун баталгаа нь гэрлэлтийн байдал, нас буюу одоогийн нөхцөл байдлаас илүү байдаг. Бурханы охины хувьд та нарын хувийн үнэ цэнэ бүх хил хязгаарыг даван гардаг билээ” гэжээ (“To the Single Adult Sisters of the Church,” *Ensign*, 1988 оны 11-р сар, 96).

Сүмийн 10 дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Иосеф Фиелдинг Смит заахдаа: “Хэрэв ариун сүмд энэ амьдралд болон үүрд мөнхөд лацдан холбуулсан эрэгтэй, эсвэл эмэгтэй хүн нүгэл үйлдэж, селестиел хаант улсад өргөмжлөлийг хүлээн авах эрхээ алдвал тэр эрэгтэй, эсвэл эмэгтэй итгэлтэй байсан сэвтсэн хамтрагчийн хөгжил дэвшлийг зогсоож чадахгүй. Хүн бүр өөрийн [хувийн] үйлсүүдийн дагуу шүүгдэх бөгөөд гэмтний нүглүүдийн төлөө гэмгүй нэгнийг шийтгэдэг шударга ёс гэж үгүй” гэжээ (*Doctrines of Salvation*, харьц. Bruce R. McConkie, 3 боть. [1954–56], 2:177).

Зорилго

Гэрлэсэн хосуудад илүү нэгдмэл байхад мөн ганц бие гишүүдийг гэрлэлт дэх эв нэгдэлд баяр хөөртэй байхад нь бэлтгэхэд туслах.

Бэлтгэл

1. Өөрөө “Багшийн Хувьд Таны Үүрэг Хариуцлагууд” дахь (энэ гарын авлагын хуудас х–хiii) зарчмуудыг дагаж болох арга замуудыг хай.
2. Хичээлийн тодоор бичсэн гарчгуудыг унш. Эдгээр гарчгууд энэ хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудын тоймыг өгдөг. Бэлтгэлийнхээ нэг хэсэг болгон оролцогчдод эдгээр сургаалууд болон зарчмуудыг хэрэглэхэд нь туслах арга замуудыг тунгаан бод. Оролцогчдын хэрэгцээг хангахын тулд та юуг онцлон хэлэх ёстойг шийдэхдээ Сүнсний удирдамжийг эрэлхийл.
3. Оролцогч бүрт зориулж ангид хуудас цаас, үзэг, эсвэл харандаа авчир.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Их Эзэн эхнэр нөхрүүдийг нэгдмэл байхыг зарлигласан юм.

Хичээл эхлэхдээ самбарт $1+1=1$ гэж бич.

- Энэ нь гэрлэлтийн харьцааг хэрхэн тодорхойлж байна вэ?

Оролцогчдыг энэ асуултын талаар ярилцсаны дараа тэдэнтэй Эхлэл 2:24-ийг унш. Бурхан эхнэр нөхөр хоёрт нэг байхыг зарлигласан гэдгийг онцгойлон хэл.

- Эхнэр нөхрийн хувьд нэг байна гэдэг нь юу гэсэн үг вэ?

Оролцогчдоор Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Хенри Б.Айрингийн дараах мэдэгдлийг уншуул (*Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын хуудас 8*):

“Эрэгтэй, эмэгтэй хүний бүтээлтийн үед гэрлэлт дэх тэдний нэгдэл нь найдвар байдлаар өгөгдөөгүй юм. Энэ бол зарлиг байсан! ‘Ийм учраас эр хүн эцэг эхээ орхиод, эхнэртэйгээ нийлэн, тэр хоёр нэгэн бие болох ажгуу’ (Эхлэл 2:24). Тэнгэрлэг Эцэг минь бидний зүрх сэтгэлийг нэгдэхийг хүсдэг. Тэр хайран дахь нэгдэл нь зүгээр нэг загвар биш. Энэ бол шаардлага юм” (Conference Report, 1998 оны 4 сар, 85; *Ensign*, 1998 оны 5 сар, 66).

Энэ хичээл дээр эхнэр нөхрүүд нэгдмэл байж чадах хэд хэдэн арга замын талаар ярилцах болно гэдгийг тайлбарла.

Эхнэр нөхрүүд бие биенээ тэгш эрхт хамтрагчийн хувьд үнэлэх ёстой

Гэрлэлт дэх нэгдлийн нэг чухал зарчим нь эхнэр нөхөр хоёр бие биенээ эрх тэгш хамтрагчид хэмээн үнэлэх ёстойг тайлбарла. Ерөнхийлөгч Гордон

Б.Хинкли Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр Зөвлөхөөр үйлчилж байхдаа ингэж хэлжээ:

“Гэрлэлт нь хамгийн үнэн утгаараа бие биенийхээ дээр ноёрхох гэсэн биш, харин аль аль нь нөгөөхдөө байж болох аливаа үүрэг хариуцлагууд болон хүсэл эрмэлзэлд нь тусалж урамшуулж байх эрх тэгш нөхөрлөл юм” (“I Believe,” *Ensign*, 1992 оны 8 сар, 6).

- Нэг байхын тулд эхнэр нөхрүүд бие биенээ яагаад эрх тэгш хамтрагчдын хувьд үнэлэх ёстой вэ?
- Эхнэр нөхрүүдийг гэрлэлтдээ эрх тэгш хамтрагчид байхаас хол байлгадаг ямар хандлага буюу ёс заншлууд байдаг вэ? Иймэрхүү сорилтуудыг давахын тулд эхнэр нөхрүүд юу хийж чадах вэ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Боид К.Пакер заахдаа:

“Энэ нь эмэгтэй хүн өөрөө ганцаар нөхөр, хүүгийнхээ санваарын үүрэгт үйлчилнэ гэсэн үг биш. Тэр мэдээж тэднийг дэмжиж, тэтгэж мөн хүчирхэгжүүлдэг.

“Санваарыг атгагчид хариуд нь өөрсдийгөө эхнэр болон ээжийнхээ хэрэгцээ хийгээд үүрэг хариуцлагуудад нийцүүлэх ёстой. Түүний биеийн, сэтгэл санааны, оюун ухааны болон соёлын сайн сайхан байдал мөн түүний сүнсний өсөлт [тэдний] санваарын үүргүүдийн эхэнд байх ёстой.

“Хэдийгээр нялх хүүхэд асрах, хүүхдүүдээ хооллож ундлах, эсвэл гэр орны амь зуулгын асуудалтай холбоотой даалгавар байхгүй ч тэр нь [нөхрийн] эрх тэгш үүрэг биш юм” гэжээ (“A Tribute to Women,” *Ensign*, 1989 оны 7 сар, 75).

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Ж.Скот санваар атгагчдад зөвлөхдөө: “Нөхөр болон зохистой санваартны хувьд та санваарыг нь атган байдаг Аврагчийн жишээг дагахыг хүснэ. Та өөрийгөө амьдралынхаа анхаарах зүйл болох эхнэр хүүхдүүддээ зориулах болно. Заримдаа эр хүн гэр бүлийнхээ гишүүн бүрийн хувь заяаг хянахыг хичээдэг. Тэр бүх шийдвэрүүдийг гаргадаг. Эхнэр нь түүний хувийн сонирхолд захирагддаг. Тэр нь ёс заншил ч, чухал бус зүйл ч биш. Энэ бол Их Эзэний арга зам биш. Энэ нь Хожмын Үеийн Гэгээнтэн нөхрийн эхнэр хийгээд гэр бүлдээ хандах арга биш” гэжээ (Conference Report, 1999 оны 4 сар, 32; *Ensign*, 1999 оны 5 сар, 26).

- Бие биенээ эрх тэгш хамтрагчдын адил үнэлэхдээ эхнэр нөхрүүдийн хийдэг зарим зүйл юу вэ? (Оролцогчдын хариултуудыг нэгтгэн дүгнэж, самбарт бичихээр төлөвлө. Хэрэгтэй бол дор жагсаасан санаануудыг хуваалцаад, оролцогчдыг тэдгээр санаануудтай холбоотой туршлагаадаа хуваалцахыг урь.)
 - а. Тэд гэр бүлээрээ хамтдаа залбирах, гэр бүлийн үдшийг хөтлөх болон хамтдаа судраас суралцах үүрэг хариуцлагаа хуваалцдаг.
 - б. Тэд гэр бүлийн санхүү хэрхэн ашиглагдахыг төлөвлөхдөө хамтран ажилладаг.
 - в. Тэд хамтдаа зөвлөн гэр орны дүрмүүд хийгээд хүүхдүүдээ хэрхэн сахилгажуулах тал дээр зөвшилцөлд хүрдэг. Хүүхдүүд нь эцэг эхээ иймэрхүү шийдвэрүүдэд нэгдмэл байгааг хардаг.

- г. Тэд хамтдаа гэр бүлийн үйл ажиллагануудыг төлөвлөдөг.
- д. Тэд хоёулаа гэр орны ажлын үүрэг хариуцлагад тусалдаг.
- е. Тэд сүмд хамтдаа явдаг.

Эхнэр нөхрүүд нь хувийн шинж чанар хийгээд чадвараараа нэг нэгийгээ нөхөн дэмжиж байх хэрэгтэй

Оролцогчидтой 1 Коринт 11:11-ийг унш. Тэгээд Ахлагч Ричард Ж.Скотын дараах мэдэгдлийг хуваалц:

“Их Эзэний төлөвлөгөөнд эрэгтэй хүн, эмэгтэй хүн хоёрыг аваад нэг бүхэл болгожээ. . . . Амьдрал дахь агуу их аз жаргал болон бүтээлтэнд эхнэр нөхөр хоёулаа хэрэгтэй байв. Тэдний хүчин чармайлт нэгдэж, бас өсөн нэмэгдэнэ. Тус бүрдээ эрэгтэй хүн буюу эмэгтэй хүний хувьд Их Эзэний тодорхойлсон үүрэгт хамгийн сайн тохирох хувийн шинж чанаруудтай байдаг. Их Эзэний төлөө зориулснаар эдгээр чадварууд нь гэрлэсэн хосуудад сорилтуудтай хамтдаа тулж, давж туулахад, хайранд өсч, ойлгох болон ариун сүмийн ёслолуудаар дамжуулан хамтдаа нэг юм шиг бүхэл болохыг нэг мэт бодож, үйлдэж мөн баясахыг зөвшөөрдөг. Тэр бол төлөвлөгөө юм” (Conference Report, 1996 оны 10 сар, 101; *Ensign*, 1996 оны 11 сар, 73–74).

Ахлагч Скотын заасан зарчмыг үзүүлэхийн тулд дараах дасгалыг ажиллуул:

Оролцогч бүрт хуудас цаас, үзэг, эсвэл харандаа өг. Гэрлэсэн оролцогч бүрийг өөрийн зарим нэг зан чанарууд болон чадваруудаа мөн ханийхаа зарим нэг зан чанарууд болон чадваруудыг жагсаан бичихийг хүс. Ганц бие оролцогч бүрийг ямар нэгэн гэрлэсэн хосын тухай бодоод тэр эхнэр нөхрийн зарим нэг зан чанарууд болон чадваруудыг жагсаан бичихийг хүс. Оролцогчдыг хэдэн минут бичсэний дараа дараах асуултуудыг асуу:

- Таны жагсаасан зан чанарууд болон чадварууд гэрлэсэн хосуудыг нэгдмэл байхад ямар арга замуудаар тусалдаг вэ? (Оролцогчдыг тодорхой жишээ хуваалцахыг хүс.)
- Эхнэр нөхрүүдийн ялгаатай байдал нь ямар арга замуудаар тэдний нөхөрлөлийг хүчтэй болгогчийг та нар мэдэх вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн эхнэр Маржориа П.Хинкли Эгч гэрлэлтийнхээ анхны жилийн тухай хэлсэн дараах мэдэгдлийг унш:

“Бид бие биенээ хайрлаж байсан нь эргэлзээгүй ч, бие биенээ таньж мэдэх хэрэгтэй байв. Хос бүр бие биенээ таньж мэдэх хэрэгтэй болдог гэж би боддог. Бид бие биенээ өөрчлөхийг байнга хичээхээсээ илүү бие биенээ таньж мэдэхэд чармайн ажиллавал дээр гэдгийг би эрт мэдсэн” (*Church News*, 1998 оны 9 сарын 26, 4).

- Хосууд “бие биенээ өөрчлөхийг байнга хичээхээсээ” илүү “бие биеэ таньж мэдэхийг” хичээсний үр дүн нь ямар ялгаатай байх вэ?

Эхнэр нөхрүүд бие биендээ үнэнч байх ёстой

Сүмийн 15 дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Хинклийн дээрх зөвлөгөөг хуваалц:

“Та нарын гэрлэлтийг таслах юу ч та нарын хооронд хэзээ ч байхгүй байх болно гэдгийг тодорхойл. Үүнийг хэрэгжүүл. Үүнийг хэрэгжүүлэхээр шийд.

Зүрх шархалсан, заримдаа амьдрал сүйрсэн салалт хэт их байдаг. Бие биедээ чин үнэнч бай” (“Life’s Obligations,” *Ensign*, 1999 оны 2 сар, 2, 4).

- Үнэнч байна гэдэг нь та нарын хувьд юу гэсэн үг вэ? (Хариултууд нь итгэлтэй байх, үнэнч байх, мөн харьцаандаа итгэл хүлээсэн байх зэрэг нь багтаж болно.)

Их Эзэн эхнэр нөхрүүдийн бие биедээ үнэнч байх хэрэгцээний талаар онцгойлон хэлснийг тайлбарла. Сургаал ба Гэрээ 42:22–ыг оролцогчидтой хамт унш. Энэ зарлиг эхнэр, нөхрүүдэд тэгш үйлчилнэ гэдгийг онцлон хэл.

- Өөр хэнд ч бус харин нөхөр, эсвэл эхнэртээ үнэнч байна гэдэг нь ямар утга агуулгатай вэ?

Сүмийн 12 дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл заахдаа: “Өөр хэнд ч бус гэдэг үгс нь хүн бүрийг мөн бүх зүйлийг хасч байгаа юм. Хань ижил дараа нь нөхөр, эсвэл эхнэрийн амьдралд бусдаас илүү болдог, нийгмийн амьдралд ч, мэргэжлийн амьдралд ч, улс төрийн амьдралд ч, эсвэл аливаа хүний ямар ч зүйл, бусад ямар ч сонирхол хамтрагч хань ижлээс давуу бус юм” (*Faith Precedes the Miracle* [1972], 143).

- Хүн хань ижилдээ үнэнч байхад садаа болохгүйгээр нийгмийн, мэргэжлийн болон Сүмийн амлалтуудаа хэрхэн биелүүлэх вэ?
- Хосууд бие биедээ үнэнч байгаагаа харуулж болох ямар тодорхой арга замууд байдаг вэ? (Хэрэв оролцогчдод энэ асуултад хариулахад бэрхшээлтэй байгаа бол доор жагсаасантай адил цөөн хэдэн жишээ хуваалц.)
 - а. Нөхөр нь эхнэрийнхээ төрсөн өдрийг тэмдэглэхийн тулд ажил, амралт буюу бусад уулзалтуудаа дахин төлөвлөх болно.
 - б. Эхнэр нь нөхрийнхөө үйл ажиллагаануудад амжилт хүсэн өдөр тутам залбирч болно.
 - в. Тэд бие биенээ хэрэггүй байсан ч гэсэн сонсож болно.
 - г. Тэд гэр бүлийн гишүүд болон найзуудтайгаа ярих харилцан яриандаа бие биенийхээ талаар хайрлангуй бөгөөд хүндэтгэлтэйгээр ярьж болно.

Дүгнэлт

Их Эзэн болон Түүний бошиглогчид эхнэр, нөхрүүдийг хайранд нэгдэн тэгш эрхт түншийн адилаар хамтран ажиллахыг зарлиглажээ. Эхнэр, нөхрүүд үнэнч сэтгэлээ бие биедээ өдөр бүр өөрсдийн бодол санаа, үгс болон үйл хэргээр харуулж болно.

Сүнсээр өдөөгдсөн үедээ хичээлийн турш ярилцсан үнэнүүдийн талаар гэрчил.

Гэрлэлт ба Гэр бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага дахь хуудсууд 8–11–ийг үз. Оролцогчдыг (1) “Хэрэгжүүлэхэд Зориулсан Санаанууд” дахь зөвлөгөөнүүдээс доод тал нь нэгийг дагаж, (2) Ахлагч Хенри Б.Айрингийн “Бид Нэг Байж Болох Тул” гэсэн өгүүллийг уншиж энэ хичээл дэх сургаалууд болон зарчмуудыг хянаж үзэхийг урамшуулан дэмж. Гэрлэсэн хосууд судлах гарын авлага дахь өгүүлүүдийг хамтдаа уншиж, ярилцсанаар их ашиг тус олно гэдгийг анхааруулан хэл.

Дараагийн хичээлдээ зориулан ангиддаа судлах гарын авлагуудаа авчрахыг оролцогчдод сануул.

ГЭРЛЭЛТЭД ХАЙР ХИЙГЭЭД НӨХӨРЛӨЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

Зорилго

Оролцогчдод хайрын зарчмыг илүү сайн ойлгоход нь тусалж, гэрлэлтэд хайрыг хөгжүүлэхийн тулд гэрлэсэн хүмүүсийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. “Багшийн Хувьд Таны Үүрэг” (энэ гарын авлага дахь хуудсууд х–хiii) гэсэн гарчиг дор буй зарчмуудыг хэрэгжүүлж болох арга замуудын талаар бод.
 2. Хичээлийн тодоор бичсэн гарчгуудад тоймлосон сургаалууд болон зарчмуудын талаар тунгаан бод. Долоо хоногийн турш эдгээр сургаал болон зарчмыг заах арга замуудын талаар бод. Оролцогчдын хэрэгцээнд тохируулахын тулд юуг онцгойлон хэлэхийг шийдэхдээ Сүнсний удирдамжийг эрэлхийл.
 3. Хэрэв дараах зүйлс байдаг бол тэдгээрийг хичээлийн хэсэг болгон ашиглахаар бэлтгэ:
 - а. Нэг буюу түүнээс олон хуримын зургууд. Жишээ нь: Ариун Сүм рүү Орж Буй Залуу Хос (62559; Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 609)–ын зургийг үзүүлж, эсвэл өөрийнхөө хуримын зургийг авчирч мөн оролцогчдоос өөрсдийнхөө хуримын зургуудыг авчир хэмээн та хүсч болох юм.
 - б. Цэцэг, эсвэл цэцэгний зураг.
-

Энэ хичээлийг заах зөвлөмж

Эхнэр, нөхрүүд бие биенээ хайрлах хайраа хөгжүүлж байх ёстой

Хуримын нэг, эсвэл хэд хэдэн зураг үзүүл (“Бэлтгэл,” зүйл 3а-г үз). Эхнэр, нөхрүүд анх гэрлээд мэдэрдэг бие биенээ хайрлах хайрын талаар тайлбарла.

Цэцэг, эсвэл цэцэгний зураг харуул (“Бэлтгэл,” зүйл 3б–г үз). Дараа нь нэг оролцогчоор Сүмийн 12 дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалпын дараах мэдэгдлийг уншуул (*Гэрлэлт ба Гэр бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага* х. 14):

“Хайр бол цэцэг шиг мөн бие махбодийн адил, тогтмол тордогдох хэрэгтэй байдаг. Мөнх бус бие махбодь нь хэрэв байнга тэжээгдэхгүй байсан бол удахгүй турж эцэн, үхэх байсан. Уяхан эмзэг цэцэг тэжээл, усгүй байсан бол хатаад үхчих байсан. Хайр ч гэсэн хайрын хэсэг, бишрэл хүндэтгэлийн тунхаглал, талархлын илэрхийлэл хийгээд аминч бус байдлын анхаарал халамжаар байнга тэтгэн тэжээгдэхгүй бол мөнхөд үргэлжилнэ гэж бодох боломжгүй гэсэн үг” (“Oneness in Marriage,” *Ensign*, 1977 оны 3-р сар, 5).

Энэ хичээл нь эхнэр, нөхрүүд бие биенээ хайрлах хайраа хэрхэн тордож чадах, ингэснээр хайр нь улам нэмэгдэх тухай гэдгийг тайлбарла.

Хайрын нөлөө, нинжин сэтгэлийн илрэл нь гэрлэлтэд хайр болон нөхөрсөг байдлыг үгүй болгохгүйгээр хадгалдаг.

Гэрлэсэн оролцогчдоос шинэхэн гэрлэсэн хүмүүс байх үеийнхээ тухай бодохыг хүс. Тэднийг амьдралдаа тухайн үед хань ижлийнхээ төлөө хийж байсан зарим зүйлийнхээ талаар ярихыг урь.

- Ийм үйлдлүүд яагаад гэрлэлтийн бүх явцад хэрэгтэй вэ?

Эхнэр, нөхрүүд амьдралынхаа турш бие биентэйгээ үргэлжлүүлэн болзож, нөхөрлөлөө тордох ёстойг тайлбарла. Тэд үүнийг хийснээр бие биенээ гэсэн хайр нь илүү хүчтэй болж байгааг олж мэднэ.

Далын Ахлагч Марлин К.Женсен сануулахдаа: “Нөхөрлөл бол . . . болзоо болон гэрлэлтийн амин чухал бөгөөд гайхамшигтай хэсэг юм. Эрэгтэй, эмэгтэй хүний хоорондох харилцаа нөхөрлөлөөр эхэлж, дараа нь романтик болж, аажмаар гэрлэлт нь гол төлөв үргэлжлэн мөнхийн нөхөрлөл болж хувирдаг. Өнөөгийн амархан үгүй болж байгаа гэрлэлтүүд дунд хамтдаа зуурдын байдлын зовлон бэрхшээл, адислалуудыг амсаж, жилээс жилд бие биенээ үнэлж, бие биендээ таалагдаж байгаа эхнэр, нөхрийг ажиглахаас илүү урамтай зүйл гэж үгүй” гэжээ (Conference Report, 1999 оны Дөрөвдүгээр сар, 81; *Ensign*, 1999 оны Тавдугаар сар, 64).

Ахлагч Жеймс Е.Фауст Далд үйлчилж байхдаа, гэр бүл салалтын нэн үл ажиглагдам мөртлөө хамгийн ихэд дэлгэрсэн шалтгаануудын нэг бол, “гэрлэлтэд байнгын баяжуулалт дутагддаг, гэрлэлт уйтгартай, хүнд хэцүү, бараан баргар болоход үүнийг үнэ цэнэтэй, өвөрмөц тусгай хийгээд гайхамшигтай болгох ямар нэгэн нэмэлт зүйл үгүйлэгддэг” хэмээн хэлсэн байдаг. “Гэрлэлтийг баяжуулахад, ялигүй жижигхэн мэт санагддаг зүйлүүд хэрэг дээрээ том зүйлүүд болдог. Энэ бол бие биендээ байнга талархал илэрхийлж, харилцан бие биеэ хүндэтгэж байх явдал юм. Энэ бол өсч хөгжихөд нь бие биендээ туслах явдал мөн. Гэрлэлт бол сайн сайхан, эрхэм дээд хийгээд бурханлиг чанарын нэгдэл юм” гэж тэрээр зөвлөжээ (Conference Report, 1977 оны 10-р сар, 13–14; *Ensign*, 1977 оны 11-р сар, 10–11).

- Хайр болоод нөхөрлөлийг гэрлэлтэд амьд болгодог зарим ямар “ялигүй жижигхэн” зүйлүүд байдаг вэ? (Оролцогчдын хариултуудыг самбар дээр жагсаан бичихэд анхаар.) Эдгээр арга замуудаар хайрыг өсгөн нэмэгдүүлэхийн ач холбогдлыг харуулдаг ямар туршлагауд хийгээд арга замуудыг та нар хуваалцаж чадах вэ?

Гэрлээд 35 гаруй жил болж байгаа нэгэн эмэгтэй хэлэхдээ: “Нөхөр маань нэг орой юм уу, долоо хоногийн амралтаар яваад ирэхдээ надад ялигүй жижиг ч гэсэн бэлэг авчирдагт би дуртай. Энэ нь том юм байх шаардлагагүй, ердөө л тэрээр цуглаанаас хэмнэсэн нэг жигнэмэг ч юм уу, эсвэл цэцэг байж болно. Нөхөр минь үд дундын үед ажил дээрээсээ утасдаж, тэр өдөр миний хувьд ямархуу өнгөрч байгааг асуух буюу эсвэл ямар нэг сэтгэл хөдөлгөм сонин мэдээ хуваалцахад би бүр ч дуртай” гэжээ.

Нөхөр эхнэрүүд зөвхөн хоёулахнаа хамтдаа байх цагийг төлөвлөх хэрэгтэйг онцгойлон хэл. Далын Ахлагч Жөү Ж.Кристенсенний дараах зөвлөгөөг оролцогчдоор уншуул (*Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага*):

“Анхаарал халамжаа амьд байлга. Юмсыг зөвхөн хоёулахнаа хамтдаа хийх цаг гарга. Гэр бүлээрээ хүүхдүүдтэйгээ хамт байх нь чухлын нэгэн адил, та нар ч бас ажлын өдрийн тогтмол цагуудаар хамтдаа байх хэрэгтэй. Үүнийг цагийн хуваарьт төлөвлөх нь та нарын гэрлэлт анхаарал халамжийг чинь байнга шаардахаар тийм чухал юм байна гэдгийг хүүхдүүддээ мэдэгдэх боломжийг олгох болно. Энэ нь амлалт, төлөвлөлт хийгээд цагийн хуваарь гаргахыг шаарддаг” (Conference Report, 1995 оны 4-р сар, 86; *Ensign*, 1995 оны 5-р сар, 65).

- Эхнэр нөхрүүд хамтдаа юм хийж өнгөрөөх ямар арга зам байж болох вэ? Гэрлэсэн хосууд бие биенээ хайрлаж, халамжлахыг хэрхэн байнгын болгож болох вэ?

Гэрлэлт дэх зохих ёсны ойр дотно байдал бол хайрын илрэл мөн

Гэрлэлт дэх янаг хайрын зохих ёсны илэрхийллийг Их Эзэн сайшаадгийг тайлбарла. Энэ нь гэрлэсэн хосуудад агуу адислалуудыг авчирч, санаа сэтгэлээ нэгтгэж, бие биенээ хайрлах хайрыг бэхжүүлэхэд нь тэдэнд тусалдаг. Дараах мэдэглүүдийг бүгдийг нь буюу заримыг нь хуваалцахад анхаар:

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г.Скотт гэрлэлт дэх амраг хайрын зорилгыг тайлбарлахдаа: “Гэрлэлтийн удаан үргэлжлэх гэрээний хүрээнд Их Эзэн Өөрийнхөө тогтоосон тэдний бүхий л хайр хийгээд эрхэм сайхан чанар дахь нөхөн үржихүйн ариун нандин хүчний илэрхийллийг нөхөр эхнэр хоёрт зөвшөөрдөг билээ. Энэхүү хувийн, ариун нандин, элэгсэг дотно туршлага бол Тэнгэр дэх Эцэг тэдэнд мөнх бус байдлын туршлагыг хүсдэг сүнснүүдийг бие махбодиор хангадаг билээ. Хайрын эдгээр хүчирхэг хийгээд ариун нандин мэдрэмжүүдийн өөр нэг шалтгаан бол эхнэр нөхөр хоёрыг чин үнэнч хайранд, бие биенээ хүндлэн дээдлэх хийгээд адил нийтлэг зорилгод холбон нэгтгэдэг (Conference Report, 1994 оны 10-р сар, 50; *Ensign*, 1994 оны 11-р сар, 38).

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс заахдаа: “Мөнх бус амьдралыг бүтээх хүч бол Бурханаас өөрийн хүүхдүүдэд соёрхсон хамгийн өргөмжит хүч юм. Энэ хүчийг ашиглах нь [Адам Ева хоёрт өгөгдсөн] анхны зарлигт тусгалаа олсон юм, гэвч өөр нэг зарлиг үүнийг буруу ашиглахыг хориглохын тулд өгөгдсөн юм. Ариун явдлын хуулинд бид онцгой анхаарал хандуулдаг нь Бурханы төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бидний нөхөн үржихүйн хүчний зорилгыг ойлгох бидний ойлголтоор тайлбарлагддаг. Бидний нөхөн үржихүйн хүчний илэрхийлэл нь Бурханыг баярлуулахын төлөө байдаг ч гэсэн, энэ нь гэрлэлтийн харилцааны хүрээнд хязгаарлагдах ёстойг тэрээр зарлиглажээ.” (Conference Report, 1993 оны 10-р сар, 99; *Ensign*, 1993 оны 11-р сар, 74).

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл заахдаа: “Хууль ёсны гэрлэлтийн хүрээнд ээлгийн харилцааны янаглал нь зөв бөгөөд бурханлигаар сайшаагддаг

билээ. Бэлгийн харилцаанд өөрт нь ямар нэгэн ариун бус, дорд муухай зүйл байхгүй, учир нь энэхүү арга хэрэгслээр эрэгтэй, эмэгтэй хүмүүс хамтдаа бүтээлтийн үйл явцад нэгдэн нийлж, түүнчлэн хайр дурлалаа илэрхийлдэг” гэжээ(*The Teachings of Spencer W. Kimball*, хянан тохиолдуулсан Эдвард Л.Кимбалл [1982], 311).

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жефффри Р.Холланд заахдаа: “Хүмүүний янаглал гэрлэсэн хосуудад заяагдсан юм, учир нь энэ нь Бурханы томилж, хязгаарыг нь тогтоосон бүрмөсөн нэгдэн нийлэлтийн төгс бэлэгдэл хийгээд төгс дээд хэлбэр юм. Еденийн Цэцэрлэгээс хойш гэрлэлт нь эрэгтэй, эмэгтэй хүн хоёр—зүрх сэтгэлээрээ, найдвараараа, амьдралаараа, хайр дурлалаараа, гэр бүл, ирээдүй, юм юмаараа төгс нэгдэн нийлэлт байхаар заяагдсан ажээ. Ева түүний яснаас, мөн түүний махнаас хийгдсэнийг Адам хэлсэн байдаг, ингэснээр тэд амьдралдаа хамтран “нэг бие махбодь” болжээ [Эхлэл 2:23–24-ийг үз]. Энэ бол *лацдан холбох* хэмээн бидний ашигладаг үгний мөнхийн амлалтыг илэрхийлсэн ийм төгс байдлын нэгдэл юм. Бид энэхүү ариун нандин холбоог бие биендээ гагнагдан холбогдох явдал гэж үзэж болно хэмээн Бошиглогч Иосеф Смит нэг удаа хэлжээ [С ба Г 128:18-ыг үз]” (Conference Report, 1998 оны 10-р сар, 100; *Ensign*, 1998 оны 11-р сар, 76).

Сүмийн 14 дэх Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Ховард В.Хантер, бүр гэрлэлтийн хүрээнд ч энэхүү нөхөн үржихүйн ариун нандин хүчийг буруу ашиглах ёсгүйг зөвлөхдөө: “Энхрий ялдам хайр хийгээд хүндэтгэл—хэзээ ч амин хувиа хичээхгүй байх нь эхнэр, нөхөр хоёрын хоорондын дотнын харилцаанд удирдлага болгох зарчим байх ёстой. Гэр бүлийн хос бүр нөгөөгийнхөө хүсэл бодол, хэрэгцээнд анхааралтай соргог, мэдрэмтгий байх ёстой. Аливаа байдлаар давамгайлах, ёс жудаггүй байх буюу нөхөр, эхнэр хоёрын хоорондын ойр дотнын харилцаанд зан төрхөө хянахгүй байх нь Их Эзэнээр буруутгагддаг” гэжээ (Conference Report, 1994 оны 10-р сар, 68; *Ensign*, 1994 оны 11-р сар, 51).

Египетээс Гарсан нь 20:14, 17-г оролцогчдын хамт унш. Дараа нь Сүмийн 15 дахь Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн дараах мэдэглийг хуваалц:

“Гэрлэлтийн өмнөх ариун явдал хийгээд гэрлэлтийн дараах үнэнч байдалд бид итгэдэг. Энэ бол гэрлэлтийн гол амин сүнс мөн. Энэ бол амьдрал дахь аз жаргалд хүрэх зам мөн. Энэ бол сэтгэл ханамжид хүрэх зам мөн. Энэ нь зүрх сэтгэлд амар амгаланг, гэр оронд амар амгаланг авчирдаг” (Conference Report, 1996 оны 10-р сар, 68; *Ensign*, 1996 оны 11-р сар, 49).

Үнэнч биш байдалд дөхөж очих аливаа зүйлийг эхнэр, нөхрүүд хийхгүй байхад туйлын анхааралтай байх ёстой. Жишээ нь, тэд өөрсдийнхөө хоорондох хийгээд эсрэг хүйсийн хамт ажиллагсдынхаа хоорондын сэтгэл хөдлөлийн хийгээд бие махбодийн харилцаанд зохих ёсны зааг хязгаарыг ямагт баримталж байх ёстой.

- Гэрлэлтэд төгс үнэнч чанар яагаад амин чухал ач холбогдолтой вэ?

- Цэвэр ариун биш буюу порнографийн материалыг үзэх нь хэрхэн гэрлэлт дэх итгэлцлийг эвддэг вэ? Эсрэг хүйсийн хүнтэй сээтэгнэх нь гэрлэлтэд ямар байдлуудаар хор хохирол учруулдаг вэ?

Дараах мэдэглүүдийн нэгийг, эсвэл хоёуланг нь хуваалц:

“Бодол санаа, үг яриа хийгээд үйл хэрэгтээ гэрлэлтийнхээ гэрээнүүдэд үнэнч итгэлтэй байгтун. Порнографи, сээтэгнэл хийгээд цэвэр ариун бус дэвэргэн санаа хүний зан чанарыг эвдэж, аз жаргалтай гэрлэлтийн үндэс суурийг ганхуулдаг. Ийнхүү гэрлэлтийн хүрээн дэх эв нэгдэл хийгээд итгэл бусниулагддаг” хэмээн Ерөнхийлөгч Ховард В.Хантер зөвлөжээ (Conference Report, 1994 оны 10-р сар, 67; *Ensign*, 1994 оны 11-р сар, 50).

Сүмийн 13 дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон зөвлөхдөө: “*Хэрэв та гэрлэсэн бол аливаа сээтэгнэлээс зайлсхий. . . .* Гэм хоргүй тоглоом шоглоом буюу эсвэл эсрэг хүйсийн хэн нэгэнтэй бяцхан наргиан хийх нь ч гэсэн илүү ноцтой байдалд, улмаар эцэст нь итгэл эвдэхэд зайлшгүй хүргэж болно. Намайг үүнийг хийснийг эхнэр буюу нөхөр маань мэдвэл баяртай байх уу? Нөхөр нь нарийн бичгийн даргатайгаа хоёулахнаа үдийн хоол иддэг байвал эхнэр маань баяртай байх уу гэдгийг өөрсдөөсөө асууж байх нь сайн асуулт юм. Эхнэр нь өөр эр хүнтэй сээтэгнэж байхыг харсан нөхөр баяртай байх уу? Хайрт, ах эгч нар минь, энэ бол “Бузар муугийн аливаа хэлбэрийг цээрлэгтүн” гэж Паулын хэлсэн үгний утга учир мөн (1 Тесалоник 5:22)” (“The Law of Chastity,” *Бригам Янгийн Их Сургууль, 1987–88 Devotional and Fireside Speeches* [1988], 52).

Гэрлэсэн хосууд энэрэл, Христийн цэвэр хайрыг өөрсдөдөө байлгахын төлөө хичээн чармайх хэрэгтэй.

- Иохан 13:34–35 болон Ефес 5:25-ыг оролцогчидтой хамт унш. Эхнэр, нөхрүүд бие биендээ хэрхэн хандах талаар эдгээр хэсгүүд юу зааж байна вэ?

Гэрлэсэн хосуудын бие махбодийн харилцаа чухал ч гэсэн, энэ нь тэдний хайр дурлалын хамгийн чухал тал биш гэдгийг онцгойлон хэл. Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын дараах мэдэгдлийг хуваалц:

“[Гэрлэлт дэх хайр] бол гүн гүнзгий, багтаамж ихтэй, тал бүрийн шинжтэй байдаг. Энэ бол хайрыг гол төлөв бие махбодийн дур таашаал гэж үзэн, буруугаар нэрлэсэн дэлхийн ойлголттой адилгүй юм. Гэрлэлт зөвхөн үүн дээр үндэслэгдсэн үед, хосууд удалгүй бие биенээсээ уйдаж эхэлдэг. . . . Их Эзэний өгүүлдэг хайр бол зөвхөн бие махбодийн дур таашаал биш, бас түүнчлэн сүнсний хүсэл таашаал юм. Энэ бол итгэл хийгээд итгэл найдвар, бие биенээ ойлгох явдал мөн. Энэ бол төгс хосоор амьдрах амьдрал юм. Энэ бол адил нийтлэг туйлын зорилго хийгээд жишгүүд дээр тулгуурласан хамтын амьдрал юм. Энэ бол бие биенийхээ төлөө хийх хувиа хичээсэн бус золиослол юм. Энэ бол бодол санаа хийгээд үйл ажиллагааны цэвэр ариун байдал, түүнчлэн Бурханд болон түүний хөтөлбөрт итгэх итгэл юм. Энэ бол бурханлиг чанар хийгээд бүтээлтийн хүсэн хүлээлт болсон мөнх бус байдал дахь эцэг эх болох ёс, сүнсний эцэг эх болох ёс юм. Энэ бол өргөн цар хүрээтэй, бүх талыг хамарсан, хязгааргүй зүйл. Ийм хайр хэзээ ч цуцдаггүй

бөгөөд багасдаггүй. Ийм хайр өвчин зовлон, уй гашууг даван туулдаг, цэцэглэл хөгжилт хийгээд зовлон зүдгүүр, амжилт хийгээд цөхрөлийг тэсэн гарч, амьдрал хийгээд үүрд мөнхөд оршдог” (*Faith Precedes the Miracle* [1972], 130–31).

Ерөнхийлөгч Кимбаллын ярьсан хайр бол энэрэл, Христийн цэвэр хайр гэдгийг тайлбарла. Моронай 7:45–48-ыг оролцогчидтой хамт унш. Тэднийг унших үед энэрлийн тодорхойлолтуудыг гаргахыг оролцогчдоос хүс. Эдгээр шинж чанаруудыг доор харуулснаар самбарт бич:

Энэрэл:

Тэвчээртэй.
Элдэг сайхан.
Атаархдаггүй.
Бардамнадаггүй.
Амин хувиа хичээдэггүй.
Амархан өдөөн хатгагддаггүй.
Хилэнцэгийг боддоггүй.
Алдаст баясдаггүй, харин үнэнд баясдаг.
Бүх зүйлийг үүрдэг.
Бүх зүйлд итгэдэг.
Бүх зүйлд найддаг.
Бүх зүйлийг тэвчдэг.
Хэзээ ч дуусдаггүй.
Бүхнээс хамгийн агуу.
Христийн цэвэр хайр мөн.
Үүрд мөнхөд тэвчдэг.

Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ ийм хайраар тэдэнд ханддаг гэдэгт шийдвэр төгс байх, гэрлэлтэд—ялангуяа мөнхийн гэрлэлтэд шийдвэр төгс байхаас илүү тийм чухал шийдвэр төгс байдал бидэнд байдаггүйг онцгойлон хэл. Эхнэр, нөхрүүд бие биендээ хандсан энэрлийг хөгжүүлэхийн төлөө байнга ажиллах ёстой.

Энэ зарчмыг хэрэглэн оролцогчдод туслахын тулд самбар дээр өөрийнхөө бичсэн энэрлийн тодорхойлолтуудад тэдний анхаарлыг хандуул. “Амин хувиа хичээдэггүй,” эсвэл “Хэзээ ч дуусдаггүй” гэх мэтийн, гэрлэлтийн харилцаанд илэрч болдог зарим тодорхойлолтуудыг ярилцах үед тэднийг эдгээр тодорхойлолтуудын заримыг нь үзсэн жишээнээсээ хуваалцахыг хүс.

Дүгнэлт

Эхнэр, нөхрүүд өөрсдийн хайр, нөхөрлөлийг тэтгэн тордох ёстойг онцлон хэл. Хайр талархал хийгээд элдэг ялдамхан занг илтгэн харуулдаг жижиг зүйлүүдийг байнга хийснээр тэд хайраа гандаалгүй хэвээр үргэлжлүүлэх хэрэгтэй. Тэд амьдралын баяр хөөрийг ч, ачаа дарамтыг ч хамтдаа хуваалцаж, бие биенийхээ сүнсний, бие махбодийн хийгээд сэтгэл хөдлөлийн хэрэгцээнд мэдрэмтгий байх учиртай. Тэд гэрлэлтийн харилцаанд амин чухал зүйл болох хайрыг бусниулдаг аливаа зүйлийг хэзээ ч хийх ёсгүй. Мөн тэд “зүрх сэтгэлийнхээ бүхий л эрч хүчээр Эцэгт хандан залбирах

ёстой, ингэснээр тэд [энэрлээр] дүүрч болно” (Моронай 7:48). Гэр бүлийн хосуудын хувьд бие биенийхээ итгэлийг байнга даасан үед, бие биенээ хайрлах тэдний хайр он жил улиран өнгөрөх тутам өсөн нэмэгдэх болно. Тэд үнэхээр Христийнх шиг хайр хөгжүүлж байгаагаа мэдэх болно.

Гэрлэлт ба Гэр бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын хуудас 12–15-ыг үз. (1) “Хэрэгжүүлэх Санаанууд” дахь зөвлөмжүүдээс доод тал нь нэгийг баримталж, (2) Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын “Гэрлэлт дэх Нэгдмэл байдал” өгүүллийг унших замаар энэ хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудыг нэгтгэн дүгнэхэд нь оролцогчдыг урамшуул. Гэрлэсэн хосууд суралцах удирдамж дахь өгүүллүүдийг хамтдаа уншиж, ярилцсанаас үлэмж их ашиг тус олж болно гэдгийг онцлон хэл.

ГЭРЛЭЛТ ДЭХ БЭРХШЭЭЛҮҮДЭД ХАНДАХ ХАНДЛАГА

Хичээл

4

Зорилго	Нөхөр эхнэрүүд бэрхшээлүүдийг хамтдаа даван туулж, сэтгэл санаагаар унах буюу уурлаж уцаарлахаас илүүтэйгээр тэвчээрээр хариулахаар сонгож сурахад нь оролцогчдод туслах.
----------------	---

Бэлтгэл	<ol style="list-style-type: none">1 “Багшийн Хувьд Таны Үүрэг Хариуцлагууд ”дахь (энэ гарын авлагын хуудас х–хiii) зарчмуудыг нэгтгэн дүгнэ. Заахад бэлтгэхдээ эдгээр зарчмуудыг хэрэглэх арга замуудыг эрж хай.2. Хичээл дэх сургаалууд болон зарчмуудыг тоймлосон тодоор бичсэн хичээлийн гарчгуудыг унш. Бэлтгэлийнхээ нэг хэсэг болгон эдгээр сургаалууд болон зарчмуудыг долоо хоногийн турш тунгаан бодож, оролцогчдын хэрэгцээг хангахын тулд юуг онцлон хэлэхээ шийдэхэд сүнсний удирдамжийг эрэлхийл.3. Хуудас 23 дээрх судрын хэсгүүдийг судал, ингэснээр та тэдгээрийн тухай ярилцлага хөтлөн явуулахад бэлэн болно.
----------------	---

**Энэ хичээлийг
заах зөвлөмж**

Бүх гэрлэсэн хосод бэрхшээл тохиолдох болно.

Далын Ахлагч Брус К.Хафены өгүүлсэн дараах түүхийг хуваалц:

“Хуримын өдөр шинэ бэр, ‘Ээж ээ, би бүх зовлон бэрхшээлийнхээ төгсгөлд ирлээ шүү дээ!’ хэмээн баяртайгаар шүүрс алдан хэлэхэд ‘Тийм ээ,’ гэж ээж нь хариулснаа, ‘ гэвч аль төгсгөлд нь?’ гэж асуужээ (Conference Report, 1996 оны 10-р сар, 34; *Ensign*, 1996 оны 11-р сар, 26).

- Гэрлэсэн хосод тохиолдож болдог зарим бэрхшээл, хүндрэлүүд юу вэ? (Оролцогчдын хариултуудыг самбар дээр бичихээр төлөвлө. Доор жагсаасан хариултууд байж болно.)
 - а. Санал зөрөлдөөн
 - б. Аминч үзэл
 - в. Гомдол
 - г. Эрүүл мэнд муу байх
 - д. Хүүхэд төрөхгүй байх
 - е. Өтлөх
 - ё. Бие эрхтний согогтой гэр бүлийн гишүүд
 - ж. Бүх хүүхдүүд гэр орноос тусдаа амьдрах болсон үед тэднийг үгүйлэх
 - з. Хайртай хүмүүс нь өөд болох
 - и. Санхүүгийн хүндрэл бэрхшээл
 - й. Хэцүү хүүхдүүд
 - к. Байгалийн гамшиг

Зарим бэрхшээл гэрлэлтийн харилцаан дахь хүндрэлүүдийн үр дагавар болж, бусад нь амьдралын жам ёсны хэсэг болж ирдгийг анхааруулан хэл.

Хэрэв эхнэр нөхрүүд гэрлэлтийг гэрээний харилцаа хэмээн үздэг бол тэд ямар ч бэрхшээлийг даван туулж чадна.

Гэрлэсэн хосууд гэрлэлтийн харилцаагаа хэрхэн үздэгээс хамааран бэрхшээлд өөр өөр байдлаар хариулах болно гэдгийг тайлбарла. *Гэрээ, Их Эзэнтэй хийх гэрээ* гэдэг үгсийг самбар дээр бич.

Гэрээ бол хоёр хүн, эсвэл хэсэг хүмүүсийн хооронд бичгээр үйлдсэн тохиролцоо юм. Гэрээ нь тухайн улс орны хуулиар хүчин төгөлдөр байдаг. Бурхантай хийх гэрээ нь дээрх гэрээтэй төстэй боловч, илүү өргөн утгатайг тайлбарла. *Их Эзэнтэй хийх гэрээ* гэдэг үг зарим үед хүмүүс хоорондын тохиролцоог заадаг хэдий ч, сайн мэдээний тухай хам сэдэвт энэ нь Их Эзэн болон бидний хоорондох тохиролцоог заадаг. Энэ гэрээнд Их Эзэн гэрээний нөхцөлүүдийг тогтоож, бид эдгээр нөхцөлүүдийг сахихаар амладаг. Бид амлалтуудаа биелүүлсэн үед Их Эзэн Өөрийн амлалтуудыг биелүүлэх үүрэг хүлээдэг (С ба Г 82:10-ыг үз).

Өнөөдрийн нийгэмд олон хүн гэрлэлтийг гэрээнээс илүү зүйл огт биш хэмээн үздэгийг тэмдэглэн хэл. Дараах асуултуудын тухай чангаар хариулалгүйгээр бодож үзэхийг оролцогчдоос хүс:

- Гэрлэлтэд хүндрэл бэрхшээл тохиолдоход, хэрэв тэд өөрсдийн харилцааг ердийн гэрээ гэж үздэг бол эхнэр, нөхөр хоёр юу хийж болох вэ? Хэрэв тэд өөрсдийн харилцааг Их Эзэнтэй хийсэн гэрээ гэж үздэг бол тэд юу хийх вэ?

Далын Ахлагч Брус К.Хафен: “Бэрхшээл тохиолдоход, гэрээгээр гэрлэсэн талууд гэр бүл салснаар аз жаргалыг эрж хайдаг. Тэд ямар нэг ашиг тусыг бодож гэрлэдэг бөгөөд тэд тохирсон зүйлээ хүлээн авах хүртлээ л хамт үлддэг. Гэтэл *Их Эзэнтэй хийх гэрээний* гэрлэлтэд бэрхшээл тохиолдоход, нөхөр, эхнэр хоёр үүнийг шийдвэрлэхийн төлөө ажилладаг. . . . *Гэрээний* хосууд тус бүрдээ 50 %-ийн үүрэг хүлээдэг бол *Их Эзэнтэй хийсэн гэрээний* хосууд тус бүрдээ 100 %-ийн үүрэг хүлээдэг. Гэрлэлт бол мөн чанараараа хэн нэг нь хүслээрээ цуцалж болдог хувийн гэрээ биш, харин Их Эзэнтэй хийсэн гэрээ юм” гэжээ (Conference Report, 1996 оны 10-р сар, 34; *Ensign*, 1996 оны 11-р сар, 26).

Бэрхшээл бий болоход бид урам хугаралтаар, эсвэл уур уцаараас илүүтэйгээр тэвчээр хийгээд хайраар хариулахаар сонгож болно.

Нөхөр эхнэрүүд зарим нэг бэрхшээлээс зайлсхийж чадахгүй ч гэсэн, тэд бэрхшээлүүдэд хэрхэн хариулахаа сонгож чадна. Далын Ахлагч Линн Г.Роббинс тайлбарлахдаа: “Хэн ч биднийг ууртай болгодоггүй. Бусад хүмүүс биднийг уурлуулдаггүй. Үүнд оролцсон ямар ч хүч байдаггүй. Ууртай болох гэдэг нь ухамсартай сонголт бас шийдвэр юм, тиймээс бид уургүй байх сонголт хийж чадна. *Бид л сонгоно!*” гэжээ (Conference Report, 1998 оны 4-р сар, 105; *Ensign*, 1998 оны 5-р сар, 80).

Тэнгэрлэг Эцэг бидэнд сонгох эрх—өөрсдийнхөө төлөө сонгож, үйлдэх хүч өгснийг онцлон хэл. Бэрхшээл тохиолдоход тэвчээртэй, хайраар дүүрэн байхаар сонгосноор бид сонгох эрхээ хэрэгжүүлдэг.

Дараах судруудыг оролцогчдоор ээлжлэн чангаар уншуул. Тэднийг унших үед нөхөр эхнэрүүд гэрлэлтийн болон өдөр тутмын амьдралын бэрхшээлүүдэд хариулахад эдгээр судруудыг хэрэглэж болох арга замуудын талаар ярилцахыг нь урамшуулан дэмж.

Мозая 18:21

1 Иохан 4:18

1 Петр 4:8

Иохан 13:34–35

Иохан 16:33

2 Нифай 31:20

Сургаал ба Гэрээ 24:8

Алма 38:12

3 Нифай 11:29–30

Иаков 1:19–20

Мозая 3:19

• Бид урам хугарах буюу уурлаж уцаарласан үедээ, эдгээр мэдрэмжийг даван туулахын тулд юу хийж болох вэ? (Доор жагсаасан хариултууд байж болно.)

- а. Тайвшрах хүртлээ нөхцөл байдлыг өөрсдөөсөө зайлуул.
- б. Тусламж хийгээд удирдамжийн төлөө залбир.
- в. Санал зөрсөн үед, нөгөө хүнийхээ учир үндэслэл хийгээд бодол санаануудыг анхааралтай авч үзэх цаг гарга.
- г. Орон нутгийн Сүмийн удирдагчдаас, хэрэв шаардлагатай бол, үзэл бодол хийгээд дадал зуршил нь Сүмийн заадаг зүйлүүдтэй нийцдэг мэргэжлийн зөвлөхүүдээс тусламж эр.

Дараах түүхийг уншиж, нөхөр эхнэрүүд бэрхшээлүүдэд хэрхэн хариулахаар сонгож болохыг дүрсэл. Энэ бол гэрлэлтэд тохиолдож болох өдөр тутмын ялиггүй жижиг бэрхшээлийн жишээ болохыг тайлбарла.

“Энэ бол тийм өдрүүдийн нэг байлаа. Делла өдөржингөө хичнээн шуурхай ажиллаад ч гэр бүлийнхээ шаардлагатай ажлуудыг амжуулж чадсангүй. Түүнээс олон хүүхэдтэй хөрш нь их л баяр хөөртэй байдгийг Делла хараад, эмэгтэй хүн, эхнэр түүнчлэн эх хүний хувьд өөрийнхөө чадварт эргэлзэж эхэлжээ.

“Бен гэр рүүгээ ирэх замдаа илүү их өлссөн аж. Фермийн тоног төхөөрөмжийг хүргэж өгөхөд дахиад наян бээр явах хэрэгтэй байсан ч, тэрээр одоо ядарчихсан байлаа. Гэртээ харихсан гэдэг бодол бүх цаг үеийн турш салахгүй байв. Амар амгалан. Хоол унд. Амралт.

“Бений машин зам дээр дуугарахыг Делла сонсоод цаг уруу харав. Хөөе, юу вэ! Оройн долоо дөхөж байна шүү дээ? Одоо яах билээ? Тэр оройн хоолоо бэлэн болгохыг бодсон сон, гэтэл? . . .

“Тэрээр сүүлчийн жигнэмгээ хайруулын тавган дээр яаран сандран тавих үед хаалга нээгдэхийг сонсов.

“Бен хаалгаар алхаж орж ирээд, буланд хана налан зогсож, Делла уруу харан инээмсэглэв. Тэрээр сэтгэл түгшсэн байдалтай харагдаж байв, нөхөр нь хоосон ширээг ажиглалаа. Тэрээр дуугарсангүй, гүнзгий санаа алдав.”

Дараах асуултуудыг оролцогчдоос асуу:

- Хэрэв Бен зөвхөн өөртөө л санаа тавьдаг бол, юу тохиолдож болох вэ?
- Хэрэв Бен эхнэртээ санаа тавьдаг бол, тэрээр хэрхэн хандаж болох вэ?

Эдгээр асуултуудыг ярилцсаны дараа уг түүхийг үргэлжлүүл:

“Бен шүүрс алдан, Делла уруу харж инээмсэглэн, ‘Одоо л би туслах цаг болж дээ’ гэж хэлэв. Эхнэрийнх нь сэтгэлийн түгшүүр арилав. Тэр санаа нь амарч, нөхрөө үнсээд, ‘чамайг гэртээ ирэхэд яасан сайхан юм бэ, Бен. Чи өнөөдөр урт удаан ажилласан шүү дээ, тэгээд л би хоолыг чинь бэлэн болгох гэж чармайлаа!’ гэж хэлэв. Эхнэр нь хоосон ширээ рүү дохив.

“ ‘Хоёул хамтдаа дуусгачихъя л даа,’ гэж нөхөр нь хэлээд, түүний мөрөн дээр гараа тавилаа. Тэгээд тэр хоёр аль алиндаа тохиолддог өөр өөр бэрхшээлийг хуваалцаж эхэлжээ. Бен ширээ засч байх хооронд Делла жигнэмгүүдээ шарах пийшинд хийж, тэрээр өдөржингөө хэрхэн яаран сандран, санаа нь зовж байснаа нөхөртөө яриу. Бен өлссөнөө таг мартаж, эхнэрийнхээ ажлыг хэрхэн хөнгөвчлөх тухай л бодож байв” (*Family Home Evening Resource Book* [1983], 241; догол мөрийг өөрчлөв).

Дүгнэлт

Гэрлэлт ба Гэр бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын хуудас 16–17-г үз. (1) Энэ хичээл дэх “Хэрэгжүүлэх Санаануудаас” доод тал нь нэг зөвлөмжийг хэрэглэн, (2) Ахлагч Линн Г.Роббинсын “Сонголт ба Уур ” хэсэг дэх сургаалууд хийгээд зарчмуудыг нэгтгэн дүгнэхэд оролцогчдыг урамшуул. Судлах удирдамж дахь өгүүлүүдийг уншсанаар гэрлэсэн хосууд их ашиг тус олж болно гэдгийг онцлон хэл.

Нэмэлт Эх Сурвалж Материал

Нөхөр, эсвэл эхнэртэйгээ зүй бус харьцах нь Бурханыг гомдоодог

Нөхөр, эхнэрүүд уур уцаартай буюу сэтгэл санаа хямарсан үед тэдний зан авир зарим үед эвдэрч, сүйрэлд хүргэж болдгийг тайлбарла. Гэр бүлийн хосууд бие биетэйгээ хэзээ ч, ямар ч байдлаар зүй бусаар харьцах ёсгүй. Зүй бус харьцаа нь Бурханы зарлигуудыг түүнчлэн Сүмийн удирдагчдын онцгойлсон мэдэгдлүүдийг зөрчдөг. Сүмийн найм дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Жорж Альберт Смит: “Хүнд Их Эзэний сүнс байгаа цагт хэн ч, хэнтэй ч зүй бусаар харьцдаггүй. Зүй бус харьцаа нь бидэнд өөр сүнс байгаа үед л байнга гардаг” хэмээн мэдэгджээ (*Conference Report*, 1950 оны 10-р сар, 8).

Дараах мэдээллийг товчхон хуваалц:

Гэр бүлийн хос сэтгэл хөдлөлийн хувьд, бие бялдрын хувьд, эсвэл бэлгийн харилцааны хувьд бие биентэйгээ зүй бусаар харьцаж болно.

Сэтгэл хөдлөлийн зүй бус харьцаа нь чангаар дуу алдах, харааж зүхэх, дорд үзэн басамжилсан буюу доромжилсон үг хэллэг, тулган шаардалт, хүүхдүүдийнхээ буюу бусад хүмүүсийн өмнө муулах, дэмжиж туслахгүй буюу шийтгэл болгож хайр халамж үзүүлэхгүй байх, түүнчлэн эхнэр буюу нөхрийнхөө санаа бодлыг үл тоомсорлох буюу бага зүйлд тооцох явдлаар илэрдэг.

Биеийн зүй бус харьцаа нь түлхэх, хорих, сэгсрэх, цохих, алгадах, албадан шахах түүнчлэн эд юмс өгөхгүй байх зэргээр илэрдэг.

Бэлгийн зүй бус харьцаа нь сэтгэл хөдлөлийн болон биеийн зүй бус харьцаа аль алианаар нь илэрч болдог. Энэ нь бэлгийн харьцааны түрэмгийлэл, өвтгөх, хүч буюу айлган сүрдүүлэлт хэрэглэх, янаглалын үед нөгөө хосдоо тааламжгүй буюу дүргүй зүйлийг хийхийг шахан шаардах явдлаар илэрдэг.

Хэрэв зүй бус харьцааг юу бүрдүүлдэг талаар өөр асуултууд оролцогчдод байгаа бол тэд бишопоосоо зөвлөгөө авч болно гэдгийг тайлбарла.

Сүмийн арвантав дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн дараах мэдэгдлийг хуваалц. Ерөнхийлөгч Хинкли энэ сэрэмжлүүлгийг эхнэртэйгээ зүй бус харьцдаг эрчүүдэд өгсөн хэдий ч, энэ нь бас эмэгтэйчүүдэд ч хамаатай юм. Тэднийг энэ зөвлөгөөг сонсох үедээ үүний талаарх өөрсдийн зан авирыг дотроо эргэцүүлэн бодохыг хүс:

“Зарим хүмүүс [эрчүүд] өдөржингөө дэлхийн өмнө сайхан нүүр гаргаж, орой нь гэртээ ирээд, нөгөөх хувийн сахилгаа умартаж, тун ялигүй өдөөн хатгалгаас эхэлж, улмаар уурладаг.

“Ийм хилэнц үйлдэж, зүй бус авир гаргадаг хүн Бурханы санваарын хувьд зохистой байдаггүй. Өөрийгөө ийм байдлаар авч явдаг хүн Их Эзэний өргөөний онцгой боломжуудын хувьд зохистой байдаггүй. Эхнэр, хүүхдүүдийнхээ хайрыг даадаггүй зарим эрчүүд байдагт би харамсдаг. Эцгүүдээсээ айдаг хүүхдүүд, нөхрөөсөө айдаг эхнэрүүд байдаг. Их Эзэний үйлчлэгчийн хувьд миний дуу хоолойг сонсож байгаа хүмүүсийн дунд ийм эрчүүд байгаа бол би тэднийг зэмлэж, та нарыг наманчлалд дуудаж байна. Өөрсдийгөө сахилгажуул. Их Эзэн бол та нарын дуурайх зан төрх мөн. Та нарыг уурлуулдаг зүйлүүдийн олонх нь нэн ялигүй жижиг юмны үр дагавар байдаг. Гэтэл та уур уцаарынхаа төлөө аймшигтай төлөөс төлдөг шүү дээ. Өөрийгөө өршөөхийг Их Эзэнээс гуй. Өөрийгөө өршөөхийг эхнэрээсээ гуй. Хүүхдүүдээсээ уучлал гуй.” (Conference Report, 1996 оны 10-р сар, 91–92; *Ensign*, 1996 оны 10-р сар, 68).

Зарим хүмүүс зүй бус зан авирыг таньж мэдэлгүйгээр, үүний зарим хэв шинжийг хөгжүүлдэг болохыг тайлбарла. Бусад зарим нь зан авирыг өөрчлөх шаардлагатайг хүлээн зөвшөөрдөг хэдий ч, туслалцаагүйгээр өөрчлөлт гаргаж чадахгүй гэж боддог.

Зүй бус зан авираа ойлгож, өөрчлөхөд туслалцаа хүсдэг хүмүүс Их Эзэний тусламж, удирдамжийг даруухнаар эрэлхийлсэн үед, тэдний зүй бус зан авир өөрчлөгдөж болно. Тэд өөрсдөд нь зөвлөгөө өгч чадах бишопууддаа хандаж болно. Тэр бас Сүмийн жишгүүдэд нийцдэг ХҮГ Гэр Бүлийн Үйлчлэлийн болон олон нийтийн зөвлөхүүдийг санал болгож болно.

- Эхнэр буюу нөхрийн зүй бус харьцаа хүүхдүүдэд ямар байдлаар нөлөөлж болох вэ?

Оролцогчдоос хариултууд хүсэхийн хамт нөхөр буюу эхнэрийн зүй бус харьцаа нь бэрхшээлүүдийг хор хөнөөлтэй арга замаар шийдвэрлэх гэж оролдохын үргэлжилсэн жишээ болдог. Хүүхэд байхдаа ийм зүй бус харьцаа гаргадаг хүмүүс гэрлэсэн үедээ энэ загварыг үргэлжлүүлдгийг хүмүүс гэрчилдэг.

- Эцэг эхчүүд нь бэрхшээлийг эелдэг найрсаг харьцаа, тэвчээрээр шийдвэрлэх үед энэ нь хүүхдүүдэд хэрхэн нөлөөлдөг вэ?

Хайр хийгээд хэрсүү ухаантай эх, эцгүүд сорилт бэрхшээлтэй тулгарсан үедээ насан туршид үргэлжлэх сайн дадал хэвшлүүдийг хүүхдүүддээ заадаг. Бишоп Роберт Д.Хейлс Тэргүүлэх бишопоор үйлчилж байхдаа: “Сайн эцэг эхчүүдийн санал бодлын ялгааг хүлээн зөвшөөрч, эдгээр ялгааг сэтгэл санааны дарамт, өндөр дуугаар хашгичин зандрах буюу юм хаялж шидэхгүйгээр шийдвэрлэж болдгийг харах нь хүүхдүүдэд тустай байдаг. Тэд нэг нэгнийхээ бодол санаанд тайван, хүлээцтэй хандах хэрэгтэйг харна, ингэснээр амьдралд нь байгаа санаа бодлын ялгааг хэрхэн шийдвэрлэхийг мэдэх болно” хэмээн хэлжээ (Conference Report, 1993 оны 10-р сар, 10; *Ensign*, 1993 оны 11-р сар, 9).

ЭЕРЭГ ХАРИЛЦААГААР ДАМЖУУЛАН БЭРХШЭЭЛҮҮДЭД ХАРИУЛАХ НЬ

Хичээл
5

Зорилго Хайрын харилцаагаар дамжуулан гэрлэлт дэх бэрхшээлүүдээс урьдчилан сэргийлж, бэрхшээл гарсан үед хэрхэн шийдвэрлэхийг оролцогчдод заах.

Бэлтгэл

1. Та өөрийгөө заахад бэлтгэхдээ “Багшийн Хувьд Таны Үүрэг Хариуцлагууд” (энэ гарын авлагын хуудас х–xiii) дэх зарчмуудыг дагах арга зам хай.
2. Хичээл дэх сургаалууд болон зарчмуудыг тоймлон үзүүлдэг тодоор бичсэн гарчгуудыг унш. Бэлтгэлийнхээ нэг хэсэг болгон эдгээр сургаалууд болон зарчмуудыг долоо хоногийн турш эргэцүүлэн бодоод, оролцогчдын хэрэгцээнд тохируулан юуг онцлон хэлэхээ шийдэхэд Сүнсний удирдамжийг эрэлхийл.

**Энэ хичээлийг
заах зөвлөмж**

Гэрлэсэн хос бүрд санал бодлын зарим ялгаа байх болно.

Далын Ахлагч Жөү Ж.Кристенсений дараах мэдэгдлийг оролцогчдоор уншуул (*Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага*, хуудас 20):

“Юу гэж дээ, бид гэрлээд тавин жил болж байна шүү дээ, бидэнд санал бодлын зөрөлдөөн хэзээ ч байгаагүй” гэх мэтийн яриаг бид хааяа сонсдог. Үнэхээр тийм байдаг бол, энэ нь хэн нэгний хэлснээр үнэнээс гажууд зүйл буюу хосуудын нэг нь нөгөөгөө дарангуйлдаг байж таарна. Ямар ч ухаалаг боловсролтой хост санал бодлын зөрөлдөөн байх болно. Бидний сорилт бол тэдгээрийг хэрхэн шийдвэрлэхийг мэддэг байх явдал мөн. Энэ бол сайхан гэрлэлтийг улам сайн болгох үйл явцын нэг хэсэг мөн” (Conference Report, 1995 оны 4-р сар, 86; *Ensign*, 1995 оны 5-р сар, 65).

Энэ хичээлээр нөхөр эхнэр хоёр өөрсдийн харилцаанд тохиолдож болох бэрхшээлүүдээс урьдчилан сэргийлж, шийдвэрлэхэд тусалж чадах өвөрмөц зарчмуудын талаар ярилцах болно гэдгийг тайлбарла.

Эхнэр нөхрүүд нэг нэгнээсээ гайхамшигтай чанаруудыг эрж хайх хэрэгтэй

Эхнэр нөхрүүд нэг нэгнээсээ гайхамшигтай чанаруудыг хайвал тэд бэрхшээлүүдээс илүү сайнаар урьдчилан сэргийлж чадна. Тэрчлэн тэд үүсэн бий болсон бэрхшээлүүдийг хамтдаа шийдвэрлэх боломжтой байна. Дараах түүхийг хуваалц:

Нэг эмэгтэй нөхрийнхөө талаар гомдол мэдүүлэхээр бишопдоо дахин дахин очжээ. Эцэст нь бишоп, “Та энэ хүнийг ийм хайхрамжгүй, тэвчээр муутайг мэдсээр байж, яагаад түүнтэй суусан юм бэ?” гэж түүнээс асуухад, нөгөөх эмэгтэй түр зуур бодсоноо, “Тийм ээ, түүнд зарим сайн чанар байгаа гэж гэж би бодсон л доо, гэвч ямар ч тийм сайн чанарыг би санахгүй байна. Тэр

өөрчлөгдөх ёстой” гэж хариулжээ. Бишоп тэр эмэгтэйг гэртээ харьж, нэгэнтээ өөрийнхөө нөхөрт гайхан биширдэг байсан чанаруудыг санахын тулд залбирахыг түүнээс хүссэн аж. Цаг хугацаа өнгөрөх тутам тэр эмэгтэй нөхрийнхөө гайхан биширмээр чанаруудад анхаарал төвлөрүүлэх хэрэгтэйг хүлээн зөвшөөрөх боломжтой болжээ. Өмнө нь, тэрээр нөхрийнхөө дутагдлыг л олж харахад хамаг анхаарлаа хандуулаад, сайн чанаруудыг нь олж хардаггүй байжээ.

- Гайхамшигтай чанаруудыг бусдаас олж харахын үнэ цэнийг та нар ямар арга замаар харсан бэ? Бие биенээсээ гайхамшигтай чанаруудыг олж харах нь гэрлэлтээ бэхжүүлэхэд эхнэр, нөхрүүдэд хэрхэн тусалж чадах вэ?

Хэдийгээр хүн бүр өвөрмөц ялгаатай ч гэсэн, бид бүгдээрээ Бурханы хүүхдүүд гэдгийг оролцогчдод сануул. Нэг оролцогчийг “Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”-аас дараах мэдэгдлийг уншихыг урь (энэ гарын авлагын хуудас ix, түүнчлэн хуудас iv *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага*):

“Бурхан бүх хүн төрөлхтөн—эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг өөрийн дүр төрхөөр бүтээсэн. Хүн бүр тэнгэрлэг эцэг эхийн хайртай сүнсний хүү, охин нь бөгөөд ийм учраас хүн бүр бурханлиг шинж чанар, хувь тавилантай юм.”

- Энэхүү үнэнийг санах нь нөхөр, эхнэрүүдэд бие биенээ ойлгох тэдний хүч чармайлтад хэрхэн тусалж чадах вэ?

Эхнэр нөхрүүд бие биенээсээ эрхэм сайхан хийгээд бурханлиг бүхнийг эрж хайн олохыг эрэлхийлэх үед, бие биенээсээ баяр баясгалан болоод хамтын амьдралын бүрэн дүүрэн сайн сайхныг олж мэдэрдэг бөгөөд нэг нэгэндээ өөрсдийн бурханлиг чадавхийг хэрэгжүүлэхэд нь тусалдгийг тайлбарла.

Ахлагч Гордон Б.Хинкли Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад үйлчилж байхдаа, “хүн өөрийнхөө ханийг газар дэлхий дээрх хамгийн үнэ хүндтэй хүн гэж үзэх тийм хүндэтгэлийн” тухай өгүүлсэн байдаг. Тэрээр хэлэхдээ: “Гэрлэлт дэх хамтын амьдрал эгэл жирийн, тэр ч байтугай уйтгартай болох хандлага байдаг. Эрэгтэй хүн өөрийнхөө хажуу дахь туслагч нь Өөрийн мөнхийн зорилгуудыг тохиолгон авчрах Бурханы агуу их бүтээлтийн үйл явцад оролцдог гэдэг баримтыг хааяа дурсан санаснаар үүнийг эрхэм ариун, бурханлиг нөлөөн доор байлгадаг илүү тодорхой арга замыг би мэдэхгүй юм. Нөхрөө хайрладаг хайраа ямагт гэрэл гэгээтэй байлгаж, бидний Тэнгэрлэг Эцэгийн хүү бүрийн бурханлиг чанаруудыг онцлон анхаарснаар хүндэтгэл, бишрэл хийгээд урамшуулал төрүүлэхийг эрж хайхаас илүү үр ашигтай арга замыг би мэдэхгүй юм. Ийм үйл ажиллагаануудын чухамхүү үйл явц нь бие биенээ дээдлэн хүндлэх байнгын хөшүүргийг бий болгон өсгөх болно” гэжээ (Conference Report, 1971 оны 4-р сар, 81–82; *Ensign*, 1971 оны 6-р сар, 71–72).

Эерэг харилцаа бэрхшээлүүдээс урьдчилан сэргийлж, тэдгээрийг шийдвэрлэхэд тусална

Бие биендээ байдаг гайхан биширмээр чанаруудыг нөхөр, эхнэрүүд хүлээн зөвшөөрөхийн хамт, өөр хоорондоо эелдэг ялдам сайхан харьцахыг хичээх ёстой. Харилцаа бол хайр, эв нэгдлийг төлөвшүүлэх хийгээд үүсэн бий болж мэдэх бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд амин чухал юм.

Дараах зарчмуудыг самбар дээр бич:

Бие биенээ сонс. Бэрхшээлүүдийг илэн далангүй, тайван ярилц. Хайраар, эерэг байдлаар харилц.
--

Эдгээр зарчмууд харилцаагаа сайжруулахад нь гэрлэсэн хосуудад тусалж чадна гэдгийг тайлбарла. Зарчим тус бүрийн тухай ярилцлага хөтлөн явуулахад дараах материалыг ашигла:

Бие биенээ сонс.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Рассел М.Нелсоны дараах мэдэгдлийг хуваалц:

“Нөхөр эхнэрүүд сонсож сурдаг, нэг нь нөгөөгийнхөө үгийг сонсож сурдаг. . . . Ярилцах цаг гаргах нь харилцааны хэвийн байдлыг хадгалахад амин чухал юм. Хэрэв гэрлэлт амьдрал дахь харилцаанд тэргүүлэх байр эзэлдэг бол, тэргүүлэх цаг хугацаа үүнд зориулагдах ёстой! Багахан ач холбогдол бүхий болзоонд чухал ач холбогдол өгөх нь олонтаа байдаг мөртлөө, хамгийн эрхэм хүндтэй ханийхаа үгийг сонсоход зөвхөн илүү цагаа л зориулах нь байдаг” (Conference Report, 1991 оны 4-р сар, 28; *Ensign*, 1991 оны 5-р сар, 23).

- Эхнэр нөхөр хоёр бие биенийхээ үгийг хайрын үндсэн дээр анхааралтай сонсдог бол тэдэнд ямар ашиг тус ирэх вэ? (Доор жагсаасан хариултууд байж болно.)
 - а. Тэд бие биенийхээ үнэн бодол санаа хийгээд учир үндэслэлийн тухай илүү ихийг мэддэг болно.
 - б. Тэд дүгнэлт хийх буюу зөвлөгөө өгөхөөсөө өмнө ойлгохыг хичээдэг.
 - в. Тэд тус бүрдээ өөрөө үнэлүүлдэг, бас хайрлуулдгаа илүү их мэддэг.
 - г. Тэд тус бүрдээ өөрийгөө хамгаалах нь бага болж, илүү илэн далангүй харилцдаг болно.
- Гэр бүлийн хосууд бие биенээ үнэхээр сонсдог байхад юу саад болдог вэ? (Ажлын шахуу цаг, сонсоход цаг гаргах боломжгүй байх, бие биенийхээ үүрэг хариуцлагыг сонирхох сонирхол дутмаг байх нь хариултууд байж болно.)
- Илүү сайн сонсогчид байхын тулд гэр бүлийн хосууд юу хийж болох вэ? (Оролцогчдын санаануудыг асуухаас гадна, доор жагсаасан санаануудыг хуваалцахад анхаар.)
 - а. Хамтдаа ярилцах цаг гаргах. Анхаарал сарниулах зүйлгүй байж, бүх анхаарлаа бие биендээ хандуул.

- б. Ойлгохын тулд сонс. Ярьж байгаа хүний үгийг бүү тасал. Хэрэв шаардлагатай бол, “Энэ тухай чи надад арай тодорхой ярихгүй юу?” эсвэл “Ийм явдал болоход чамд ямар санагдсан бэ?” эсвэл “Би ойлгосонгүй. Чи ингэж хэлж байна уу. . . ?” гэх зэрэг асуултуудыг асуу.
- в. Уурлах, хүн гомдоохоос зайлсхий. Олон тохиолдолд нэгээс илүү санал бодол зөв байдгийг санагтун.

Бэрхшээлүүдийг илэн далангүй, тайван яриц.

- Гэрлэлтдээ тохиолдсон бэрхшээлүүдийн талаар гэр бүлийн хосууд бие биендээ илэн далангүй ярих нь яагаад чухал вэ?

Бэрхшээлийн тухай яриаг харилцан хүндэтгэсэн байдлаар, маргаан буюу зөрчилгүйгээр хийх ёстойг тэмдэглэн хэл. Ахлагч Гордон Б.Хинкли Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад үйлчилж байхдаа:

“Бид намуухан зөөлнөөр ярилцах үед эвгүй байдалд орох нь ховор байдаг. Бид гагцхүү дуугаа өндөрсгөсөн үед л хэрүүлийн оч үсэрч, жижигхэн гүвээ том уул болон өсч зөрчил сөргөлдөөн үүсдэг. . . . Тэнгэрийн дуу хоолой намуухан зөөлхөн дуу хоолой байдаг; үүнчлэн, гэр орон дахь амар амгалан бол нам гүмхэн дуу хоолой байдаг” гэжээ (Conference Report, 1971 оны 4-р сар, 82; *Ensign*, 1971 оны 6-р сар, 72).

Ерөнхийлөгч Давид О.МкКей, “Хэрэв орон гэр нь шатаагүй л бол, нөхөр, эхнэр хоёр бие биендээ хэзээ ч дуугаа өндөрсгөн бүү яриг” гэж хэлжээ (*Stepping Stones to an Abundant Life*, эмхтгэсэн. Ллюлин Р.МкКей [1971], 294).

Хайрлангүй, эерэг байдлаар харилц.

- Хүндэтгэл, дэмжлэг, хайраа илэрхийлэх нь гэрлэлтэд ямар байдлаар нөлөөлдөг вэ? Шүүмжлэл, үглэж янших, өө сэв эрэх зэрэг сөрөг харилцаа гэрлэлтэд хэрхэн нөлөөлдөг вэ?

Ахлагч Жөү Ж.Кристенсений дараах зөвлөгөөг оролцогчдоор уншуул (*Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага*, хуудас 00 (19):

“Байнга гардаг жижиг сажиг таагүй явдлаас зайлсхий. ‘Бие биенийхээ дутагдалд хэтэрхий шүүмжлэлтэй бүү бай. Бидний хэн нь ч төгс биш гэдгийг санагтун. Манай удирдагчид биднээс хичээнгүйлэн хүсдэгчлэн, бид Христтэй адилхан болохын тулд бүгд урт удаан замыг туулдаг.

“Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын нэрлэсэн ‘байнгын жижиг сажиг таагүй зүйл’ бараг л гэрлэлт бүрд байдаг аж. . . . Ерөнхийдөө бидний хүн нэг бүр өөрсдийн сул талд эмзэг ханддаг, иймээс бидэнд байнгын сануулагч хэрэггүй байдаг. Байнгын шүүмжлэл хийгээд үглэн яншсаны үр дүнд сайн тал руугаа өөрчлөгдсөн хүн ганц нэгхэн л байдаг байх. Хэрэв бид анхааралтай байхгүй бол, *үр ашигтай* шүүмжлэл хэмээн бидний санал болгодог зүйл үнэн хэрэг дээрээ *хор хөнөөлтэй* зүйл байдаг” (1995 оны 4-р сарын Conference Report, 85-ыг үз; эсвэл *Ensign*, 1995 оны 5-р сар, 64–65; мөн түүнчлэн Спенсер В. Кимбалл, “Marriage and Divorce,” *1976 Devotional Speeches of the Year* [1977], 148-ыг үз).

- Байнга гомдоллох буюу шүүмжлэхийн үр дагавар юу байж болох вэ?

- Шүүмжлэлийн нэг хэлбэр бол нэг хүний сул талыг бусдын давуу талтай харьцуулах явдал мөн. Энэ зуршил гэрлэлтэд хэрхэн нөлөөлж болох вэ?
- Бусдыг байнга шүүмжилснээс тэднийг магтаж урамшуулах нь илүү үнэ цэнэтгийг харуулсан ямар туршлага та нарт тохиолдож байсан бэ? Эерэг илэрхийллүүд ямар байдлаар гэрлэлтийг бэхжүүлдэг вэ?

Түүний авъяас чадварыг бас гэрийн эзэгтэйн хувьд түүнийг нөхөр нь зөвхөн гэртээ байхад төдийгүй, тэд найз нөхөдтэйгөө хамт байхад ч үргэлж магтан сайшаадаг байсан тухай нэг эмэгтэй ярьдаг байжээ. Нөхөр нь эхнэрийнхээ сул талыг огт дурсдаггүй байж. Харин үүний оронд тэрээр эхнэрийнхээ давуу тал дээр анхаарлаа төвлөрүүлдэг байж. Нөхрийнх нь энэхүү хандлага түүнд итгэл найдвар, улам өсөн хөгжих учир үндэслэл болж өгдөг байсан хэмээн тэр эмэгтэй ярьжээ.

Дүгнэлт

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Марвин Ж.Аштоны дараах зөвлөгөөг хуваалц:

“Гэр бүлийн ярилцлагад санал бодлын ялгааг хайхрахгүй байж болохгүй ч гэсэн, шүүн хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгөхдөө тайван байх ёстой. Нэг хүний үзэл буюу санал нь цаашид үргэлжлүүлэхээр бөгөөд эрүүл саруул харилцааны адил ач холбогдолтой байдаггүй. Ярилцлагын үед анхааралтай сонсож, хариулахад эелдэг найрсаг, хүндэтгэлтэй байх нь харилцан яриа зохих ёсоороо өрнөхөд үндэс суурь нь болж өгдөг. . . . Бусдын үзэл бодолтой санал нийлэхгүй тохиолдолд хэрхэн, юуны улмаас санаа нийлэхгүй байгааг мэдэх нь хичнээн чухал билээ” (Conference Report, 1976 оны 4-р сар, 79; *Ensign*, 1976 оны 5-р сар, 52).

Өөрсдийн ярилцсан зарчмуудыг товч нэгтгэн дүгнэ. Эдгээр зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь оролцогчдыг урамшуул. Сүнсээр өдөөгдсөний дагуу гэрчлэлээ хэл.

Гэр Бүл ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын хуудас 18–20-ийг үз. Оролцогчдыг (1) “Хэрэгжүүлэхэд Зориулсан Санаанууд” дахь зөвлөмжүүдээс доод тал нь нэгийг дагаж, (2) Ахлагч Жөү Ж.Кристенсений “Гэрлэлт ба Аз Жаргалын Агуу Төлөвлөгөө” өгүүллийг уншиж энэ хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудыг нэгтгэн дүгнэхэд нь урамшуул. Гэрлэсэн хосууд судлах гарын авлага дахь өгүүлүүдийг хамтдаа уншиж, ярилцсанаар ашиг тусыг олж болохыг онцлон хэл.

ИТГЭЛ ХИЙГЭЭД ЗАЛБИРЛААР ДАМЖУУЛАН ГЭРЛЭЛТИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Зорилго

Гэрлэсэн хосуудыг Есүс Христэд итгэх итгэлийг хөгжүүлж хамтран залбирснаар ирдэг адислалуудыг хүлээж авахын тулд ойлгож, ажиллахад нь оролцогчдоод туслах.

Бэлтгэл

1. Та өөрийгөө заахад бэлтгэхдээ “Багшийн Хувьд Таны Үүрэг Хариуцлагууд” (энэ гарын авлагын хуудас х–xiii) дэх зарчмуудыг дагах арга замыг эрж хай.
2. Хичээл дэх сургаалууд болон зарчмуудыг тоймлон үзүүлэх тодоор бичсэн гарчгуудыг унш. Бэлтгэлийнхээ нэг хэсэг болгон эдгээр сургаалууд болон зарчмуудыг долоо хоногийн турш эргэцүүлэн бодоод, оролцогчдын хэрэгцээнд тохируулан юуг онцлон хэлэхээ шийдэхэд Сүнсний удирдамжийг эрэлхийл.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Эхнэр нөхрүүд Есүс Христэд итгэх итгэлээ өсгөн нэмэгдүүлэхийн тулд хамтдаа ажиллах хэрэгтэй.

Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Жеймс И. Фаустын ярьсан дараах түүхийг хуваалц:

“Ахлагч Орин Вууриес . . . бол Аргентины Буенос Айрест үйлчилж асан том биетэй, царайлаг, онцгой сайхан залуу хүн юм. Номлолдоо ирээд 11 сар орчим болсны дараа, нэг шөнө, зэвсэглэсэн хэдэн дээрэмчин Ахлагч Вууриес болон түүний хамтрагчийг гудамжинд хоргоожээ. Тэдний нэг нь, ухаан мэдрэлгүй хүчирхийллийн үйлдэлд Ахлагч Вууриесын толгойд нь буудсан аж. . . .

“Ахлагч Вууриес одоо болтол саанд бараг бүрэн дайрагдаж, ярьж чаддаггүй хэдий ч, түүнд гайхамшигтай сүнс байдаг бөгөөд асуултуудад гарын хөдөлгөөнөөр хариулдаг. Тэрээр номлогчийн энгэрийн тэмдгээ одоо хүртэл зүүсээр байдаг аж. Тэдний эцэг эхчүүд, ‘Эзэний дуудлагаар үйлчилж байсан сайхан хүүд минь яагаад ийм явдал тохиолдов?’ гэж асуудаггүй. Илүү эрхэм зорилгууд биелсэн нөхцөл байдалд л бус бол, хэнд ч тодорхой хариулт байдаггүй. Бид итгэлээр алхлах ёстой” (Conference Report, 1999 оны 10-р сар, 73; *Ensign*, 1999 оны 11-р сар, 59–60).

Еврей 11:1, Алма 32:21-ийг оролцогчдын хамт унш. Еврей 11:1-ийн Иосеф Смитийн орчуулгад “итгэл бол найддаг зүйлүүдэд *баттай итгэх* явдал мөн” хэмээн өгүүлсэн байдаг.

- Эдгээр шүлгүүдэд өгүүлснээр итгэлийн тодорхойлолт юу вэ?
- Ерөнхийлөгч Фаустын өгүүлснээр гэрлэсэн хосуудаас “итгэлээр алхлахыг” шаарддаг ямар зарим нөхцлүүд байдаг вэ?

Өөрсдийнхөө амьдралын жишээнүүдээс хуваалцахыг оролцогчдоос хүсэхийг бод. Хариултуудад эрүүл мэнд муу байх, үр хүүхэдгүй байх, нас өтлөх, тахир дутуу хүүхдүүд, хайртай хүмүүс нь нас барах, санхүүгийн бэрхшээлүүд, хэцүү хүүхдүүд, түүнчлэн байгалийн гамшиг зэрэг байж болно. Сорилт бэрхшээлүүд бидний амьдралд, бүр бид зөв шударгаар амьдрахыг хичээж байгаа үед ч гэсэн ирж болохыг тэмдэглэн хэл.

Моронай 7:32–33-ыг оролцогчдын хамт унш. Бидний итгэл Есүс Христэд төвлөрөх ёстойг онцлон тэмдэглэ. Бид Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэх юм бол, бэрхшээлтэй тулгарах үед хүчирхэгждэгийг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г.Скотт тайлбарлажээ:

“Та нар *Есүс Христэд итгэх итгэл* хийгээд даруу байдалд чөлөөлөлтийг эрэлхийлэх үед Их Эзэн бурханлиг хүчээр тайтгарлыг үзүүлэх болно. . . . Өөрийн чинь итгэл хийгээд хүч чармайлтгүйгээр хэн ч та нарт тусалж чадахгүй. Та нарын хувь хүний өсөлт үүнийг шаарддаг. Ая тухгүй байдал, эмзэглэл, дарамт шахалт, сорилт бэрхшээл буюу гомдлоос бүрмөсөн чөлөөтэй амьдралыг бүү эрж хай, эдгээр зүйлийн хувьд хайраар дүүрэн Эцэг маань зэмсгүүдийг бидний хувь хүний өсөлт хөгжилт хийгээд ойлголтыг хөхүүлэн дэмжихэд хэрэглэдэг билээ. Судрууд давтан өгүүлдэгчлэн, та нар *Есүс Христэд итгэх итгэлээ* хөгжүүлэх үед тусламж авах болно. Итгэл нь Түүний бошиглогчид болон судруудаар дамжуулан өгсөн Түүний амлалтуудад итгэх хүсэл эрмэлзлээр илэрхийлэгддэг билээ” (Conference Report, 1994 оны 4-р сар, 8; *Ensign*, 1994 оны 5-р сар, 8).

Нөхөр эхнэрүүд өөрсдийн амьдралыг Аврагч дээр төвлөрүүлэхийн тулд хамтран ажиллах ёстойг тэмдэглэ. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жеффри Р.Холланд хэлэхдээ:

“Христийнх шиг цэвэр хайр, аюулгүй байдал, бат найдвартай байдлыг гэрлэлтийнхээ амьдрал хийгээд үүрд мөнхөд байлгах чадварыг та нар хүсдэг үү? Есүсийн үнэн шавь бай. Жинхэнэ, шийдвэр төгс, үг хийгээд үйл хэргийн аль алианаар нь Хожмын үеийн Гэгээнтэн бай. Итгэлд тань таны оргилуун хүсэл эрмэлзлийн хамт *юм бүхэн* байдаг гэдэгт итгэ, учир нь үүгээр та нар өөрийнхөө болон хайртай ханийнхаа хайрын хийгээд аз жаргалын замыг амжилттай харж чаддаг тэрхүү цорын ганц чийдэн—Дэлхийн Гэрэл, Есүс Христийг. . . бий болгодог” (“*How Do I Love Thee?*” [Brigham Young University devotional address, 2000 оны 2-р сарын 15], 6).

- Аврагчид итгэх өсөн нэмэгдсэн хайр нь гэрлэсэн хосуудад бие биентэйгээ харилцах харилцааг бэхжүүлэхэд хэрхэн тусалж болох вэ? (Доор жагсаасан хариултууд байж болно.)
 - а. Тэд бие биетэйгээ харилцах харилцаанд Христтэй илүү адилхан болдог. Тэд илүү хайрладаг, тусч, эелдэг, тэвчээртэй хийгээд бие биенээ сонсох хүсэлтэй болдог байна.
 - б. Тэд илүү даруу болж, наманчлах хийгээд Аврагчийн заадаг зүйлүүдийг дагах хүсэлтэй болдог. Эхнэр буюу нөхөр тус бүрдээ наманчилж, Аврагчтай илүү адилхан болохыг хэдийчинээ ихээр хүснэ, гэрлэлт нь төдийчинээ их эв нийцтэй болох болно.
- Гэрлэсэн хосууд Аврагчид итгэх итгэлээ өсгөн нэмэгдүүлэхийн тулд ямар байдлаар хамтран ажиллаж болох вэ? (Оролцогчдыг Аврагчид итгэх итгэлийг нь бэхжүүлсэн туршлагаадаасаа хуваалцахыг урь. Оролцогчдын

хариултуудыг хүсэхийн хамт, доор жагсаасан зарчмуудыг хуваалцахад анхаар.)

- а. Сайн мэдээний хуулиуд хийгээд ёслолуудыг дуулгавартай дага. (Тэргүүлэх Бишопоор үйлчилж байхдаа Бишоп Роберт Д.Хейлсийн хийсэн дараах мэдэгдлийг хуваалц: “Сайн мэдээний хуулиуд хийгээд ёслолуудад дуулгавартай байх нь Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлийг олж авахад зайлшгүй чухал юм” [Conference Report, 1990 оны 4-р сар, 52; *Ensign*, 1990 оны 5-р сар, 39].)
- б. Судруудыг хамтдаа судал. (Хиламан 15:7–8-ыг оролцогчдын хамт судал.)
- в. Их Эзэнд итгэ. (Сургаалт Үгс 3:5–6-г оролцогчдын хамт унш. Гэр бүлийн хосууд бэрхшээлтэй тулгарах үед, тэд өөрсдийн итгэлийг өдөр тутмын амьдралынхаа бүр илүү чухал хэсэг болгон, Их Эзэний тусламжийг агуу хүсэл эрмэлзлээр эрж хайхаар шийдэж чадна гэдгийг онцлон хэл.)

Эхнэр нөхрүүд хамтдаа залбирах үед адислагддаг

- Эхнэр нөхрүүд хамтдаа залбирах үед ямар адислалууд тэдэнд ирж болох вэ? (Энэ асуултад тохирох туршлагаудыг хуваалцахад нь оролцогчдыг урамшуул. Үүнээс гадна, дараах ишлэл, дараах жишээнүүдээс нэгийг, эсвэл хоёуланг нь унш.)

Ахлагч Гордон Б.Хинкли Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад үйлчилж байхдаа дараах зөвлөгөөг өгчээ:

“Та нарын амьдралд та нар өдөр бүрийг эхэлж, төгсгөхдөө хамтдаа өвдөг сөгдөх тэрхүү зуршлаас илүү ашиг тустай нөлөө үзүүлэх тийм дадал зуршлыг би мэдэхгүй. Гэрлэлт бүрд зовлон учруулж болох жижигхэн шуургууд Их Эзэний өмнө өвдөг сөгдөх үед ямар боловч сарнин алга болдог, та нар нэг нэгнийхээ дэргэд, нэг нэгнийхээ төлөө түүнд талархал өргөдөг, тэгээд дараа нь түүний адислалуудыг амьдралдаа, гэр орондоо, хайртай хүмүүс дээрээ, бас хүсэл мөрөөдөлдөө хамтдаа урин дууддаг.

“Тэгэхэд Бурхан та нарын хамтрагч байх байх болно, тийнхүү түүнтэй хийх таны өдөр тутмын ярианууд өөр ямар ч эх сурвалжаас ирж эс чадах амар амгаланг та нарын зүрх сэтгэлд, баяр баясгаланг та нарын амьдралд авчрах болно. Та нарын хамтын амьдрал он жилүүд улиран одох тусам аятай сайхан болох болно; та нарын хайр бэхжих болно. Та нар бие биенээ эрхэмлэн дээдлэх нь өсөн нэмэгдэх болно” (Conference Report, 1971 оны 4-р сар, 83; *Ensign*, 1971 оны 6-р сар, 72).

Эхнэрийнх нь залбирлууд түүнд илүү сайн нөхөр, илүү сайн эцэг байхад нь сүнслэгээр нөлөөлөхөд тусалсан тухай нэгэн нөхөр ярьжээ. Тэрээр эхнэрийнхээ дэргэд өвдөг сөгдөн залбирахдаа, түүний гарыг дээш барин, зүрх сэтгэлийнхээ санаа бодлуудын тухай Бурханд дэлгэн гуйхыг нь сонсдог байжээ. Эхнэрийнх нь зүрх сэтгэл цэвэр ариун, түүний эрмэлзэл тэмүүлэл жинхэнэ үнэн гэдгийг нөхөр нь мэддэг учраас эхнэрээ хайрладаг нөхрийнх нь хайр өсөн нэмэгддэг ажээ. Эхнэр нь Тэнгэрлэг Эцэгт хандан ярихад, зөв шударга байдалд Түүнд үйлчлэхээс өөр юуг ч эхнэр нь үнэхээр хүсдэггүй байлаа.

Өөр нэг гэр бүлд, нөхөр нь бие эрхтний гажигаар удаан хугацаанд зовон шаналжээ. Орой болгон тэрээр эхнэрийнхээ хамт унтахаар хэвтэхдээ өөрсдөд нь ирсэн адислалуудын төлөө Тэнгэрлэг Эцэгт талархаж, багахан орлогоороо дөрвөн хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд Түүнээс удирдамж эрэлхийлдэг байжээ. Хэдэн жилийн дараа, нөхөр нь ажилдаа эргэн орох боломжтой болсон үед, хүнд бэрх цаг үед тэд хэрхэн ажиллаж, амьдарч байсныг нь тэднээс асуусан аж. Хамт ажиллаж, хамт залбирч байсан нь өөрчлөлт гаргасан гэж тэд гэрчилдэг байв. Тэдний чин сэтгэлийн залбирал олон адислалаар, түүний дотор Сүнсний тайтгаруулагч нөлөөгөөр дамжуулан тэдний хүлээн авсан найдвараар адислагдсан ажээ.

- Хамтдаа залбирах нь өөрсдийн харилцаан дахь бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд нь нөхөр эхнэрүүдэд хэрхэн тусалж болох вэ? (Оролцогчдыг энэ асуултын талаар ярилцах зуур нөхөр эхнэрүүд хоорондоо зөрчилтэй байх үедээ заримдаа хамтдаа залбирахаа больдог гэдгийг анхааруулан хэл. Гэвч, хамтдаа залбирах нь ийм бэрхшээлүүдийг даван туулахад тэдэнд туслах хүчтэй хэрэгсэл болдог.)

Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Томас С.Монсон, тэрээр гэргий Францистайгаа Солт Лейкийн Ариун Сүмд лацдан холбуулсан өдрийнхөө тухай ярьсан байдаг. Ёслолыг гүйцэтгэсэн Бенжамин Бауринг тэдэнд дараах зөвлөгөө өгчээ: “Та нарт учрах аливаа санал зөрөлдөөн нэг өдрөөс илүү удаан хугацаагаар үргэлжлэхгүй байх томъёоллыг шинэхэн гэрлэгсэд та нарт би санал болгохыг зөвшөөрнө үү? Шөнө болгон орныхоо хажууд өвдөг сөгдөж бай. Нэг шөнө Монсон Ах та өвдөг сөгдөн, чангаар залбирч бай. Дараагийн шөнө нь, Монсон Эгч та өвдөг сөгдөн, чангаар залбирч бай. Тэгэх юм бол та нарыг залбирахад тэр өдөр бий болсон аливаа буруу ойлголтууд та нараас сарнин алга болно. Та нар хамтдаа залбирахгүйгээр бие биендээ хандсан хамгийн сайн сайхан санаа бодлуудыг өөрсдөдөө хадгалж чадахгүй” (Conference Report, 1988 оны 10-р сар, 81; *Ensign*, 1988 оны 11-р сар, 70).

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Давид Б.Хайт хэлэхдээ: “Хэрэв нөхөр эхнэр та хоёр, ноцтой буруу ойлголттой байх буюу, эсвэл гэрлэлтдээ зарим хүндрэл бэрхшээл бий болсныг мэдрэх юм бол, та нарын харилцааг бүрхсэн харанхуйг сөхөхийн тулд, өөрсдөдөө хэрэгтэй гэрлийг хүлээн авахын тулд, өөрсдийн алдааг харж, буруу зүйлүүдээ наманчлахын тулд, бие биенээ уучлахын тулд, түүнчлэн эхэнд та нар хийсэн зүйлээ тус бүрдээ өөрсдөдөө хүлээн авахын тулд та нар даруухнаар өвдөг дээрээ сөрөн, чин сэтгэлээсээ, үнэн санаа бодлоор өөрсдийн Эцэг Бурханаас асуух хэрэгтэй. Бурхан амьдардгийг, тэрчлэн та нарын даруухан гуйлтад хариулах болно гэдгийг би та нарт хүндэтгэлтэйгээр батлан хэлж байна” гэжээ (Conference Report, 1984 оны 4-р сар, 17; *Ensign*, 1984 оны 5-р сар, 14).

Эхнэр буюу нөхөртэйгөө хамт залбирах хүч чармайлтаа чимээгүйгээр үнэлэн дүгнэхийг гэрлэсэн оролцогчдоос хүс. Эцэг буюу эхийн зөвхөн нэг нь байдаг гэр бүлд хувь хүний оргилуун залбирал нь Бурханы адислалуудыг гэр орондоо авчирдгийг онцлон хэл.

Дүгнэлт

Есүс Христэд итгэх итгэлийг хөгжүүлж, залбирахын тулд нөхөр эхнэрүүд хамтран ажилласан үед тэд илүү их аз жаргал, эв нэгдэл хийгээд бэрхшээлүүдийг даван туулах чадварыг олдог.

Сүнсээр өдөөгдсөний дагуу, энэ хичээлээр яригдсан үнэнүүдийн тухай гэрчил.

Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага, хуудас 21–24-ийг үз. Оролцогчдыг (1) “Хэрэгжүүлэхэд Зориулсан Санаанууд” дахь зөвлөмжүүдээс доод тал нь нэгийг дагаж, (2) Ахлагч Ричард Г.Скоттын “Амьдрал дахь Баяр Баясгаланг Олох нь” өгүүллийг уншиж энэ хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудыг нэгтгэн дүгнэхэд нь урамшуул. Гэрлэсэн хосууд судлах гарын авлага дахь өгүүллүүдийг хамтдаа уншиж, ярилцсанаар ач тусыг олж болохыг онцлон хэл.

Өөрсдийн судлах гарын авлагуудыг дараагийн хичээлд ангид авчрахыг оролцогчдоод сануул.

Зорилго Бие биенээ уучилдаг хүмүүст ирдэг амар амгаланг биеэрээ амсахад нь оролцогчдод туслах, гэр орондоо уучлалын сүнснийг төлөвшүүлэн хөгжүүлэхэд оролцогчдыг урамшуулах.

- Бэлтгэл**
1. “Багшийн Хувьд Таны Үүрэг Хариуцлагууд” дахь (энэ гарын авлагын хуудас х–xiii) зарчмуудыг хэрэглэж болох арга замуудыг авч үз.
 2. Хичээл дэх сургаалууд болон зарчмуудыг тоймлон харуулсан тод гарчгуудыг унш. Бэлтгэлийнхээ нэг хэсэг болгон эдгээр сургаалууд болон зарчмуудыг долоо хоногийн турш эргэцүүлэн бодоод, оролцогчдын хэрэгцээнд тохируулан юуг онцлон хэлэх ёстойг шийдэхэд Сүнсний удирдамжийг эрэлхийл.
 3. *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагаа* ангид авчрахыг оролцогчдод сануул. Уг гарын авлагыг хичээлийн үед ашиглах нь тэдэнд ашигтай байх болно.

Анхааруулга: Та энэ хичээлийг заахдаа оролцогч хувь хүмүүсийн нөхцөл байдалд онцгой мэдрэмжтэй бай. Хэрэв оролцогчид зүй бус харьцаа буюу итгэл эвдсэн зэрэг гэр бүлийн ноцтой асуудлуудыг уучлах тухай асуултууд асууж, хариултуудыг эрж байгаа бол, тэднийг бишоптойгоо хувиараа уулзаж, ярилцахыг эелдэг зөөлнөөр урамшуулан дэмж.

**Энэ хичээлийг
заах зөвлөмж**

Эхнэр нөхрүүдийн хоорондох уучлалын сүнс нь амар амгалан, итгэл хийгээд аюулгүй байдлын мэдрэмжийг авчрахад тусалдаг.

Далын Ахлагч Хью В.Пиннокийн ярьсан дараах түүхийг унш:

“Амьдралд хожуу гэрлэсэн . . . хос; эхнэр нь өмнө нь гэрлэж байсан хүн байж, харин нөхрийнх нь хувьд энэ нь анхны гэрлэлт байв. Гэрлэлт хэдэн сарын аз жаргал авчирсны дараа, нөхөр нь өдөр тутмын ажил үүргээ хэвийн байдлаар гүйцэтгэж чадахгүй болтлоо сэтгэл санаагаар унасан тийм ноцтой санал зөрөлдөөн үүсэх нь тэр.

“Нөхөр нь энэхүү зөрчлийн нөлөөгөөр дарамтлагдсан үед тэрээр уг асуудалд дүн шинжилгээ хийхээ больж, тэгээд асуудлын бага ч гэсэн нэг хэсэг нь түүнийх байсныг ойлгожээ. Тэрээр сүйт бүсгүйдээ очиж, эвгүйгээр ээрэн хэдэн удаа, ‘Намайг уучлаарай, Хонгор минь’ хэмээн хэлсэн аж. Эхнэр нь нулимс урсган, асуудлын ихэнх нь өөрийнх нь байсныг хүлээн зөвшөөрч, уучлалт хүсчээ. Тэд бие биенээ тэврэх үед, уучлалт хүссэн ийм үгс түүний амьдралд өмнө нь байгаагүйг эхнэр нь хүлээн зөвшөөрч, тэгээд тэдний ирээдүйн асуудлуудаас алиныг нь ч шийдвэрлэж болохыг тэрээр сая мэджээ. Тэд хоёулаа, ‘Намайг уучлаарай’; ‘Би уучилъя’ гэж хэлэх чадвартай байсныг эхнэр нь мэдсэн учраас ирээдүйдээ итгэх мэдрэмж түүнд төржээ” (“Making a Marriage Work,” *Ensign*, 1981 оны 9-р сар, 36–37).

Энэ түүхийг гэрлэлтдээ олон бэрхшээлтэй учирсан нөхөр, эхнэр хоёртой хийсэн ярилцлагынхаа талаар өгүүлсэн Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн дүрслэлтэй харьцуул (*Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага*, хуудас 26):

“Миний ширээний нөгөө талд суусан гэр бүлийн нэгэн хосын яриаг дуустал нь сонссоноо би эргэн санадаг. Тэдний хооронд гашуун хөндийрөл бий болсон байв. Нэгэн цагт тэдний хайр дурлал гүн гүнзгий, үнэнч байсныг би мэдлээ. Гэвч нөхөр, эхнэр хоёр аль аль нь нөгөөгийнхөө дутагдлын талаар ярьдаг зуршилтай байжээ. Бид бүгдийн гаргадаг энэ төрлийн алдааг уучлах хүсэлгүй байснаар, тэдгээр алдааг мартахыг хүсэхгүй байснаар, улмаар сурсан юмыг сураар боож болдоггүй гэдэг шиг тэдгээрээс салж чадахгүй байсаар, тэд бие биенийхээ чихнээс хонх уясаар, нэгэн цагт тэдний мэддэг байсан хайр дурлал замхран алга болжээ. Энэ нь тэгээд ‘дутагдалгүй’ салалт гэж нэрлэгддэг нэгэн зүйл болон үнс чандруу болж хувирчээ. Ингэсэн тохиолдолд зөвхөн ганцаардал, бие биенээ буруутгах явдал л үлдэнэ. Тэд хамтдаа хэвээр байж, тэдний өнгөрсөн жилүүдийг арвин баялгаар адисалсан тэрхүү хамтын амьдралаа таалан, наманчлал, уучлал ялигүй бага ч атугай байх юм бол миний сэтгэл ханах сан” (“Of You It Is Required to Forgive,” *Ensign*, 1991 оны 6-р сар, 4).

- Энэ хоёр жишээнээс бид юуг мэдэж болох вэ?

Энэ хичээл бол уучлалыг эрэлхийлэх хийгээд бие биенээ уучлахын ач холбогдлын тухай юм гэдгийг тайлбарла. Хэрэв гэрлэсэн хос өөрсдийн гэрлэлтэд уучлалын сүнстэй байхыг хичээх юм бол, өөрсдийн харилцаанд учирч болох олон бэрхшээл сорилтыг даван туулж чадна гэдгийг онцлон хэл. Тэд ингэхийн хэрээр: “Зүрх сэтгэлд тань амар амгалан, өөрөөр хэлбэл ханаж баршгүй их байх болно” (*Ensign*, 1991 оны 6-р сар, 5) хэмээн бие биенээ уучилдаг хүмүүст Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн амласан амлалтын үнэнийг тэд мэдэх болно.

Эхнэр нөхрүүд бие биенийхээ сул тал, дутагдал доголдлыг уучилж, сайжруулахын төлөө чин сэтгэлийн хүч чармайлт гаргахыг эрэлхийлэх хэрэгтэй.

- Нөхөр эхнэрүүд “Намайг уучлаарай” гэж хэлэн өөрсдийнхөө дутагдал доголдлын төлөө бие биенээсээ уучлал гуйх нь яагаад чухал вэ?
- Зарим үед уучлал гуйх нь яагаад хэцүү байдаг вэ? (Аминч үзэл болон бардамнал саад тотгор учруулдаг, эсвэл зарим үед бид өөрсдийнхөө асуудлуудын төлөө бусдыг буруутгадаг гэх зэрэг нь хариултууд байж болно.)
- Бусдыг уучлахыг эрэлхийлэх хүч чадлыг бид хэрхэн олж болох вэ?

Бид уучлалыг эрэлхийлэх үед өөрчлөх хүч чармайлтыг чин сэтгэлээсээ гаргах нь чухал, түүнчлэн шаардлагатай бол нүглээ наманчлах нь чухал гэдгийг онцлон хэл. Өөрсдийн үйлдлүүдийн төлөө зөвхөн харамсал илэрхийлэх нь хангалттай биш; бусдаар уучлуулахын тулд, бас Их Эзэний өршөөлд зохистой байхын тулд бид ажиллах хэрэгтэй.

- Сайжрах хүч чармайлт гаргахгүйгээр уучлалыг эрэлхийлэхийн аюул юу вэ?

Та энэ хичээлийн энэ хэсгийн дүгнэлтийг хийхдээ, дараах үнэн түүхүүдээс нэгийг нь, эсвэл хоёуланг нь хуваалц:

Нэг эрэгтэй эхнэр, хэдэн найзынхаа хамт нэг оройг гэрээсээ гадуур өнгөрөөсний дараа эхнэр нь нэг л хачин таг дуугүй болчихыг ажиглажээ. Ямар нэгэн таагүй зүйл болов уу гэж нөхөр нь түүнээс асуухад, тэр үдшийн үеэр нөхөр нь түүн рүү хандсан хэд хэдэн түүхийг ярих үеэр тэр ичиж, гомдсон гэдгээ тайлбарласан аж. Эхлээд нөхөр нь өөрийнхөө үйлдлүүдийг хамгаалж, энэ бол ердөө л наргиан байсан, хүн бүр цагийг аятай сайхан өнгөрүүлэхийг л тэр хүссэн, түүнчлэн эхнэр нь үүнд хэтрүүлж хариу үйлдэл үзүүлсэн хэрэг гэж хэлжээ. Гэвч тэд ярилцах үед нөхөр нь түүнийг үнэхээр гомдоосноо мэджээ. Тэрээр нэн их харамсаж, түүний тэнэг үйлдэл эхнэрийг нь олон удаа гомдоосныг мэдсэн аж. Тэрээр уучлалт гуйж, түүнийг дахин ичээхгүй гэж амлажээ. Тэр хэлсэн үгэндээ хүрсэн аж. Түүнээс хойш тэрээр эхнэрээ бусдын дэргэд чин үнэнээсээ магтах арга замыг мэддэг болсон ажээ.

Эцэг бас нөхөр болсон нэг эрэгтэй өсвөр насандаа порнографид орооцолдож, улмаар энэ зуршлаа орхиогүй байв. Тэрээр үүнийг хэрхэн орхихоо мэдэхгүй байсан болохоор санаагаар унах болжээ. Эцэст нь, тэрээр тусламжийн төлөө хичээнгүйлэн залбирч, өөрийгөө даруусган, улмаар Аврагчийн амьдрал, заадаг зүйлүүдийг судалж эхэлжээ. Аврагчийн Цагаатгалаар дамжуулан санал болгогддог адислалуудын тухай тэрээр илүү ихийг ойлгосон үедээ, өөрийн зан авирыг өөрчлөх нь түүний хувьд боломжтойг мэдсэн аж. Донтолт нь түүнийг өөрийг нь, гэрлэлтийг нь, бас гэр бүлийг нь сүйрүүлж байгааг тэрээр харжээ. Есүс Христийн үүрэг зорилгын тухай түүний шинэ ойлголт нь шаардлагатай өөрчлөлт хийх боломжийг түүнд олгож, гэрлэлтийг нь аварчээ.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад үйлчилж байхдаа Ахлагч Спенсер В.Кимбаллын хийсэн дараах мэдэгдлийг хуваалц:

“Уучлал бүрд нэгэн нөхцөл байдал байдаг. Боолт нь өвчтэй газрыг бүрэн таглах хэмжээтэй байх ёстой. Мацаг барилт, залбирлууд, даруу байдал нь үйлдсэн нүгэлтэй адил хэмжээтэй буюу түүнээс илүү их байх ёстой. Харуусан зүрх, гэмшсэн сэтгэл байх ёстой. Үнсэн дээр таар нөмрөх нь байх ёстой. Үнэнхүү нулимс, зүрх сэтгэлийн жинхэнэ өөрчлөлт байх ёстой. Нүглийн шийтгэл, хилэнцийг таягдан хаях, Их Эзэнээр зохих ёсоор тавигдсан эрх мэдэлтнүүдэд алдаагаа хүлээн гэмших нь байх ёстой. Алхаа гишгээ, явах чиглэл, хүрэх газраа өөрчлөх шийдэмгий, баттай нөхөн сэргээлт байх ёстой. Нөхцөлүүдийг хамтын хүч чармайлтаар хянаж, залруулах буюу өөрчилж байх ёстой. Дээлээ угааж, цагаан болгох нь, түүнчлэн шинэ зориуллага хийгээд Бурханы бүх хуулиудад бүхнээ зориулах нь байх ёстой, өөрийгөө, нүглийг мөн дэлхийг даван туулах нь байх ёстой” (*The Miracle of Forgiveness* [1969], 353).

Эхнэр нөхрүүд бие биенээ уучлахыг эрэлхийлж байх хэрэгтэй.

Бид үйлдсэн нүгэл, гаргасан алдааныхаа төлөө уучлалт гуйхыг эрэлхийлэхээс гадна, бид өөрсдөө бас уучлуулах хэрэгтэйг онцлон хэл. Заримдаа хүмүүсийн хийдэг ялигүй жижиг зүйлүүд биднийг гомдоож болно, гэвч бие биенээ уучилж байхыг Их Эзэн бидэнд зарлигласан билээ. Сургаал ба Гэрээ 64:8–10, Матай 6:14–15-ыг оролцогчидтой хамт унш.

- Нөхөр эхнэрүүд бие биенээ уучлах хүсэлтэй байх үед гэрлэлт ямар байдлаар бэхэждэг вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли зөвлөхдөө: “Хэрэв өөр хүнд хандсан дайсагналлын хорт охийг зүрх сэтгэлдээ тэжээдэг хэн нэгэн байдаг бол, уучлах хүч чадлыг Их Эзэнээс гуйхыг би та нараас хүсч байна. Хүслийн энэхүү илэрхийлэл та нарын наманчлалын гол утга учир байх болно. Энэ нь амар хялбар биш байж болно, мөн энэ нь хурдан ирэхгүй байж болно. Гэвч хэрэв та нар үүнийг чин сэтгэлээсээ эрэлхийлж, үүнийг тарьж суулгах юм бол, энэ нь *ирэх болно*. . . . Хүрэхийн аргагүй мэт санагдаж байсан амар амгалан зүрх сэтгэлд тань ирэх болно” гэжээ (*Ensign*, 1991 оны 6-р сар, 5; мөн түүнчлэн *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага*, хуудас 26-г үз).

- Уучлах нь заримдаа яагаад хэцүү байдаг вэ? (Хүмүүс ирээдүйд гомдсон байхаас өөрсдийгөө хамгаалахыг хичээх, уучлал бол гашуун, хор хөнөөлтэй үйлдэлтэй адил гэж хүмүүс боддог, эсвэл бусдыг гомдоодог зан авираа даван туулах хүч чармайлт огт гаргалгүйгээр уучлалыг хүсэн хүлээдэг хүнийг уучлах нь хүмүүст хэцүү байдаг зэрэг нь хариултууд байж болно.)
- Уучлахаас татгалздаг нөхөр, эхнэрүүдийн аюул юу вэ?
- Уучлал нь уучлуулж байгаа хүмүүсийг ямар арга замаар адисалдаг вэ? Бусдын уучлал нь хүсэшгүй зан авираа өөрчлөхөд нь хүнд хэрхэн тусалж болох вэ?
- Уучлалын сүнс, уучилж байгаа хүнийг ямар арга замаар адисалж болох вэ?

Бусад хүмүүс бидэнд буруу зүйл хийсэн гэж бид бодож байвал, үүнд хэрхэн хандахыг Их Эзэн биднээс хүсэх вэ гэдгийг бид өөрсдөөсөө асуух ёстойг зөвлөмж болго. Сүмийн 14 дэх Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Ховард В.Хантер: “Бид ариун зүйлүүдийн талаар илүү их бодож, Аврагч өөрийн шавь нарыг хэрхэн үйлдэхийг хүсдэг байсантай илүү адилхнаар үйлдэх ёстой. Бид боломж гарах бүрийд, ‘Есүс яах байсан бол?’ гэж өөрсдөөсөө асууж, тэгээд хариултан дээр илүү зоригтойгоор ажиллах ёстой” хэмээн зөвлөжээ (*Conference Report*, 1994 оны 10-р сар, 118; *Ensign*, 1994 оны 11-р сар, 87).

Сүмийн зургаа дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитийн дараах зөвлөгөөг унш:

“Бид бүгдэд сул талууд бас бүтэлгүйтлүүд байдаг. Зарим үед нөхөр нь эхнэрийнхээ бүтэлгүйтлийг хараад, үүнийх нь төлөө түүнийг буруутгадаг. Зарим үед эхнэр нь нөхрөө зөв зүйл хийсэнгүй гэж бодоод, тэрээр түүнийг буруутгадаг. Үүний ашиг юу вэ? Уучилбал дээр биш үү? Энэрэл дээр биш үү? Хайр дээр биш үү? Дутагдлын тухай ярихгүй байж, сул талыг дэвэргэн, дахин дахин сэдрээхгүй байх нь дээр биш үү? Ингэх нь дээр биш үү? Мөн өөрсдийнхөө хоорондох шинэ бөгөөд үүрдийн гэрээгээр холбогдсон хүүхдүүдийнхээ төрөлтийн хоорондох хэлхээ холбоог гагнан бэхжүүлж, бие биенийхээ сул тал, дутагдлуудыг дурдахаа мартаж нь та нарын хувьд илүү бат найдвартай байх бус уу? Алдаа дутагдлыг анзаарахгүй байж, тэдгээрийн талаар огт ярихгүй—тэдгээрийг булшилж, нэг нэгнийхээ тухайд өөрсдийн мэддэг, боддог зөвхөн сайн зүйлүүдийн тухай ярьдаг байж, ийнхүү бие биенийхээ дутагдал доголдуудыг хав дарж, тэдгээрийг дэвэргэхгүй байх нь дээр биш үү; энэ чинь л дээр биш үү” (“*Sermon on Home Government*,” *Millennial Star*, 1912 оны 1-р сарын 25, 49–50).

Дүгнэлт

Ахлагч Спенсер В.Кимбаллын дараах мэдэгдлийг хуваалц:

“Хичнээн их тайвшрал вэ! Хичнээн их тайтгарал вэ! Хичнээн их баяр хөөр вэ! Хэрэв тэд Их Эзэнд хандаж, түүний тухай мэдэж, түүнчлэн түүний зарлигуудыг сахих юм бол зөрчил, харамсал хийгээд нүглийн ачаа дарамт уучлагдан, ариусгагдаж, бас цэвэршигдэж болно. Тиймээс бид бүгд өдөр тутмынхаа тэнэглэл хийгээд сул талуудыг энэхүү гайхамшиг дотор хуваалцан наманчлах хэрэгтэй” (*The Miracle of Forgiveness*, 368).

Сүнсээр өдөөгдсөний дагуу, гэрлэсэн хосууд бие биенийхээ алдаа дутагдлыг уучилдаг байвал, тэд амар амгалан байх болно гэдгийг гэрчил. Тэд илүү эв нэгдэлтэй болж, гэрлэлт хийгээд эцэг эхийн хувьд тохиолддог бэрхшээлүүдийг шийдвэрлэж чаддаг болно. Гэр орондоо уучлалын сүнсийг тэтгэн тордоход оролцогчдыг урь.

Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын хуудас 25–27-г үз. Оролцогчдыг (1) “Хэрэгжүүлэхэд Зориулсан Санаанууд” дахь зөвлөмжүүдээс доод тал нь нэгийг дагаж, (2) Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн “Уучлах нь Та Нараас Шаардагдана” өгүүллийг уншиж“ энэ хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудыг нэгтгэн дүгнэхэд нь урамшуулан дэмж. Гэрлэсэн хосууд судлах гарын авлага дахь өгүүллүүдийг хамтдаа уншиж, ярилцсанаар ашиг тусыг олж болохыг онцлон хэл.

Судлах гарын авлагуудаа дараагийн хичээлд ангид авчрахыг оролцогчдод сануул.

Зорилго

Гэр орондоо санхүүгийн эрүүл зохицуулалтыг хэрэгжүүлэхэд нь оролцогч-дод туслах.

Бэлтгэл

1. “Багшийн Хувьд Таны Үүрэг Хариуцлагууд” дахь (энэ гарын авлагын хуудас х–хiii) зарчмуудыг хэрэглэж болох арга замуудыг бодож үз.
 2. Энэ хичээлийн тодоор бичсэн гарчгуудыг унш. Эдгээр гарчгууд энэ хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудын тоймыг өгдөг. Түүнээс гадна, *Гэр Бүл ба Гэрлэлтийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын* хуудас 21 дэх Ерөнхийлөгч Н.Элдон Таннерын “Өөрчлөлт дэх Тогтвортой Байдал” өгүүллийг анхааралтайгаар судал. Энэ өгүүлэл дэх зарчмууд бол энэ хичээл дэх нэн тэргүүнд анхаарал төвлөрүүлэх зүйл мөн. Бэлтгэлийнхээ нэг хэсэг болгон, эдгээр зарчмуудыг долоо хоногийн турш тунгаан бод. Оролцогчдын хэрэгцээг хангахад та юуг онцлон хэлэх ёстойг шийдэхэд Сүнсний удирдамжийг эрэлхийл.
 3. *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага* ангид авчрахыг оролцогчдод сануул. Хичээлийн үед Ерөнхийлөгч Таннерын өгүүллийг иш татах нь тэдэнд хэрэгтэй байх болно.
 5. Хэрэв та хуудас 47 дахь дэх нэмэлт эх сурвалж материалыг ашиглах бол, оролцогч бүрд зориулан хуудас цаас, үзэг буюу харандаа ангид авчир.
-

**Энэ хичээлийг
заах зөвлөмж**

Аз жаргалтай гэрлэлтэд мөнгө санхүүгийн зөв зохицуулалт амин чухал байдаг.

Гэрлэсэн хосыг ангийн өмнө гарч ирэхийг урь (хэнийг урих тухайд бодолтой бай). Ялиггүй жижиг зүйл гэрлэлтийг бэхжүүлэх буюу гэрлэлтийн ноцтой асуудлуудад хүргэж болдгийг та харуулах гэж байгаагаа тайлбарла. Тэгээд мөнгө өргөж харуул.

Мөнгийг ангийн өмнө өөрийнхөө дуудаж гаргасан хүмүүсийн нэгэнд өг.

- Зөвхөн нөхөр буюу эхнэр л гэр бүлийнхээ санхүүг хянадаг бол энэ нь гэрлэлтийн харилцаанд хэрхэн нөлөөлөх вэ?

Оролцогчид энэ асуудлыг хэлэлцсэний дараа мөнгийг буцааж ав.

- Гэр бүлийн санхүүг нэг хүн хянадаггүй буюу эсвэл хүүтэй өр төлбөр нь гэр бүлийн санхүүг хянадаг бол энэ нь гэрлэлтийн харилцаанд хэрхэн нөлөөлөх вэ?

Энэ асуултыг ярилцсаны дараа мөнгийг буцааж өг. Нөхрийнх нь гарт мөнгийг бариулж, нөхрийнхөө гараас барихыг эхнэрээс нь хүс. Мөнгөний зохицуулалт бол хайр дээр тулгуурласан гэрлэлтийн харилцаанд хамгийн чухал

зүйл биш гэдгийг тайлбарла. Гэвч нөхөр, эхнэр хоёр санхүүгээ зохицуулахын тулд хамтран ажиллах юм бол, гэр орондоо дэг журам бий болгох чухал хүч чармайлтдаа эв нэгдэлтэй байх болно. Тэд бас хүнд бэрхшээлдээс урьдчилан сэргийлэх болно. Санхүүгийн нөөцүүдийг гэр бүлийн ашиг сонирхолд хамгийн сайнаар нийцүүлэн анхаарал хяналтгүйгээр зарцуулснаас гэрлэлтэд хамгийн ноцтой зарим асуудал үүсэн бий болдог.

- Нөхөр эхнэр хоёр санхүүгээ зохицуулахад хамтран ажилладаг тохиолдолд гэрлэлт ямар байдлаар бэхэждэг вэ?

Эхнэр нөхрүүд мөнгөний зохицуулалтын үндсэн зарчмуудыг баримтлахын тулд хамтран ажиллах хэрэгтэй.

Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын хуудас 28–31-ыг үз. “Өөрчлөлтийн Доторх Өөрчлөгддөггүй Зүйл (Өөрчлөлт дэх Тогтвортой Байдал)” өгүүллийг тэднээр гүйлгэн уншуулаад Ерөнхийлөгч Н.Элдон Таннерын “эдийн засгийн тогтвортой байдлын таван зарчмыг” олуул. Оролцогчид зарчмуудыг олоход, тэдгээрийг самбар дээр жагсаан бич:

Аравны нэгээ шударгаар төл.
Олдгоосоо багыг зарцуулж амьдар.
Хэрэгцээ, хүсэл хоёроо ялгаж сур.
Төсөв боловсруулж, түүнийхээ хүрээнд амьдар.
Санхүүгийнхээ бүх ажил хэрэгт үнэнч шударга бай.

Та бүх таван зарчмыг самбар дээр жагсаан бичээд, тэдгээрийн талаар ярилцахдаа дараах материалыг ашигла:

Аравны нэгээ шударгаар төл.

Ерөнхийлөгч Таннерын дараах мэдэгдлийг нэг оролцогчоор уншуул (*Гэр Бүл ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага*, хуудас 29):

“Аравны нэгийг төлөх нь зарлиг, амлалт бүхий зарлиг юм. Хэрэв бид энэ зарлигийг дуулгавартай дагах юм бол, бид ‘эх нутагтаа цэцэглэн хөгжих’ амлалтыг бидэнд өгсөн билээ. Энэхүү цэцэглэн хөгжилт нь эд материалын зүйлүүдээс илүү их зүйлээс бүтдэг—энэ нь сайн эрүүл мэнд, саруул ухаантай байхыг хамарч болно. Энэ бол гэр бүлийн бат бөх байдал хийгээд сүнслэг байдлын өсөлт юм. Одоогоор та нарын доторх аравны нэгээ бүрэн төлдөггүй хүмүүс аравны нэгээ бүрэн төлөхийн тулд итгэлийг эрэлхийлнэ гэдэгт би найдаж байна. Та нар энэ үүргээ Бий Болгогчдоо хандан биелүүлэх юм бол, та нар зөвхөн энэ зарлигт итгэлтэй байдаг хүмүүсийн мэдэх тэрхүү агуу, агуу их аз жаргалыг олох болно” (Conference Report, 1979 оны 10-р сар, 119; *Ensign*, 1979 оны 11-р сар, 81).

- Аравны нэгийг төлөх нь танай гэр бүлд эсвэл таны таньдаг бусад хүмүүст адислалуудыг хэрхэн авчирсан бэ?

Олдгоосоо багыг зарцуулж амьдар.

Ерөнхийлөгч Таннерын дараах мэдэгдлийг уншихыг нэг оролцогчоос хүс (Гэр Бүл ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага, хуудас 29):

“Та өөрийн зарцуулж болохоос илүү их мөнгө олж чадах тийм арга зам байдаггүйг би олж мэдсэн юм. Сэтгэл санааны амар амгаланг хувь хүнд авчирдаг зүйл бол мөнгөний тоо хэмжээ ч биш, бас тэр чинээгээр мөнгөндөө хяналт тавих нь ч биш гэдэгт би итгэн үнэмшсэн юм. Мөнгө дуулгавартай үйлчлэгч, бас хатуухан үүрэг даалгавар өгөгч байж чадна. Багахан илүүдэлтэйгээр амьдралын жишгээ тогтоон мөрддөг хүмүүс, нөхцөл байдлаа хянаж чаддаг. Олдог мөнгөнөөсөө арай багыг зарцуулдаг хүмүүс нөхцөл байдлаа хянаж чаддаг. Тэд үүрэг хүлээдэг. Ерөнхийлөгч Хебер Ж. Грант нэг удаа хэлэхдээ: ‘Хэрэв хүмүүний зүрх сэтгэлд, мөн гэр бүлд амар амгалан хийгээд сэтгэл хангалуун байдлыг авчирдаг ямар нэг юм байдаг бол, энэ нь байгаагийнхаа дотор багтаж амьдрах явдал мөн. Түүнчлэн хэрэв дарамт учруулдаг, сэтгэл алдруулж, зүрх үхүүлдэг ямар нэг зүйл байдаг бол энэ нь төлж чадахгүй өр өглөгтэй байх явдал мөн’ (*Gospel Standards*, эмхтгэсэн. Г.Хомер Дурам [1941], 111).

“Бид олдог мөнгөнөөсөө багыг зарцуулах түлхүүр бол энгийн зүйл—үүнийг сахилга гэж нэрлэдэг. Амьдралын эхэн үед ч байна уу, хожуу үед ч байна уу ялгаагүй, бид бүгд өөрсдийгөө, өөрсдийнхөө дур таашаалыг, түүнчлэн өөрсдийнхөө эдийн засгийн хүслүүдийг сахилгажуулж зайлшгүй сурах болдог. Олдгоосоо багыг зарцуулж суран, хүнд бэрх цагт зориулж, ямар нэг юмыг нөөцөлж хадгалдаг хүн хичнээн ихээр адислагдсан билээ” (*Conference Report*, 1979 оны 10-р сар, 119; *Ensign*, 1979 оны 11-р сар, 81-ийг үз).

Сүмийн арвантав дахь Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн дараах мэдэгдлийг хуваалцахад анхаар:

“Гэр орноо эмх цэгцэд оруулах цаг болжээ.

“Манай хүмүүсийн олонх нь орлогынхоо дээд хязгаараар амьдарч байна. Үнэн хэрэг дээрээ, зарим хүмүүс зээлээр амьдарч байна. . . .

“Улс орны хүмүүс, түүний дотор манай өөрийн хүмүүсийг нөмөрсөн хэрэглээний зүйлс зээлээр худалдаж авсны асар их хэмжээний өр төлбөрийн тухайд миний санаа ихэд зовдог. . . .

“Санхүүгийнхээ байдлыг . . . анхаарч үзэхийг би та нараас шаргуу хүсч байна. Үрлэг зарлагадаа даруухан байхыг; зээлээр худалдаж авах зүйлд өөрсдийгөө сахилгажуулж, өр зээл тавихаас боломжийнхоо хэрээр зайлсхийхийг би та нараас шаргуу хүсч байна. Өрийг чадах чинээгээрээ хурдан төлж дуусган, өөрсдийгөө боолчлолоос чөлөөл” (*Conference Report*, 1998 оны 10-р сар; 70, 72; *Ensign*, 1998 оны 11-р сар, 53–54).

- Өр ямар байдлаар боолчлол байдаг вэ?
- Ямар дадал зуршил өрнөөс гарах буюу өрөнд орохоос зайлсхийхэд та нарт тусалсан бэ? Орлогынхоо багахан хэсгийг хэмнэн хадгалах боломжтой байхын тулд та нар юу хийсэн бэ?

Хэрэгцээ, хүсэл хоёроо ялгаж сур.

Ерөнхийлөгч Таннерын дараах мэдэгдлийг нэг оролцогчоор уншуул (*Гэр Бүл ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага*, хуудас 30):

“Хэт дураараа аашлах болон мөнгөний муу зохицуулалт гэрлэлтийн харилцааг ноцтойгоор муутгадаг. Гэрлэлтийн ихэнх асуудлууд эдийн засгийн үндэс суурьтай—нэг бол гэр бүлийг тэтгэх орлого хангалтгүй байх, нөгөө бол олсон орлогоо буруу зарцуулдагас үүдэлтэй байдаг бололтой” (Conference Report, 1979 оны 10-р сар, 119–20; *Ensign*, 1979 оны 11-р сар, 81).

- Хэрэгцээ болон хүслийг ялгахын тулд бид юу хийж болох вэ? Үүнийг эхнэр нөхөр хоёр хамтдаа хийх нь яагаад чухал вэ?

Төсөл боловсруулж, түүнийхээ хүрээнд амьдар.

Тэдний нөөц боломж ямар байх нь хамаагүй, гэрлэсэн хос бүр гэр бүлийн төсөв боловсруулж, мөрдөхийн тулд хамтран ажиллах хэрэгтэйг тайлбарла. Төсөв бол тодорхой хугацаан дахь төлөвлөгдсөн орлого, зарлагын нэгтгэсэн товчоо юм. Энэ нь зарлагыг орлогоос хэтрүүлэхгүй байлгахад гэр бүлүүдэд тусалдаг. Гэрлэсэн хосууд өөрсдийн хэрэгцээ, хүсэл болон санхүүгийн зорилгыг тодорхойлсны үндсэн дээр төсвөө хэлэлцэх хэрэгтэй. Жишээ нь, дараагийн хоёр долоо хоногийн орлогоо тооцсоны дараа, аравны нэг, Сүмийн бусад хандивууд, хадгаламж, хоол хүнс, барьцаа буюу түрээсийн төлбөр гэхчлэн зүйлүүдэд хичнээн мөнгө хэрэглэхийг гэрлэсэн хос тооцон тогтоож болно. Хоёр долоо хоногийн хугацаанд тэд бүх орлого, зарлагаа бүртгэнэ. Том хэмжээний зүйл худалдаж авах, эсвэл өөрсдийнх нь боловсруулсан төсөвт нөлөөлөх бусад зүйлүүдийг хийхийн өмнө тэд хамтдаа зөвлөлдөх хэрэгтэй. Хоёр долоо хоногийн дараа тэд жинхэнэ орлого зарлагаа анхны төсвийн төлөвлөгөөтэй харьцуулна.

Төсөв хэрхэн боловсруулахыг ойлгоход нь оролцогчдоод туслахын тулд *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага*, хуудас 32-т байгаа, дараах загвар төсөвт тэдний анхаарлыг хандуул.

Ерөнхийлөгч Таннерын дараах мэдэгдлийг уншуулахаар нэг оролцогчийг урь (*Гэр Бүл ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага*, хуудас 31):

“Олон жилийн турш олон хүмүүстэй хийсэн ярилцлагаасаа ажиглахад хэтэрхий олон хүмүүс бодитой сайн төсөв хийдэггүй, түүнчлэн үүний заалтуудыг мөрдөхийн тулд өөрсдийгөө сахилгажуулдаггүй нь мэдэгдсэн билээ. Төсөв тэдний эрх чөлөөг боогдуулдаг гэж олон хүмүүс боддог. Харин ч үүний эсрэгээр, төсөв нь эдийн засгийн эрх чөлөөг бодит боломж болгодгийг амжилтад хүрсэн хүмүүс мэддэг” (Conference Report, 1979 оны 10-р сар, 121; *Ensign*, 1979 оны 11-р сар, 82).

Санхүүгийнхээ бүх ажил хэрэгтээ үнэнч шударга бай.

Ерөнхийлөгч Таннерын дараах мэдэгдлийг уншихыг нэг оролцогчоос хүс (*Гэр Бүл ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага*, хуудас 31):

“Шударга зарчимч байдлын төгс чанар хэзээ ч арилж үгүй болохгүй. Энэ нь бидний хийдэг бүх зүйлд хамаатай. Бид сүмийн удирдагчид хийгээд гишүүдийн хувьд шударга зарчимч байдлын загвар байх ёстой” (Conference Report, 1979 оны 10-р сар, 121; *Ensign*, 1979 оны 11-р сар, 82).

он сар өдөр	аас	он сар өдөр	хүртэлх төсөв																																																															
<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <tr> <td style="width: 50%;">ОРЛОГО</td> <td style="width: 25%;">ТӨЛӨВЛӨСӨН</td> <td style="width: 25%;">ЖИНХЭНЭ ГҮЙЦЭТГЭЛ</td> </tr> <tr> <td>Татварын дараах цалин</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Бусад орлого</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Нийт орлого</td> <td></td> <td></td> </tr> </table>	ОРЛОГО	ТӨЛӨВЛӨСӨН	ЖИНХЭНЭ ГҮЙЦЭТГЭЛ	Татварын дараах цалин			Бусад орлого			Нийт орлого			<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <tr> <td style="width: 50%;">ЗАРЛАГУУД</td> <td style="width: 25%;">ТӨЛӨВЛӨСӨН</td> <td style="width: 25%;">ЖИНХЭНЭ ГҮЙЦЭТГЭЛ</td> </tr> <tr> <td>Аравны нэг</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Сүмийн бусад хандивууд</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Урт хугацаатай хадгаламж</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Тусгай хадгаламжууд</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Хоол хүнс</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Барьцаа буюу түрээсийн төлбөр</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Хэрэглээний зардал</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Тээвэр</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Өр төлбөр</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Даатгалууд</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Эмнэлгийн зардал</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Хувцас</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Бусад</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Бусад</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Бусад</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Нийт зардал</td> <td></td> <td></td> </tr> </table>			ЗАРЛАГУУД	ТӨЛӨВЛӨСӨН	ЖИНХЭНЭ ГҮЙЦЭТГЭЛ	Аравны нэг			Сүмийн бусад хандивууд			Урт хугацаатай хадгаламж			Тусгай хадгаламжууд			Хоол хүнс			Барьцаа буюу түрээсийн төлбөр			Хэрэглээний зардал			Тээвэр			Өр төлбөр			Даатгалууд			Эмнэлгийн зардал			Хувцас			Бусад			Бусад			Бусад			Нийт зардал		
ОРЛОГО	ТӨЛӨВЛӨСӨН	ЖИНХЭНЭ ГҮЙЦЭТГЭЛ																																																																
Татварын дараах цалин																																																																		
Бусад орлого																																																																		
Нийт орлого																																																																		
ЗАРЛАГУУД	ТӨЛӨВЛӨСӨН	ЖИНХЭНЭ ГҮЙЦЭТГЭЛ																																																																
Аравны нэг																																																																		
Сүмийн бусад хандивууд																																																																		
Урт хугацаатай хадгаламж																																																																		
Тусгай хадгаламжууд																																																																		
Хоол хүнс																																																																		
Барьцаа буюу түрээсийн төлбөр																																																																		
Хэрэглээний зардал																																																																		
Тээвэр																																																																		
Өр төлбөр																																																																		
Даатгалууд																																																																		
Эмнэлгийн зардал																																																																		
Хувцас																																																																		
Бусад																																																																		
Бусад																																																																		
Бусад																																																																		
Нийт зардал																																																																		

- Үнэнч шударга чанар яагаад бидний бүх санхүүгийн ажил хэргийн чухал хэсэг байдаг вэ? Эхнэр нөхөр хоёрын хоорондох үнэнч шударга чанар гэр бүлийн санхүүд яагаад амин чухал шаардлагатай байдаг вэ?

Дүгнэлт

Эхнэр нөхрүүд санхүүгээ зохицуулахын тулд хамтран ажиллах ёстойг онцлон хэл. Хичээлийн үед ярилцсан зарчмуудыг тэд хэрхэн сайн баримталдгийг нь оролцогчдоос асуу. Мөнгөнийхөө зохицуулалтыг сайжруулах төлөвлөгөө хийхэд тэднийг урь.

Сүнсээр өдөөгдсөний дагуу, хичээлээр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага, хуудас 28–32-ыг үз. (1) “Хэрэжүүлэхэд Зориулсан Санаанууд” дахь зөвлөмжүүдээс доод тал нь нэгийг дагаж, (2) Ерөнхийлөгч Н.Элдон Таннерын “Өөрчлөлт дэх Тогтвортой Байдал” өгүүллийг уншиж, энэ хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудыг нэгтгэн дүгнэхэд нь оролцогчдыг урамшуулан дэмж. Гэрлэсэн хосууд судлах гарын авлага дахь өгүүлүүдийг хамтдаа уншиж, ярилцсанаар ашиг тус олж болохыг анхааруулан хэл.

Нэмэлт Эх Сурвалж Материал

Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцааны цуврал хичээлийн А хэсэг дэх хичээлүүдийн тойм

Энэ хичээл Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцааны цуврал хичээлийн А хэсгийг нэгтгэн дүгнэдэг. Хэрэв та цуврал хичээлүүдийг бүхэлд нь зааж байгаа бол, дараах дасгалыг ашиглахыг бод:

Оролцогч бүрд хуудас цаас, харандаа буюу үзэг өг. Энэ цуврал хичээлийн эхний найман хичээлээс өөрсдийн санаж байгаа сургаалууд болон зарчмуудыг жагсаан бичихэд гурван минут зарцуулахыг оролцогчдоос хүс. Тэдний хувьд хамгийн утга учир бүхий сургаалууд буюу зарчмуудыг доогуур нь зуруул. Тэдний доогуур нь зурсан зүйлүүдийн заримых нь тухай ярихад бэлтгэхийг нь тэдэнд урамшуулан дэмж. Хэрэв тэдэнд туслалцаа хэрэгтэй бол, энэ гарын авлагын агуулгын товъёог, хуудас v–viii-ийг ашиглах буюу *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага* дахь хуудас vii–viii дахь цуврал хичээлийг тоймлон дүгнэ.

Гурван минутын дараа оролцогч тус бүрээс өөрийнхөө жагсаалтаас нэг зүйлийг уншихыг, түүнчлэн энэ нь чухам яагаад утга учиртай болохыг тайлбарлахыг хүс. Оролцогчдын ойлголтыг самбар дээр хураангуйлан дүгнэж, санал дүгнэлт бүрийн ач холбогдлыг үнэл. Тэгээд өөрийн ойлголтыг хуваалц. Цаг гарвал энэ дасгалыг давтан хий.

Энэ цуврал хичээлийн эхний хэсэгт оролцсоны төлөө заадаг хүмүүстээ талархал илэрхийл.Цуврал хичээлийн хоёр дахь хэсэг эцэг эхчүүд гэр бүлээ хэрхэн бэхжүүлэх хийгээд өөрсдийн үүрэг хариуцлагуудад баяр баясгаланг хэрхэн олох тухай найман хичээлээс бүрддэгийг тайлбарла. Хичээлд үргэлжлэн оролцуулахын тулд бүх оролцогчдод баяр хүргэ.

Хэсэг Б
ГЭР БҮЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЭЦЭГ
ЭХИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГУУД



“ҮР ХҮҮХЭД БОЛ ИХ ЭЗЭНИЙ ӨВ ЮМ”

Хичээл

9

Зорилго

Дэлхийн эцэг эхчүүд Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийг гэр орондоо ирэхэд баяртай угтаж, тэднийг хайрлах, тэднийг энхрийлэх, тэдэнд заах, түүнчлэн тэднийг мөнхийн амьдрал уруу хөтлөх үүрэг хариуцлагыг өөрсөд дээрээ хүлээдгийг оролцогчдод сануул.

Бэлтгэл

1. Та өөрийгөө заахад бэлтгэхдээ “Багшийн Хувьд Таны Үүрэг Хариуцлагууд” дахь (энэ гарын авлагын хуудас ix–xiii) зарчмуудыг хэрэглэж болох арга замуудыг эрж хай.
2. Хичээлийн тод гарчгуудыг унш. Эдгээр гарчгууд хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудын тоймыг өгдөг. Бэлтгэлийнхээ нэг хэсэг болгон эдгээр сургаалууд болон зарчмуудыг хэрэглэхэд нь оролцогчдод туслах арга замуудыг тунгаан бод. Оролцогчдын хэрэгцээг хангахын тулд та юуг онцлон хэлэх ёстойг шийдэхэд Сүнсний удирдамжийг эрэлхийл.
3. Хүүхдийн Хэсгийн хэдэн хүүхдийг энэ хичээл дээр ирж, “Би Бурханы Хүүхэд” дууг хичээлийн эхэнд дуулж өгөхийг урьдчилан хүс (*Сүмийн Дуулал болон Хүүхдийн Дуу*, х.58). Эсвэл уг дууг оролцогчдоор дуулуулахаар бэлтгэ.
4. Хүүхдүүд нь тэдний амьдралд авчирдаг баяр баясгалангийн тухай товч яриулахаар нэг юм уу хоёр оролцогчийг урьдчилан урь. Танилцуулгынхаа нэг хэсэг болгон хувийн туршлагуудаасаа хуваалцахыг тэдэнд санал болго. Энэ даалгаврыг та хэнд өгөхөө шийдэхэд Сүнсний удирдамжийг эрэлхийл.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Тэнгэрлэг Эцэг Өөрийн сүнсэн хүүхдүүдийг дэлхийн эцэг эхчүүдэд итгэл хүлээлгэн өгдөг

“Би Бурханы Хүүхэд” дууг дуулахыг Хүүхдийн Хэсгийн хүүхдүүдээс хүс (“Бэлтгэл,” зүйл 3-ыг үз). Дууны дараа хүүхдүүдийг Хүүхдийн Хэсгийн хичээлд тэр даруй буцааж явуул. Хэрэв та Хүүхдийн Хэсгийн хүүхдүүдийг ангид ирж дуулахыг хүсээгүй бол уг дууг өөртэйгөө хамт дуулахад ангийн гишүүдийг урь.

- Ямар үнэнүүд энэ дуунд заагддаг вэ?
- Эцэг эхчүүдийн үүрэг хариуцлагын тухай бид энэ дуунаас юу сурч болох вэ? (“Надад замаа олоход туслан хөтлөн удирдаач, Түүнтэй амьдрахын тул, Би юу хийхийг заагаач” гэсэн дахилтын үгсэд анхаарал хандуул)

Сүмийн 15 дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли зөвлөхдөө: “Эдгээр бяцхан хүүхдүүд Бурханы хөвгүүд охид гэдгийг, түүнчлэн тэдэнтэй харьцаж тэднийг асран хүмүүжүүлэх нь, та нар эцэг эхчүүд байхаас өмнө Тэрээр эцэг байсныг, Тэрээр Өөрийн эдгээр бяцхан хүүхдүүдийн

хувьд Эцэгийн эрх үүрэг буюу тэднийг сонирхох сонирхлоо шилжүүлж өгсөн хэрэг биш гэдгийг хэзээ ч бүү март. Ийм болохоор, тэднийг хайрла, тэдэнд анхаарал халамж тавь. Эцгүүд ээ, зан авиртаа хяналт тавь, эдүгээ, бас ирэх бүх тэр жилүүдэд. Эхчүүд ээ, дуу хоолойгоо хяна; үүнийг намуун зөөлхөн байлга. Хүүхдүүдээ хайраар, халамжаар түүнчлэн Их Эзэний сануулга зөвлөгөөгөөр өсгөн хүмүүжүүл. Бяцхан хүүхдүүдээ анхаарал халамж тавь. Тэднийг гэр орондоо баяртай хүлээн авч, тэднийг бүх зүрх сэтгэлээрээ халамжилж, хайрлагтун” гэжээ (“Excerpts from Recent Addresses of President Gordon B. Hinckley,” *Ensign*, 1997 оны 7-р сар, 73).

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Рассел М.Баллард сургамжлахдаа: “Хүмүүн болгон Бурханы сүнсэн хүүхэд бөгөөд дэлхийд ирэхээсээ өмнө Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдарч байсан юм. Тэрээр өөрийн сүнсэн хүүхдүүдийг дэлхийн эцэг эхчүүдэд итгэмжлэн өгсөн бөгөөд тэд төрөлтийн гайхамшгаар дамжуулан тэднийг зуурдын биеэр хангаж, хүүхдүүдээ хайрлаж, хамгаалан, тэдэнд заах, түүнчлэн тэд Есүс Христийн цагаатгал хийгээд амилалтаар дамжуулан нэгэн цагт бидний Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд эргэж очихын тулд тэднийг гэрэл ба үнэнд өсгөн хүмүүжүүлэх ариун боломж, үүрэг хариуцлагыг эцэг эхчүүдэд ноогдуулсан билээ” гэжээ (Conference Report, 1991 оны 4-р сар, 104; *Ensign*, 1991 оны 5-р сар, 78).

- Энэхүү мэдлэг хийгээд ойлголт нь эцэг эхчүүдээс хүүхдүүдээ хандах харьцаа хандлагад хэрхэн нөлөөлөх ёстой вэ?

Тэргүүлэх Бишопоор үйлчилж байхдаа өгсөн, Бишоп Роберт Д.Хейлсийн дараах зөвлөгөөг унш: “Хүүхдээ халамжилж, хайрлан, анхаарал санаа тавих болон тэдэнд заах явцад дэлхийн эцэг эхчүүд олон талаар Тэнгэрлэг Эцэгээ төлөөлдөг. Хүүхдүүд Тэнгэрлэг Эцэгийнхээ зан чанараас суралцахын тулд эцэг эхчүүдээ харж дуурайдаг нь зүй ёсны юм. Тэд дэлхийн эцэг эхчүүдээ хайрлаж, хүндлэн, тэдэнд итгэдэг болсны дараа Тэнгэрлэг Эцэгтээ хандсан мөн тийм мэдрэмжүүдийг аяндаа хөгжүүлэх нь олонтаа байдаг” гэжээ (Conference Report, 1993 оны 10-р сар, 10; *Ensign*, 1993 оны 11-р сар, 9).

Эцэг эхчүүдийн харьцаа хандлага, үйл ажиллагаа Тэнгэрлэг Эцэгт хандсан хүүхдийн мэдрэмжүүдэд хэрхэн нөлөөлдгийг тунгаан бодоход оролцогчдыг урь.

Эцэг эхчүүд хүүхэд бүрийн хувийн хэрэгцээг хангахыг эрмэлзэх ёстой.

Хүүхэд бүр өөрийн гэсэн хүсэл, авьяас, хэрэгцээтэй байдгийг тайлбарла. Хүүхэд бүрийн хувийн чадвар, хэрэгцээг ойлгохыг хичээх нь эцэг эхчүүдийн хувьд чухал юм.

Олон хүүхэд эцэг эхчүүдээсээ нилээд их ялгаатай байдаг. Тэдний зан төрхөөр байж болно, түүнчлэн тэд өөр өөр хүч чадал хийгээд сул талуудтай байж болно. Эдгээр ялгаанууд нь тэд өөрсдөө хэзээ ч туулаагүй туршлагаар дамжуулан хүүхдүүдийг удирдаж, тэдэнд туслахад хүндрэл бэрхшээл учруулдаг учир эцэг эхчүүдийг гонсойлгодог байж болно. Гэвч Тэнгэрлэг Эцэг эдгээр хүүхдүүдийг өөрсдөд нь итгэмжлэн өгснийг, түүнчлэн хүүхэд бүрийг өөрийнх нь бурханлиг чадавхийг хэрэгжүүлэхэд хэрхэн удирдахыг мэдэхэд нь Тэрбээр тэдэнд туслах болно гэдгийг эцэг эхчүүд санах ёстой. Хүүхдийн Хэсгийн ерөнхий ерөнхийлөгч асан Майклийн П.Грассли Эгч:

“Бидний хүүхдүүд чухам хэн бэ гэдгийг бид нээж олох хэрэгтэй. Юу тэдний сонирхлыг татдаг, юу тэдний санааг зовоодог, түүнчлэн, хэрэв тэдний хамгийн сайхан мөрөөдөл биелэгдэх юм бол тэд юу хийхийг бид мэдэх хэрэгтэй. Тэдний хамгийн сайхан мөрөөдөл бараг үргэлж гайхамшигтай байдаг. Хүүхдүүдээ эцэг эхийнхээ хуулбар байхыг хүсэн хүлээх биш, тэднийг өөрсдийнхөөрөө байхыг нь бид зөвшөөрөх учиртай. Тэдний сонирхлыг юу татдагийг тэд *нээж олохын* тулд тэдэнд олон янзын туршлага суулгаж, тэгээд дараа нь эдгээр сонирхол, авьяас чадваруудыг—бүр эдгээр нь таныхтай адилгүй байсан ч гэсэн, урамшуулан дэмж” хэмээн хэлжээ (“Teaching Our Children,” *Ensign*, 1994 оны 4-р сар, 62).

- Эцэг эхчүүд, хүүхэд нэг бүрийнхээ зан чанар болон хэрэгцээг ойлгох нь яагаад чухал вэ?
- Эцэг эхчүүд хүүхдийн хувийн авьяас чадвар болон сонирхолд нийцэхгүй үйл ажиллагаа, туршлагаудад хүүхдүүдээ албадах нь ямар хор хохирол учруулж болох вэ?
- Хүүхэд нэг бүрийнхээ авьяас чадварыг хөгжүүлэхийн тулд эцэг эхчүүд юу хийж болох вэ?

Энэ зарчмыг хэрэглэхэд нь оролцогчдод туслахын тулд, нэг гэр бүлийн хүүхдүүд бие биенээсээ болон эцэг эхээсээ ялгаатай байж болох зарим хэлбэрүүдийг жагсаан бичихийг тэднээс хүс. Ингэхдээ, оролцогчид эцэг эхчүүдийн хувиарх өөрсдийн туршлага эсвэл тэд өөрсдийн эцэг эх, үр хүүхдүүдтэй ажилласан туршлага дээрээ тулгуурлаж болно. Тэдний санаануудыг самбар дээр бич. Дараа нь жагсаалт дахь авьяас буюу зан чанаруудыг нэг бүрчлэн ярилц. Дараах маягийн асуултуудыг асуух замаар хувь хүний авьяас, зан чанаруудыг харуул:

- Энэ авьяасыг үргэлжлүүлэн хөгжүүлэхэд хүүхдээ урамшуулан дэмжихийн тулд эцэг эхчүүд юу хийж болох вэ?
- Хэрэв хүүхэд ийм зан чанартай байвал, тэрээр хайрлагч хийгээд эелдэг сайхан зантай байхын тулд эцэг эх нь түүнд юу зааж болох вэ?
- Ийм авьяастай хүүхэд гэр бүлийн үдэшт ямар байдлаар хувь нэмэр оруулж чадах вэ?

Хүүхэд нэг бүрийнхээ чадвар, зан төлвийг ойлгодог эцэг эхчүүд хүүхдүүдээ сахилгажуулах илүү чадвартай байдгийг тэмдэглэн хэл. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад үйлчилж байхдаа Ахлагч Жеймс Е. Фаустын өгсөн дараах зөвлөгөөг нэг оролцогчоор уншуул. (*Гэр Бүл ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага*, хуудас 49):

“Эцэг эхчүүдийн хамгийн хэцүү бэрхшээлүүдийн нэг бол хүүхдүүдийг зохих ёсоор сахилгажуулах явдал мөн. Хүүхэд хүмүүжүүлэх нь нэн өвөрмөц хувийн шинжтэй юм. Хүүхэд бүр өөр өөр, давдагдашгүй өвөрмөц онцлогтой байдаг. Нэг хүүхдэд тохирч байгаа зүйл нөгөөд нь тохирохгүй байж болно. Сахилга бол хэтэрхий хатуу зүйл гэх буюу хүүхдүүдийн эцэг эх нь л юм бол тэднийг хамгийн ихээр энхрийлэн хайрлах л хэрэгтэй шүү дээ гэж хэлдэг хүн ухаалаг гэж би мэдэхгүй юм байна. Энэ бол эцэг эхчүүдийн хувьд залбирлаар ялган таних асуудал юм. Хүүхдийн сахилга шийтгэл дээр биш, хайр дээр үндэслэгдсэн байх нь хүүхдийн хувьд хамгаалах хийгээд

халамжлан хайрлах зарчим байдаг нь тодорхой юм” (Conference Report, 1990 оны 10-р сар, 41; *Ensign*, 1990 оны 11-р сар, 34).

- Сахилгыг хүүхэд бүрийн хэрэгцээ, нөхцөл байдалд тохируулан төлөвшүүлэх ёстойг ойлгоход ямар туршлагауд та нарт тусалсан бэ?

Хүүхдүүд эцэг эхчүүдтэйгээ хайрын харилцаатай байх эрхтэй.

Эцэг эхчүүдийн хийж болох хамгийн чухал зүйлүүдийн нэг бол хайр, нөхөрлөл, аз жаргалын уур амьсгалыг гэр орондоо бий болгох явдал мөн гэдгийг онцлон хэл. Дараах мэдэгдлүүдийг хуваалц:

Ахлагч Гордон Б.Хинкли Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад үйлчилж байхдаа: “Эцэг эхийнхээ хайр халамжийг мэдэрдэг хүүхэд хичнээн азтай, хичнээн их адислагдсан байдаг билээ. Тэрхүү элгэмсэг халуун сэтгэл, тэрхүү хайр ирэх он жилүүдэд амтат сайхан үр жимс өгөх болно” хэмээн хэлжээ (Conference Report, 1978 оны 10-р сар, 25; *Ensign*, 1978 оны 11-р сар, 18).

Далын Ахлагч Марлин К.Женсен хэлэхдээ: “Дэлхий даяар амьдралд хичнээн их байдагчлан, бидний үерхэл нөхөрлөлийн хэрэгцээ гэр оронд л хамгийн сайнаар хэрэгжих нь олонтаа тохиолддог. Хэрэв манай хүүхдүүд бие биентэйгээ, тэрчлэн эцэг эхтэйгээ үерхэл нөхөрлөлийг гэр орондоо мэдрэх юм бол, гэр бүлээс гадуур цөхрөлд хүрэхгүй байх болно” гэжээ (Conference Report, 1999 оны 4-р сар, 81; *Ensign*, 1999 оны 5-р сар, 64).

- Өөрийгөө бусдаар хайрлуулдаг гэж бодоход тусалсан ямар зүйлийг та хүүхэд ахуй үеэсээ эргэн санадаг вэ? Хайрын энэхүү мэдрэмж таны амьдралын бүх үед ямар байдлаар танд нөлөөлсөн бэ?
- Тэд хүүхдүүдээ хайрладаг гэдгийг хүүхдүүд нь мэдэхэд тэдэнд туслахын тулд эцэг эхчүүд гэр орондоо юу хийж болох вэ?

Эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ хайрын харилцаатай байхыг хичээхийн тулд сайн харилцаа амин чухал гэдгийг онцлон хэл. “Илэн далангүй, үнэнч харилцаанаас илүү чухал зүйл гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаанд байдаггүй. Энэ нь ялангуяа хүүхдүүддээ сайн мэдээний зарчмууд болон жишгүүдийг заахыг хичээж буй эцэг эхчүүдийн хувьд үнэн байдаг. Залуучуудтайгаа зөвшилцөх чадвар—магадгүй үүнээс ч илүү ач холбогдолтой нь тэдний сэтгэлийг зовоож буй асуудлыг үнэн голоосоо сонсох нь—амжилт бүхий хэлхээ холбоог бий болгох үндэс суурь юм. Ихэнхдээ бидний нүднээс нь харж, зүрх сэтгэлдээ мэдэрдэг зүйлүүд бидний сонсож, хэлдэг зүйлээс илүү ихийг мэдээлдэг” хэмээн Ахлагч М.Рассел Баллард зөвлөжээ (Conference Report, 1999 оны 4-р сар, 114; *Ensign*, 1999 оны 5-р, 86–87).

- Хүүхдүүдтэйгээ сайн харилцахын тулд эцэг эхчүүд юу хийж болох вэ? (Хариултад дараах жагсаалтад байгаа зүйлүүд байж болно.)

- а. Цуцашгүй сонсогч бай. Шаардлагатай бол, хүүхдүүдийн хэлснээс ойлгосон зүйлээ давтан хэл. Энэ нь та хүүхдүүдийг үнэхээр сонсдогийг, түүнчлэн та тэднийг ойлгодгоо харуулахад танд туслах болно.
- б. Хүүхдүүд бүр бага насных байлаа ч гэсэн тэдэнтэй ярилцаж, тэдний хэлэхийг—бүр тэд ярих чадвартай болохоос нь өмнө ч, сонсох цаг гарга.
- в. Тэдний санаануудыг сонирх.
- г. Хоолны үеэр яриа өрнүүл.
- д. Тэдэнтэй ганцаарчлан ярилцахад цаг зарцуул.

Хүүхэд нэг бүртэйгээ хамт өнгөрүүлэх цаг гаргахыг эцэг эхчүүдэд онцгойлон хэлэхийн тулд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Роберт Д.Хейлсийн дараах зөвлөгөөг хуваалц: “Хүүхдүүдээрээ үйл ажиллагаа болон ярианы сэдвийг сонгуулж, хүүхдүүдтэйгээ хамт цагийг биечлэн өнгөрүүл. Саад болж байгаа зүйлүүдийг зайлуул.” (Conference Report, 1999 оны 4-р сар, 41; *Ensign*, 1999 оны 5-р сар, 33).

Сайн харилцааны зарчмуудын тухай нэмэлт санаануудыг хичээл 5-ын 28–31 хуудсуудаас үз.

Хүүхэдтэй зүй бусаар харьцах нь Бурханыг гомдоодог.

Матай 18:6-г оролцогчидтой хамт унш. Эцэг эхчүүд хүүхдүүдтэй ямар ч байдлаар, хэзээ ч зүй бусаар харьцах ёсгүйг тайлбарла.

- Хүүхэдтэй зүй бусаар харьцах зарим хэлбэрүүд юу вэ? (Оролцогчдын хариултуудыг самбар дээр жагсаахад анхаар. Дараах жагсаалтан дахь зүйлүүд хариултууд байж болно.)
 - а. Хэрцгий уур
 - б. Хашгирч зандрах
 - в. Сүрдүүлэх
 - г. Зодох, гар хүрэх
 - д. Бэлгийн харилцааны аливаа хавьтгалт буюу зохисгүйгээр биенд хүрэх
 - е. Басамжилж дорд үзсэн үг яриа
 - ё. Хайрлахаа болих
 - ж. Зохимжгүй кино, шог наргиа үгс, үг хэллэг, зохисгүй сэтгүүлүүд буюу интернетийн материал үзэх
 - з. Химийн бодисуудыг зүй бусаар хэрэглэх
 - и. Хайхрамжгүй байх, түүний дотор эрүүл мэнд эмнэлгийн талаар зохих ёсоор анхаарахгүй байх, хяналт, сахилга хангалтгүй байх

- Эдгээр үйлдлүүд ямар байдлаар хүүхдүүдэд хор хохирол учруулах вэ?

Энэ асуултыг ярилцсаны дараа, хүүхэд ахуй үед нь тэдэнтэй буруу харьцдаг байсан насанд хүрэгчид заримдаа, ийм зан авир хичнээн хор хөнөөлтэйг мэдэлгүй, хүүхдүүдтэй мөн тийм сөрөг байдлаар харьцдагийг тайлбарла. Зарим үед тэд өөрсдийнхөө зан авирыг ч өөрчлөх чадваргүйгээ мэдэрч болно. Хэрэв тэд Их Эзэний туслалцаа болон удирдамжийг даруухнаар эрэлхийлэх юм бол, зүй бусаар харьцдаг хүмүүс зан авираа өөрчилж чадна гэдгийг онцлон хэл.

Өөрсдийн зүй бус харьцдаг зан авирыг ойлгож, өөрчлөхөд туслалцаа хүсдэг хүмүүс бишоптоо хандаж болно. Тэрээр тэдэнд зөвлөх боломжтой байх болно. Тэрээр ХҮГС-ийн Гэр Бүлийн Үйлчлэлийн зөвлөхүүд хийгээд Сүмийн жишгүүдэд нийцдэг зөвлөмжөөр хангадаг олон нийтийн эх сурвалжуудыг бас санал болгож болно.

Сургаал ба Гэрээ 121:41–44-ийг оролцогчидтой хамт унш.

- Энэ хэсэг эцэг эхчүүд хүүхдүүдээ сахилгажуулдаг аргад ямар байдлаар холбогдож байна вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөхөөр үйлчилж байхдаа:

“Хүүхдүүдийг зодох хэрэггүй. Тэдэнд хайр, урамшуулал хэрэгтэй. Айх биш, харин хүндэтгэлтэйгээр өөдөөс нь харах эцгүүд тэдэнд хэрэгтэй, юуны түрүүнд, үлгэр дуурайл тэдэнд хэрэгтэй. . . .

“Миний гуйлт бол . . . хүүхдүүдийг аврах хүсэл. Тэдний олонх нь өвчин зовлон, айдас түгшүүр, ганцаардал хийгээд арга тасарч, цөхөрсөн байдалтай явцгаадаг. Хүүхдүүдэд нарны гэрэл, гэгээ хэрэгтэй. Тэдэнд аз жаргал хэрэгтэй. Тэдэнд хайр, халамж хэрэгтэй. Тэдэнд сайхан сэтгэл, хоол унд, хайр халамж хэрэгтэй. Айл гэр бүр орон байрны үнэ өртгөөс үл хамааран авралын орчин болох хайрын орчныг бүрдүүлж чадна” гэж заажээ (Conference Report, 1994 оны 10-р сар, 74–75; *Ensign*, 1994 оны 11-р сар, 54).

Сүмийн хоёр дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Бригам Янг заахдаа:

“Хүүхдүүдээ Их Эзэнийг хайрлах хайр, түүнээс эмээх айдаст өсгөн хүмүүжүүл; тэдний сонирхол, зан авирыг судал, тэгээд тэдэнтэй үүний дагуу харьц, тэднийг уур хилэнгийн халуунаар засч залруулахыг хэзээ ч өөртөө бүү зөвшөөр; танаас айхыг биш, харин таныг хайрлахыг тэдэнд заа” гэжээ (*Discourses of Brigham Young*, эмхтгэсэн. Жон А.Видцөү [1954], 207).

Хүүхдүүд эцэг эхчүүдийнхээ амьдралд агуу баяр хөөр авчирдаг.

Эцэг эхчүүд өөрсдийн ариун үүргүүдийг санадаг байх нь чухал боловч, бас хүүхдүүд нь өөрсдийнх нь амьдралд нь авчирдаг баяр хөөрийг тэд ойлгодог байх нь чухал гэдгийг онцлон хэл. Ахлагч Жеймс Е.Фауст Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад үйлчилж байхдаа, “хүмүүний амьдралд тохиолддог хэдхэн сорилт бэрхшээл сайн эцэг эхчүүд байхаас илүү агуу байдаг бол, хэдхэн боломж нь баяр хөөрийн төлөө илүү агуу чадавхийг санал болгодог” гэжээ (Conference Report, 1990 оны 10-р сар, 40; *Ensign*, 1990 оны 11-р сар, 32; мөн түүнчлэн *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Авлага Авлага*, хуудас 48-ыг үз).

Хүүхдүүд нь тэдний амьдралд баяр хөөр авчирсан тухай товч ярих даалгавар авсан оролцогчдоос үүний талаар ярихыг хүс (“Бэлтгэл,” зүйл 4-ийг үз). Цаг гарвал, өөрийн чинь амьдралд хүүхдүүдийн авчирсан баяр хөөрийн тухай мэдрэмжүүдээ хуваалцахыг бод.

Дүгнэлт

Хүүхдүүд бол бидний Тэнгэрлэг Эцэгээс ирдэг бэлэг гэдгийг онцлон хэл. Дууллыг зохиогчийн хэлсэнчлэн, “Үр хүүхэд бол Их Эзэний Өв юм” (Дуулал 127:3). Дэлхийн эцэг эхчүүд Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийг гэр орондоо ирэхэд нь баяртай угтан, тэднийг хайрлах, тэднийг энхрийлэх, тэдэнд заах түүнчлэн тэднийг мөнх амьдрал уруу удирдан хөтлөх үүрэг хариуцлагыг өөрсөд дээрээ хүлээдэг.

Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага, хуудас 35–38-ыг үз.(1) “Хэрэгжүүлэхэд Зориулсан Санаанууд” дахь зөвлөмжүүдээс доод тал нь нэгийг дагаж, (2) Ерөнхийлөгч Томас С.Монсоны “Үнэ Цэнэ Бүхий Хүүхдүүд Бурханы Бэлэг Мөн” өгүүллийг уншиж энэ хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудыг нэгтгэн дүгнэхэд нь оролцогчдыг урамшуулан дэмж. Гэрлэсэн хосууд судлах удирдамж дахь өгүүллүүдийг хамтдаа уншиж, ярилцсанаар ашиг тус олж болохыг онцлон хэл.

Судлах гарын авлагуудаа дараагийн хичээлд ангид авчрахад нь оролцогчдыг урамшуул.

**Нэмэлт эх
Сурвалж
Материал**

Уламжлалт гэр бүлийн нөхцөлд байдаггүй хүмүүсийн хэрэгцээг тодорхойлж, хандах нь

Уламжлалт гэр бүлийн нөхцөлд байдаггүй оролцогчдын нөхцөл байдлыг тодорхойлохын тулд дараах мэдэглүүдээс нэгийг буюу илүү олныг унш:

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Боид К.Пакер тайлбарлахдаа: “Төрөлхийн шинж чанар хийгээд нөхцөл байдлаас болж, гэрлэлтийн болон эцэг эх болох адислалуудыг олж аваагүй, эсвэл гэм буруугүй хүүхдүүдээ ганцаараа хуулийн дагуу өсгөн хүмүүжүүлж, тэтгэн тэжээхээр ажиллах ёстой болсон бодгалиуд мөнх оршихуй дахь зарлигуудыг сахьдаг хүмүүст өгөгддөг ямар ч адислалуудаас хасагдах нь үгүй. Ерөнхийлөгч Лорензо Снөүгийн амласнаар, “Энэ нь баттай бөгөөд үүнд итгэлтэй байна” гэжээ (Conference Report, 1993 оны 10-р сар, 30; *Ensign*, 1993 оны 11-р сар, 23).

Сүмийн 11 дэх Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Харольд Б.Лий хэлэхдээ: “Энэ амьдралд нөхөрт гарах буюу эх болох адислал үгүйсгэгдсэн боловч— би чадах байсан, би болох байсан, хэрэв надад ийм боломж байсан бол би чадах байсан гэж зүрх сэтгэлдээ хэлдэг [эмэгтэйчүүд ээ]—та нарын хийсэн зүйлээр дамжуулан Их Эзэн та нарыг адислах болно, мөн зүрх сэтгэлдээ хүсдэг байсан зөв шударга зүйлүүдийг хийх боломжгүй байсан нь тэдний өөрсдийнх нь буруугаас болоогүй учир ирэх дэлхий үүнийг нь тэдэнд нөхөн төлөх болно” гэжээ (“Maintain Your Place As a Woman,” *Ensign*, 1972 оны 2-р сар, 56).

Далын Ахлагч Жийн Р.Куук: “Нас барсан буюу гэр бүл салснаас нэг гэр бүлд заримдаа зөвхөн эцэг, эх хоёрын нэг нь л байдаг. Заримдаа эцэг эх хоёрын зөвхөн нэг нь л Сүмийн гишүүн байдаг. Заримдаа эцэг эх хоёрын нэг нь нөгөөгөөсөө идэвх султай байдаг. Яг үүнчлэн, сүнслэг байдлаар хөтлөгдсөн эцэг буюу эх ганцаараа гэр бүлээ Их Эзэнд амжилттайгаар өсгөн торниулж чаддаг. Миний таньдаг хамгийн шилдэг зарим эрэгтэйчүүд мөн эмэгтэйчүүд ийм гэр бүлүүдээс гаралтай. Хүүхдүүдээ өсгөн хүмүүжүүлэх ажлыг ‘ганцаараа’ хийх ёстой гэж боддог хэдий ч, хэрэг дээрээ тэднийг Их Эзэний чиглүүлэл дор хүмүүжүүлдэг эдгээр сайн эхчүүд, сайн эцгүүдийг Их Эзэн үргэлж адислах болтугай” хэмээн тайлбарлажээ (*Raising Up a Family to the Lord* [1993], xv).

Хэсэг 1: Эцгүүдийн үүргүүд

Зорилго Эцгүүд өөрсдийн ариун үүргүүдийг хэрхэн биелүүлдэг хийгээд эцэг эхчүүд адил тэгш хамтрагчдын хувьд хэрхэн бие биендээ тусалж болдгийг ойлгоход нь оролцогчдод туслах.

- Бэлтгэл**
1. “Багшийн Хувьд Таны Үүрэг Хариуцлагууд” дахь (энэ гарын авлагын хуудас х–хiii зарчмуудыг хэрэглэж болох арга замуудыг эрж хай.
 2. Хичээл дэх сургаалууд болон зарчмуудыг тоймлон харуулсан тод гарчгуудыг унш. Бэлтгэлийнхээ нэг хэсэг болгон эдгээр сургаалууд болон зарчмуудыг долоо хоногийн турш эргэцүүлэн бодоод, оролцогчдын хэрэгцээнд тохируулан юуг онцлон хэлэх ёстойг шийдэхэд Сүнсний удирдамжийг эрэлхийл.
 3. *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагуудаа* ангид авчрахыг оролцогчдод сануул.

**Энэ хичээлийг
заах зөвлөмж**

Эцэг эхчүүд хүүхэд бүрээ итгэлийн бамбайгаар хангахын тулд хамтран ажиллах ёстой.

Самбар дээр *Итгэлийн Бамбай* гэж бич. Сургаал ба Гэрээ 27:15, 17-г оролцогчидтой хамт унш.

- Итгэл юугаараа бамбайтай адилхан бэ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Гүйцэтгэх Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Бойд К.Пакерын дараах мэдэгдлийг унш. Хүүхдүүд яагаад гэр орондоо “итгэлийн бамбай” хүлээн авах шаардлагатайг ойлгохын тулд анхааралтай сонсохыг оролцогчдоос хүс.

“Амьдралын нэг үеийн адил, итгэлийн бамбай нь гэр бүлд төлөвшиж, нийцэн зохицдог байхыг бидний Эцэгийн төлөвлөгөө шаарддаг. Итгэлийн хоёр бамбай яг адилхан байж чаддаггүй. Хүн бүр хувь хүнийхээ өвөрмөц онцлогт зохицуулагдсан байх ёстой.

“Загварыг нь Эцэгийн гаргасан төлөвлөгөө эрэгтэй хүн, эмэгтэй хүн хоёр, эхнэр нөхөр хоёр хамтран ажилласнаар итгэлийн бамбайнд хүүхэд бүрийг хувийн өвөрмөц байдлаараа тохирох болгож, улмаар энэ нь ховхорч унахгүй, бас галт суманд нэвтлэгдэхгүй бат бөхөөр бэхлэгдэж чадна гэж бодон төлөвлөгджээ.

“Энэ нь бамбайн төмрийг давтах эцгийн цуцашгүй хүч чадлыг, мөн үүнийг өнгөлж, сайхан болгох эхийн зөөлөн гарыг шаардана. Зарим үед эцэг буюу эх ганцаараа үүнийг хийх ёстой болдог. Энэ нь хэцүү юм, гэвч үүнийг хийж болдог.

“Итгэлийн бамбай хийгддэг материалууд: хүндэтгэл, зориг, энэрэл, наманчлал, уучлал, өрөвч сэтгэлийн тухай бид Сүмд зааж чадна. Эдгээрийг сүмд

хэрхэн хамтад нь нийлүүлэн угсардгийг бид сурч болно. Гэвч итгэлийн бамбайг жинхэнэ ёсоор хийж, тохирохоор болгох нь гэр бүлийн хүрээнд л ноогддог. Эс бөгөөс энэ нь суларч, хямралд ордог” (Conference Report, 1995 оны 4-р сар, 8; *Ensign*, 1995 оны 5-р сар, 8).

- Эцгийн болон эхийн үүргүүдийн талаар энэ мэдэгдэл юу зааж байна вэ?

Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага, хуудас iv дэх “Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхагт” хандахыг оролцогчдоос хүс (түүнчлэн энэ гарын авлагын хуудас ix-ыг үз). Уг тунхгийн долоо дахь догол мөрөн дэх дараах зарчмуудыг тэдэнтэй хамт унш:

“Тэнгэрийн загвараар эцэг нь өрх гэрээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, амьдралын хэрэгцээт зүйлсээр нь хангаж гэр бүлээ хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал юм. Энэхүү ариун үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой. Тахир дутуу болох, нас нөгчих болон бусад нөхцөл байдалд хувь хүн зайлшгүй дасан зохицох шаардлага гарч болно.”

Энэ хичээл болон хичээл 11 нь эцэг эхчүүдийн ариун үүргүүдийн тухай юм гэдгийг тайлбарла. Нэг хичээл эцгийн үүргүүдэд анхаарал төвлөрүүлж, нөгөө нь эхийн үүргүүдэд анхаарал төвлөрүүлдэг хэдий ч, энэ хоёр хичээл “адил тэгш хамтрагчдын хувьд бие биендээ туслах үүрэгтэй” эцэг, эх хоёуланд нь хамаатай юм. Хичээлүүд нь түүнчлэн, Их Эзэний тусалцаатайгаар эцэг, эх хоёулангийнх нь үүргийг биелүүлж, бүхнийг хийдэг ганц бие эцэг буюу эхчүүдэд бас ашиг тустай юм.

Эцгүүд хайр хийгээд зөв шударга ёсоор тэргүүлэх ёстой.

Гэр бүлийн тунхаг дахь дараах мэдэгдэлд оролцогчдын анхаарлыг хандуул: “Тэнгэрийн загвараар эцэг нь өрх гэрээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдах ёстой.” *Тэргүүлэх* гэдэг нь гэр бүлийн сайн сайхны төлөө удирдаж, дагуулан, хариуцлага хүлээх ёстой гэсэн утгатайг тайлбарла.

Эрэгтэй хүн гэр орондоо тэргүүлэх үүргээ биелүүлэхдээ тэрээр эхнэртэйгээ хамтран ажилладгийг онцлон хэл. Сүмийн 14 дэх Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Ховард В.Хантер зөвлөхдөө: “Санваар эзэмшдэг эр хүн гэр орон, гэр бүлээ үүнд хамаатай бүх шийдвэрүүдэд бүрэн оролцох хийгээд бүрэн мэдлэгтэйгээр тэргүүлэхэд эхнэрээ хамтрагч болгодог. . . . Бурханлиг томиллоотоор гэр орон дахь тэргүүлэх үүрэг хариуцлага санваар эзэмшигч дээр ноогддог (Мосе 4:22-ыг үз). Эхнэр нь эрэгтэй хүнд *тэгш эрхтэй* туслагч байхаар Их Эзэн төлөвлөсөн бөгөөд энэ нь бүрэн хамтын ажиллагаан дахь тэгш эрхтэй, зайлшгүй шаардлагатай хамтрагч мөн. Зөв шударга ёсоор тэргүүлэх нь нөхөр, эхнэр хоёрын хооронд үүрэг хариуцлагыг хуваарилдаг бөгөөд та нар хамтдаа гэр бүлийн бүх асуудлуудад мэдлэг, оролцоотойгоор хамтран ажилладаг. Эрэгтэй хүн бие даан ажиллах буюу эхнэрийнхээ бодол санаа, зөвлөгөөг анхаарахгүйгээр гэр бүлээ удирдах нь зөв шударга бус эрх мэдлийг бий болгодог” гэжээ (Conference Report, 1994 оны 10-р сар, 68; *Ensign*, 1994 оны 11-р сар, 50–51).

Эцгүүд “Есүс Христ өөрийн сүмийг тэргүүлдэг лугаа адил—хайр, үйлчлэл, нинжин сэтгэл хийгээд үлгэр жишээгээр тэргүүлэх ёстой” гэж Сүмийн 12 дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл заажээ (Conference Report, 1976 оны 4-р сар, 68; *Ensign*, 1976 оны 5-р сар, 45).

- Эцгүүд хайр, зөв шударга ёсоор тэргүүлэх нь яагаад чухал байдаг вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр Зөвлөхөөр үйлчилж байхдаа: “Гэр бүлийн тэргүүн болон зогсох үндсэн хийгээд хаашаа ч зайлах аргагүй үүрэг хариуцлага бол та нарынх юм. Энэ нь аливаа дарангуйлал буюу зөв шударга бус эрх мэдлийг өөртөө агуулсан байдаггүй. Энэ бол гэр бүлийнхээ хэрэгцээг эцгүүд хангах бүрэн эрхийг агуулсан байдаг. Эдгээр хэрэгцээ бол хоол хүнс, хувцас хунар, орон байрнаас илүү зүйл. Эдгээр хэрэгцээ нь зөв шударга чиглүүлэл хийгээд үнэнч шударга ёс, зарчимч байдал, үйлчлэл, бусдын эрхийг хүндэтгэх болон бид энэ амьдралд, зөвхөн нэг нэгнийхээ төлөө төдийгүй, бас бидний мөнхийн Эцэг тэнгэрийн Бурханд зориулан хийдэг зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээх ёстойг ойлгох тухай үндсэн зарчмуудыг үлгэр жишээгээр бас дүрэм журмаар заах явдлыг өөртөө багтаадаг” гэж зөвлөжээ (Conference Report, 1993 оны 10-р сар, 78–79; *Ensign*, 1993 оны 11-р сар, 60).

“Ах нар аа, санваар бол гагцхүү зөв шударга эрх мэдэл гэдгийг санахыг бид та нарт урамшуулан дэмждэг. Хайрын харьцаагаараа дамжуулан хүүхдүүдийнхээ хүндлэл, итгэлийг олж авагтун” хэмээн Ерөнхийлөгч Ховард В.Хантер хэлжээ (Conference Report, 1994 оны 10-р сар, 69; *Ensign*, 1994 оны 11-р сар, 51).

Хүүхдүүдээ сүнслэг удирдлагаар хангахад эцгүүд юу хийх ёстойг ойлгоход нь оролцогчдод туслахын тулд, *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын* хуудас 41–42-т тэдний анхаарлыг хандуул. Сүмийн 13 дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны дараах мэдэгдлийг оролцогчидтой хамт уншиж, ярилц:

“Израил дахь эцгүүдийг хайрлах зүрх сэтгэлийнхээ хайраар би, тэднээс хүүхдүүдээ сүнслэг удирдлагаар хангаж болох арван өвөрмөц арга замыг тэдэнд санал болгохыг надад зөвшөөрнө үү:

“1. Хүүхдүүдээ эцгийн адислалуудыг өг. Хүүхдүүдээ баптисм хүртээж, гишүүнээр батал. Хөвгүүдээ санваарт томил. Эдгээр зүйлүүд хүүхдүүдийн чинь амьдралд сүнслэг гол үйл явдлууд болно.

“2. Гэр бүлийн залбирлууд, өдөр бүр судар судлах болон долоо хоног тутмын гэр бүлийн үдшийг биечлэн удирд. Эдгээр үйл ажиллагаанууд үнэхээр хичнээн чухал болохыг таны хувийн оролцоо хүүхдүүдэд чинь харуулах болно.

“3. Боломжтой л бол Сүмийн цуглаануудад гэр бүлээрээ хамтдаа оролц. Таны удирдлага доорх гэр бүлийн шүтлэг бишрэл хүүхдүүдийн чинь сүнсний сайн сайхан байдалд амин чухал юм.

“4. Аав охидтойгоо уулзаж ярилцах цаг гарган, эцэг хөвгүүд хамт гадагшаа явахыг үргэлж зохион байгуул. Аялал зугаалгаар явах, бөмбөг тоглох, концерт үзэх, сургуулийн хөтөлбөрүүдэд оролцох зэрэгт гэр бүлээрээ явж бай. Энэ бүгдэд Аав оролцох нь бүхнийг өөрчилнө.

“5. Гэр бүлээрээ амардаг, гэр бүлээрээ аялал зугаалгад явдаг уламжлал бий болго. Эдгээр ой дурдатгалуудыг хүүхдүүд чинь хэзээ ч мартаггүй.

“6. Хүүхдүүдтэйгээ нэг бүрчлэн тогтмол уулзаж бай. Тэд юу хийхийг хүсч байгаагаа ярих боломжийг тэдэнд олго. Сайн мэдээний зарчмуудыг тэдэнд заа. Жинхэнэ үнэт зүйлсийг тэдэнд заа. Тэднийг та хайрладгаа тэдэнд хэл.

Хүүхдүүдтэйгээ хамт байдаг цаг хугацаа тань, Аав нь тэргүүн зэрэгт анхаардаг зүйлүүдээ хаана тавьдгийг тэдэнд хэлж өгөх болно.

“7. Ажиллахыг хүүхдүүддээ зааж, зохистой зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө ажиллахын үнэ цэнийг тэдэнд харуул. Хүүхдүүддээ зориулан номлолын сан, боловсролын сан байгуулах нь Аав нь юуг чухал гэж үздэгийг хүүхдүүдэд чинь харуулдаг.

“8. Гэр орондоо сайн хөгжим, урлаг болон утга зохиолын номнууд байлгахыг урамшуулан дэмж. Гоо сайхны болон үзэсгэлэнт сайхан зүйлийн уур амьсгал байдаг гэр орон хүүхдүүдийн чинь амьдралыг үүрд адислах болно.

“9. Хол биш бол, эхнэртэйгээ хамт ариун сүмд байнга очиж бай. Тэгвэл хүүхдүүд чинь ариун сүмийн гэрлэлт, ариун сүмийн амлалт хийгээд мөнхийн гэр бүлийн нэгжийн ач холбогдлыг илүү сайн ойлгох болно.

“10. Та сүм дэх үйлчлэлд баяр хөөр, сэтгэл ханамжтай байдгаа хүүхдүүддээ харуул. Энэ нь тэдэнд нөлөөлж, улмаар тэд ч бас Сүмд үйлчлэхийг хүсч, хаант улсыг хайрлах болно” (Conference Report, 1987 оны 10-р сар, 62–63; *Ensign*, 1987 оны 11-р сар, 50–51).

Эцгүүд гэр бүлээ амьдралын хэрэгцээт зүйлүүдээр ханган тэтгэж, хамгаалж байх ёстой.

Эцгүүд “гэр бүлээ . . . амьдралын хэрэгцээт зүйлүүдээр ханган тэтгэх үүрэг хариуцлагатайг” гэр бүлийн тунхаг нотолдгийг оролцогчдод сануул.

- Амьдралын хэрэгцээт зарим ямар зүйлүүд байдаг вэ? (Хариултууд нь хоол хүнс, мөнгө, хувцас, орон байр байж болно.) Эдгээр хэрэгцээт зүйлүүдийг эцгүүд ямар арга замаар хангах ёстой вэ?

Ерөнхийлөгч Ховард Б.Хантер хэлэхдээ: “Санваар эзэмшдэг та нар, хэрэв тахир дутуу биш бол, эхнэр хүүхдүүдээ тэтгэхийн тулд материаллаг зүйлүүдээр хангах ёстой. Хариуцлагын энэхүү ачаагаа өөр хүнд, тэр ч байтугай эхнэртээ шилжүүлдэг эр хүн гэж үгүй. Эмэгтэйчүүд, хүүхдүүд өөрсдийгөө тэтгүүлэхийн тулд нөхрүүд болон эцгүүдээсээ нэхэх ёстой гэж Их Эзэн зарлигласан билээ (С ба Г 83; 1 Тимот 5:8-ыг үз). . . . Та гэр бүлээ хангахын тулд чадах бүхнээ хийхийн хамт, гэртээ үлдэж, хүүхдүүддээ анхаарал халамж тавих боломжийг эхнэртээ олгохын тулд өөрийн хүчин дэх бүхнийг хийхийг бид та нараас шаргуу хүсч байна” гэжээ (Conference Report, 1994 оны 10-р сар, 69; *Ensign*, 1994 оны 11-р сар, 51).

- Амьдрал дахь сүнслэг байдлын зарим хэрэгцээт зүйлс юу вэ? (Хариултууд нь гэрчлэл, хайр, өдөр тутмын залбирал, судар судлах, сайн мэдээг заах хийгээд санваарын ёслолууд байж болно.) Эдгээр хэрэгцээт зүйлсээр хангахын тулд эцгүүд юу хийж болох вэ?
- Өөрсдийг нь ханган тэтгэхийн тулд нөхөр болон эцгийнхээ гаргадаг хүч чармайлтуудыг эхнэр, хүүхдүүд нь хэрхэн дэмжиж болох вэ?

Гэр бүлийн тунхаг дахь: “Эцгүүд . . . амьдралын хэрэгцээт зүйлсээр хангаж . . . гэр бүлээ хамгаалах үүрэгтэй” гэсэн зөвлөгөөнд оролцогчдын анхаарлыг хандуул.

- Гэр бүлүүд юунаас хамгаалагдах хэрэгтэй вэ?
- Нөхөр болон эцгүүд ямар арга замаар гэр бүлээ хамгаалж чадах вэ?

Ерөнхийлөгч Ховард В.Хантер хэлэхдээ:

“Зөв шударга эцэг хүүхдүүдийнхээ нийгмийн, боловсролын болоод сүнслэг үйл ажиллагаанууд, үүрэг хариуцлагуудад өөрийн цаг завьг зориулж, оролцох замаар хүүхдүүдээ хамгаалдаг. . . .

“Санваар эзэмшигч эр хүн гэр бүлээ Сүмийн оролцоонд удирддаг, ингэснээр тэд сайн мэдээг мэдэж, гэрээнүүд хийгээд ёслолуудын хамгаалалтанд байх болно. Хэрэв та Их Эзэний адислалуудыг хүртэхийг хүсвэл, та өөрийнхөө гэр орныг дэг журамд оруулах ёстой. Та эхнэртэйгээ хамт өөрийн гэр орон дахь уур амьсгалыг тодорхойлдог. Таны анхдагч үүрэг бол судруудыг тогтмол судлах болон өдөр тутмын залбирлаар дамжуулан өөрийн сүнслэг амьдралыг бий болгох явдал мөн. Санваар болон ариун сүмийн гэрээнүүдээ сахин хүндэтгэ; мөн ингэхэд нь гэр бүлээ урамшуулан дэмж” гэжээ (Conference Report, 1994 оны 10-р сар; *Ensign*, 1994 оны 11-р сар, 51).

- Та нар эцгүүд өөрсдийн ариун үүрэг хариуцлагуудыг биелүүлэхийг харсан зарим ямар жишээнүүд байдаг вэ?

Анхааруулга: Хэрэв та зөвхөн энэ хичээлийг дангаар нь зааж, хичээл 11-ийг заахаар төлөвлөөгүй бол, гэр бүлийн тунхгийн доорх мэдэгдлийг ярилцахыг бод: “Энэхүү ариун үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой.” Энэхүү үнэний тухай ярилцахад туслах зүйл нь хичээл 11-т агуулагддаг (хуудас 66-г үз).

Дүгнэлт

Сүнсээр өдөөгдсөний дагуу, энэ хичээлээр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага, хуудас 39–42-ыг үз. Оролцогчдыг (1) “Хэрэгжүүлэхэд Зориулсан Санаанууд” дахь зөвлөмжүүдээс доод тал нь нэгийг дагаж, (2) Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны “Израилын Эцгүүдэд Зориулав” өгүүллийг уншиж энэ хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудыг нэгтгэн дүгнэхэд нь урамшуулан дэмж. Гэрлэсэн хосууд судлах гарын авлага дахь өгүүллүүдийг хамтдаа уншиж, ярилцсанаар ашиг тус олж болохыг онцлон хэл.

Судлах гарын авлагуудаа дараагийн хичээлд ангидаа авчрахыг оролцогчдод сануул.

Хэсэг 2: Эхчүүдийн үүргүүд

Зорилго	Эхчүүд өөрсдийн ариун үүргүүдийг хэрхэн биелүүлдэг хийгээд эхчүүд болон эцгүүд тэгш эрхт хамтрагчдын хувьд бие биендээ хэрхэн тусалж болдгийг ойлгоход нь оролцогчдод туслах.
Бэлтгэл	<ol style="list-style-type: none">1. “Багшийн Хувьд Таны Үүрэг Хариуцлагууд” дахь (энэ гарын авлагын хуудас х–хiii) зарчмуудыг хэрэглэж болох арга замуудыг авч үз.2. Хичээлийн тод гарчгуудыг унш. Эдгээр гарчгууд хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудын тоймыг өгдөг. Бэлтгэлийнхээ нэг хэсэг болгон эдгээр сургаалууд болон зарчмуудыг хэрэглэхэд нь оролцогчдод туслах арга замуудыг тунгаан бод. Оролцогчдын хэрэгцээг хангахын тулд та юуг онцлон хэлэх ёстойг шийдэхэд Сүнсний удирдамжийг эрэлхийл.3. <i>Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага</i> ангид авчрахыг оролцогчдод сануул.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Эхчүүд Бурханы ажилд оролцдог.

Энэ хичээлийн оршил болгож, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жеффри Р.Холландын хэлсэн үгний дараах хэсгийг оролцогчидтой хамт унш (*Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн гарын авлага*, хуудас 44):

“Нэг залуу ээж, түүний сэтгэлийн зовнил гурван талбарт байдаг тухай саяхан надад бичсэн юм. Нэг нь гэвэл эхчүүдийн сэдвээрх ХҮГ-ийн яриануудыг тэрээр сонссон үедээ, тэрээр яагаад ч энэхүү үүрэг хариуцлагадаа хүрэхээр ажиллаж чаддаггүйгээ мэдэрсэн учраас санаа нь зовдог ажээ. Хоёрдугаарт, тэрээр дэлхий түүнээс хүүхдүүддээ—унших, бичих, гэрийн дотоод чимэглэл, латин хэл, тооцоо, түүнчлэн Интернет зэргийг заахыг хүсэн хүлээж байгаа мэт санагдаж, бяцхан хүүхдийн өмнө бүгдээрээ ердөө л аймаар, ‘пөөх, пөөх’ гэмээр зүйлүүд байгааг тэрээр мэдэрчээ. Гуравдугаарт, заримдаа хүмүүсийн үйчлэл хийж байгаа нь, бараг л үргэлж утга учиргүй юм шиг түүнд санагддаг байв, учир нь түүний хүлээн авсан зөвлөгөө эсвэл тэр ч байтугай, түүний хүлээн авсан магтаал үгс оюун санаа, сүнсний болоод сэтгэл хөдлөлийн чармайлтад нэмэр болох зүйл юу ч байдаггүй, хязгаарлалтад сунасан урт шөнө, урт өдөр зарим үед Бурханы найддаг шиг тийм эх хүн байхыг хичээж бас хүсдэг ажээ.

“Гэвч нэг л зүйл түүнийг цааш үргэлжлүүлэх болгодог аж : ‘Үүнийг бүхий л талаар дамжуулан, энэ бүхнийг хааяа нэг гардаг нулимсаар дамжуулан, би Бурханы ажил хийж байна гэдгээ дотоод сэтгэлийнхээ гүнд мэддэг. Эх болсондоо би Түүнтэй мөнхийн түншлэлд байгаа гэдгээ мэддэг. Бурхан Өөрийн туйлын зорилго хийгээд утга учрыг эцэг болох явдалд олж хардаг, тэр ч байтугай Түүний хүүхдүүдийн зарим нь Түүнийг уйлахад хүргэдэг ч гэсэн тэр шүү дээ хэмээн тэрээр хэлжээ.

“Энэ бүхэн нэлээд сүрхий дарамт байж болох байсан тэрхүү тойрон гарах аргагүй хүнд өдрүүдийг би эргэн санахыг хичээдэг нь үүний биелэл юм” гэж тэр хэлжээ. Энэ бол чухамдаа бидний Түүнд хүрэхэд түүнчлэн эргээд бидэнд хүрэх түүний чадварыг өргөжүүлэхэд биднийг шахан шаардагч бидний чадваргүй байдал хийгээд санаа зовнилт байж болно. Магадгүй Тэрээр биднийг санаа зовнилттой *байлгахыг*, мөн Түүний тусалцааг *гуйхыг* нууцханаар найддаг байж болно гэж тэрээр өгүүлжээ. Тиймээс, Тэрээр биднээр дамжуулан, гэхдээ эсэргүүцэлгүйгээр эдгээр хүүхдүүдэд шууд зааж чадна гэдэгт би итгэдэг. Тэрээр эцэст нь, энэ санаа надад таалагддаг. Энэ нь надад найдвар төрүүлдэг. Хэрэв би Тэнгэр дэх Эцэгийнхээ өмнө зөв байж чадах юм бол, бидний хүүхдүүдэд зориулсан түүний удирдамжид саад тотгор учрахгүй биз ээ. Тэгвэл энэ нь үнэнхүү шууд утгаараа Түүний ажил хийгээд Түүний алдар суу байж болно” (Conference Report, 1997 оны 4-р сар, 47; *Ensign*, 1997 оны 5-р сар, 36).

Эхчүүд Бурханы ажилд хэрхэн оролцдог тухай санаа бодлуудаа хуваалцахад заадаг хүмүүсээ урь.

Эхчүүдийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ өсгөн хүмүүжүүлэх явдал юм.

Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын хуудас iv-т оролцогчдын анхаарлыг хандуул. Тэднийг гэр бүлийн тунхгийн долоо дахь догол мөрөн дэх дараах мэдэгдэлд хандуул: “Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ өсгөн хүмүүжүүлэх явдал юм.”

- Эхчүүд хүүхдүүдээ ямар арга замаар өсгөн хүмүүжүүлдэг вэ? (Эхийн сайн нөлөөг харуулсан туршлагуудаа хуваалцахад оролцогчдыг урь. Дараа нь доорх мэдэгдлүүдийг хуваалц.)

“Их Эзэнээр удирдагдсан эх хүний хувьд та нягт нямбай заавар, зохистой үлгэр жишээгээр дамжуулан үнэний зарчмуудаар хүүхдүүдийнхээ зан төлвийг бий болгон төлөвшүүлдэг билээ. Та шударга ёсны онцлог шинжүүд, Бурханд итгэх итгэл, үүрэг хариуцлага, бусдыг хүндэтгэх, нинжин сэтгэл, өөртөө итгэх итгэл, түүнчлэн хувь нэмрээ оруулах, сурах, хүүхдийн оюун санаа, зүрх сэтгэлийг өөрийн тань итгэмжлэлд өгөхийг заадаг. Өдөр өнжүүлэх төв үүнийг хийж чадахгүй. Энэ бол таны ариун эрх хийгээд онцгой боломж мөн” хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г.Скотт хэлжээ (Conference Report, 1996 оны 10-р сар, 102; *Ensign*, 1996 оны 11-р сар, 74).

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Гүйцэтгэх Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Бойд К.Пакер хэлэхдээ, “Эх нь хүүхдүүдээ заахтай адил хэмжээний буюу илүү сүнслэг урамшуулалтай, эсвэл илүү өргөмжлөгч шинжтэй заалт байдаггүй” (“Teach the Children,” *Ensign*, 2000 оны 2-р сар, 16).

Эхчүүд хүүхдүүдээ хэрхэн өсгөн хүмүүжүүлж болох тухай илүү олон санааг хуваалцахын тулд, *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын* хуудас 45–47-д оролцогчдын анхаарлыг хандуул. Хүүхдүүдтэйгээ хамт цагийг үр ашигтайгаар өнгөрүүлэхийн тулд эхчүүд юу хийж болох тухай Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны 10 зөвлөмжийг эрж олохыг тэднээс хүс. Эдгээр зөвлөмжүүдийг олж, доор харуулснаар тэдгээрийг самбар дээр жагсаан бичихийг оролцогчдоос хүс. Доорх зөвлөмж тус бүрийн ашиг тусыг ярилц.

1. Амьдралынх нь турш хамт бай.	6. Хоолны цагаар хамтдаа бай.
2. Жинхэнэ найз нь бай.	7. Өдөр тутам судруудыг унш.
3. Хүүхдүүддээ зориулан ном уншиж өг.	8. Аливаа зүйлийг гэр бүлээрээ хийж бай.
4. Хүүхдүүдтэйгээ хамт залбирч бай.	9. Хүүхдүүддээ заан сургаж бай.
5. Долоо хоног тутам гэр бүлийн үдшийг хий.	10. Хүүхдүүдээ үнэн голоосоо хайрла.

Эхчүүд ажлын байранд байхын оронд хүүхдүүдтэйгээ хамт гэртээ байхын ач холбогдлыг хожмын үеийн бошиглогчид онцгойлон үздэгийг анхааруулан хэл. Сүмийн 15 дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн дараах мэдэгдлийг хуваалц:

“Тэр бүлийнхээ хэрэгцээг хангахын төлөө ажил хийхээс аргагүй зарим эмэгтэйчүүд (үнэндээ бол тэд маш олон) байдаг. Та нарт хандаж хэлэхэд, чадах бүхнээ хамгийн сайнаар хий. Хэрэв та нар бүрэн цагийн ажилтай бол үүнийг ердөө л дээд зэрэглэлийн орон байр, гоё ганган машинууд, бусад тансаг эд зүйлсээр сэтгэлээ зугаацуулахын тулд бус, харин үндсэн хэрэгцээгээ хангахын тулд хийдэг гэдэгт би найддаг. Ямар ч эх хүний хийх хамгийн агуу ажил бол хүүхдүүдээ зөв шударга ёс хийгээд үнэнд өсгөн хүмүүжүүлэх, заах, өргөн дээдлэх, урам хайрлах хийгээд хүмүүжүүлэх явдал үүрд мөнхөд байх болно. Өөр хэн ч эх хүнийг зохих ёсоор орлож чадахгүй” (Conference Report, 1996 оны 10-р сар, 93; *Ensign*, 1996 оны 11-р сар, 69).

- Энэ зөвлөгөөг дагахын тулд гэр бүлүүд ямар золиослол хийж болох вэ?

Та хичээлийн энэ хэсгийн дүгнэлт болгож, дараах мэдэглүүдээс нэгийг буюу хоёуланг нь хуваалц:

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли, Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр Зөвлөхөөр үйлчилж байхдаа: “Газар бүрийн эхчүүд та нарын дуудлагын эрхэм ариуныг би сануулж байна. Өөр хэн ч та нарыг орлож чадахгүй. Дэлхийд та нарын авчирсан хүүхдүүдийг хайраар, амар амгалангаар, түүнчлэн зарчимч шударга байдлаар та нар өсгөн хүмүүжүүлдгээс илүү агуу, илүү их ачаалал үүрсэн тийм үүрэг хариуцлага гэж үгүй” хэмээн хэлжээ (Conference Report, 1993 оны 10-р сар, 79; *Ensign*, 1993 оны 11-р сар, 60).

Эхчүүдэд хандаж Ахлагч Жефффри Р.Холланд хэлэхдээ: “Хүмүүний бүх гэр бүлийн эх, 'хүмүүн [бас эмэгтэйчүүд] байж болохын тулд' [2 Нифай 2:25], мөн баяр хөөр байж болохын тулд Адам тэр хоёр унах *ёстой байсныг* ойлгосон Евагийн аугаа уламжлал бол та нарынх юм. Тэдэнгүйгээр Абрахамд, Исаакт түүнчлэн Иаковт өгөгдсөн, бид бүгдийг адисалдаг патриахын гайхамшигт амлалтууд байж чадахгүй байсан, Сара, Ребека, Рахел нарын аугаа уламжлал та нарынх юм. Лой, Юник хоёрын [2 Тимот1:5] түүнчлэн 2,000 залуу дайчдын эхчүүдийн аугаа уламжлал та нарынх юм. Энэ дэлхий байхаас өмнө сонгогдон, урьдчилан томилогдож, Бурханы Өөрийнх нь Хүүг хэвлийдээ олж, тээн, төрүүлсэн Мариагийн аугаа уламжлал та нарынх юм.

Бид та бүгдэд, түүний дотор өөрсдийнхөө ээжүүдэд талархал илэрхийлж, Өөрийн охид хөвгүүдэд үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг тохиолгон авчрахын тулд, үхэшгүй байдал болон мөнх амьдрал тэнгэр дэх селестиеп хаант улсад ирж болохын тулд Бурханы ажил хийгээд алдар сууд ийнхүү шууд оролцохоос илүү чухал зүйл гэж үгүй гэдгийг та бүгдэд хэлж байна” гэжээ (Conference Report, 1997 оны 4-р сар, 48; *Ensign*, 1997 оны 5-р сар, 36; мөн түүнчлэн *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага*, хуудас 44–45-ыг үз).

Эцэг эхчүүд тэгш эрхт хамтрагчдийн хувьд бие биендээ туслах ёстой.

Анхааруулга: Хэрэв та энэ хичээлийг дангаар нь зааж байгаа бөгөөд хичээл 10-ыг заагаагүй бол, хичээлийн энэ хэсгийг энэхүү гарын авлагын хуудас 58 дахь дэх Ерөнхийлөгч Бойд К.Пакерын мэдэгдлээр эхлэхийг бод.

Гэр бүлийн тунхаг дахь дараах мэдэгдэлд оролцогчдын анхаарлыг хандуул: “Энэхүү ариун үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой.”

- Үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан адил тэгш эрхтэй байна гэсэн нь юу гэсэн үг вэ?

Эхнэр нөхрүүд тэгш эрхт хамтрагчдын хувьд хамтран ажилласнаар тэд хүч чармайлтдаа нэгддэгийг онцлон хэл. Тэд бие биенээ дэмжин тулж, бие биенийхээ хүч чадал, авьяас чадвар дээр тулгуурладаг. Гэрлэсэн хос бүр өөрсдийн үүрэг хариуцлагуудад бие биенээ хэрхэн дэмжихийг шийдэхдээ Их Эзэний удирдамжийг хүлээн авч болно. Тэд бурханлигаар илчлэгдсэн зарчмууд хийгээд хамтрагч бүрийнхээ өвөрмөц хүч чадал болоод чадварууд дээр тулгуурлан шийдвэр гаргаж чадна.

- Хүүхдүүдээ өсгөн хүмүүжүүлэх үүрэг хариуцлагад нь эхнэртээ дэмжлэг үзүүлэхийн тулд нөхөр нь юу хийж болох вэ?
- Тэргүүлэх хийгээд тэтгэн хангах үүрэг хариуцлагуудад нь нөхөртөө дэмжлэг үзүүлэхийн тулд эхнэр нь юу хийж болох вэ?
- Хүүхдүүдээ анхаарал халамж тавьж, тэдэнд заах талаар бие биенээ үр ашигтайгаар дэмждэг эхнэр нөхрүүдийн ямар жишээг та нар харсан бэ?

Дүгнэлт

Сургаал ба Гэрээ 64:33–34-ийг оролцогчидтой хамт унш.

- Эцэг эхчүүдийн үүрэг хариуцлагын талаар энэ судар хэрхэн өгүүлдэг вэ?

Эцэг эхчүүд үнэхээр “агуу ажлын суурийг тавьдгийг” онцлон хэл. Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх өдөр тутмын ажил нь заримдаа өчүүхэн жижиг, ач холбогдол багатай мэт санагддаг хэдий ч, “өчүүхэн жижиг зүйлүүдээс агуу том зүйлүүд бий болдог билээ.” Ариун үүргээ биелүүлэхийн тулд эцэг эхчүүд хамтран ажилласнаар тэдний гэр бүл Их Эзэнээс агуу адислалуудыг хүлээн авах болно.

Сүнсээр өдөөгдсөний дагуу энэ хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай өөрийн итгэл үнэмшлийг хуваалц.

Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын хуудас 43–47-д оролцогчдын анхаарлыг хандуул. Оролцогчдыг (1) “Хэрэгжүүлэхэд Зориулсан Санаанууд” дахь зөвлөмжүүдээс доод тал нь нэгийг дагаж, (2) Ахлагч Жеффри Р.Холландын “Учир нь Тэрээр Эх Хүн,” Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны “Сион дахь Эхчүүдэд” өгүүлүүдийг унших замаар энэ хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудыг нэгтгэн дүгнэхэд нь урамшуулан дэмж. Судлах гарын авлага дахь өгүүлүүдийг хамтдаа уншиж, ярилцсанаас гэрлэсэн хосууд ашиг тус хүлээн авч чадахыг онцлон хэл.

ҮЛГЭР ЖИШЭЭ ХИЙГЭЭД ЗААВРААР ДАМЖУУЛАН ХҮҮХДҮҮДЭД ЗААХ НЬ

Зорилго

Эцэг эхчүүд үлгэр жишээ хийгээд заавраар дамжуулан хүүхдүүддээ заах түүнчлэн заах хүч чармайлтууддаа бурханлиг нөлөөг эрэлхийлэх үүрэг хариуцлагатайг ойлгоход нь оролцогчдод туслах.

Бэлтгэл

1. Та өөрийгөө заахад бэлтгэхдээ “Багшийн Хувьд Таны Үүрэг Хариуцлагууд” дахь (энэ гарын авлагын хуудас х–хiii) зарчмуудыг хэрэглэж болох арга замуудыг эрж хай.
2. Хичээлийн тод гарчгуудыг унш. Эдгээр гарчгууд энэ хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудын тоймыг өгдөг. Бэлтгэлийнхээ нэг хэсэг болгон эдгээр сургаалууд болон зарчмуудыг хэрэглэхэд нь оролцогчдод туслах арга замуудыг тунгаан бод. Оролцогчдын хэрэгцээг хангахын тулд та юу онцлон хэлэх ёстойг шийдэхэд Сүнсний удирдамжийг эрэлхийл.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Эцэг эхчүүд хүүхдүүддээ заах үүрэгтэй.

Сүмийн 15 дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн ярьсан дараах өгүүллийг хуваалц:

“Биднийг гэрлэснээс хойш нэг их удалгүй, бид өөрсдийнхөө анхны гэр орныг төвхнүүлсэн сэн. Бид тун бага мөнгөтэй байлаа. Би өөрөө их ажил хийсэн дээ. . . . Орчны газрын үзэмж бүхэлдээ миний үүрэг байлаа. Миний тарьсан олон модны анхных нь өргөсгүй эвэрт мод байв. . . . Энэ бол ганцхан нарийхан, голчоороо инчийн дөрөвний гурвын л хэмжээтэй байсан байх. Үүнийг би хааш нь л бол хааш нь амархан нугалчихаар энэ мод тийм туяхан байсан юм. Олон жил улирч одох хүртэл би энэ модонд анхаарал багахан тавьдаг байлаа.

“Тэгээд өвлийн нэг өдөр, энэ мод навчаа гүвсэн үед нь цонхоор үүнийг харлаа. Мод баруун тийшээ бөхийж, хэлбэр дүрс нь өөрчлөгдөж, тэнцвэрээ алдсаныг би ажиглав. Би үүнд итгэж ядан байлаа. Би гадагшаа гарч, модыг биеэрээ тулан, тэгшлэхийн тулд түлхэв. Гэвч модны гол нь одоо голчоороо бараг тохой орчим болсон байлаа. Миний хүч тамир энд юу ч болохгүй байв. . . .

“Энэ модыг анх тарихад, жаахан уяа үүнийг салхины хүчний эсрэг тогтоон барьж чаддаг байж билээ. Би тийм уяагаар өчүүхэн бага хүч чармайлт гарган уяж чадах байсан, бас тэгэх ёстой байсан. Гэвч би тэгсэнгүй, иймээс энэ мод салхины хүч ирдэг байсан зүг рүү бөхийжээ” (*Teachings of Gordon B. Hinckley* [1997], 419–20).

- Ерөнхийлөгч Хинклийн туршлага хүүхдүүддээ заах эцэг эхийн үүрэг хариуцлагатай хэрхэн холбогдох вэ? (Оролцогчид энэ асуултыг ярилцах үеэр Сургаалт Үгс 22:6-г тэдэнтэй хамт унш.)

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли энэ модны талаарх туршлагынхаа тухай өгүүлэн: “Амьдралыг нь ажигласан хүүхдүүдээс би олон удаа үүнтэй ижилхэн зүйлүүдийг олж харсан. Тэднийг дэлхийд авчирсан эцэг эхчүүд үүрэг хариуцлагаасаа бараг л бултдаг бололтой. Үр дагавар нь эмгэнэлтэй байдаг. Цөөн хэдхэн энгийн зангуу л тэдний амьдралд нөлөөлж байгаа хүчний эсрэг тэсэн зогсох хүч чадлыг тэдэнд өгч чадах сан даа” хэмээн хэлжээ (*Teachings of Gordon B. Hinckley*, 420).

Хүүхдүүддээ заах ариун үүргийг Их Эзэн эцэг эхчүүдэд өгснийг тайлбарла. Энэ үүрэг хариуцлагад хөнгөн хуумгай хандах буюу үүнийг бусдад тохох ёсгүй. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Рассел Баллард онцлон хэлэхдээ:

“Хүүхдүүдийнхээ үнэт зүйлсийг бий болгон хөгжүүлэх ажлыг бид сургууль, олон нийт, телевиз, эсвэл тэр ч байтугай Сүмийн байгууллагуудад даатган орхиж *болохгүй* бас ингэх *ёсгүй*. Их Эзэн энэ үүргийг эцэг, эхчүүдэд ноогдуулсан юм. Энэ бол үүнээс бид зайлсхийж болохгүй бас бусдад ноогдуулж болохгүй үүрэг юм. Бусад хүмүүс тусалж болно, гэвч эцэг эхчүүд л хариуцлага хүлээх ёстой. Тиймээс, бид гэр орныхоо цэвэр ариун байдлыг хадгалан хамгаалах ёстой, учир нь энд л хүүхдүүд өөрсдийн үнэт зүйлс, харьцаа хандлага хийгээд өдөр тутмын амьдралынхаа дадал хэвшлийг хөгжүүлдэг шүү дээ” гэжээ (*Conference Report*, 1991 оны 4-р сар, 106; *Ensign*, 1991 оны 5-р сар, 79–80).

- Эцэг эхчүүд энэ үүрэг хариуцлагаа бусдад ноогдуулахын оронд хүүхдүүддээ заах нь яагаад чухал вэ? Эцэг эхчүүд энэхүү үүргээ хөсөрдүүлэхэд ямар эрсдэл учирдаг вэ?
- Өвөө, эмээ, авга, нагацууд зэрэг гэр бүлийн ураг төрлийн гишүүд хүүхдүүддээ заах эцэг эхийн хүч чармайлтад ямар арга замаар дэмжлэг үзүүлж чадах вэ?

Эцэг эхчүүд хүүхдүүддээ заахдаа бурханлиг нөлөөг хүлээн авч болно.

Оролцогчдын анхаарлыг Сургаал ба Гэрээ 42:14-т хандуул. Энэ шүлэг эцэг эхчүүд хүүхдүүддээ заах чухал түлхүүрийг агуулдгийг тайлбарладаг. Дараа нь уг шүлгийг оролцогчидтой хамт унш.

- Энэ шүлэгт ямар түлхүүр байна вэ? (Бид Сүнсээр заах ёстой.) Сүнсээр заах гэж юу гэсэн үг вэ?

2 Нифай 32:5, 33:1-ийг оролцогчидтой хамт унш. Сүнс буюу Ариун Сүнс нь бидний юу хийх, юу гэж хэлэх ёстойг мэдэхэд бидэнд тусалж чадна гэдгийг онцлон хэл. Эцэг эхчүүд Ариун Сүнсний өдөөлтүүдийн дагуу заахад Ариун Сүнс захиасыг хүүхдүүдийнх нь зүрх сэтгэлд хүргэх болно.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн дараах зөвлөгөөг хуваалц:

“Эцэг эхчүүд та нар, хүүхдүүдээ хайрла. Тэднийг хөгжил хөөртэй байлга. Тэд үнэт эрдэнэс лугаа адил юм. Тэд нэн, нэн чухал юм. Тэд бол ирээдүй юм. Тэднийг өсгөн хүмүүжүүлэхэд та нар өөрсдөө мэргэн ухаанаасаа илүү хэрэгтэй. Их Эзэний тусалцаа та нарт хэрэгтэй. Энэхүү тусалцааны төлөө залбирч, өөрсдийнхөө хүлээн авсан бурханлиг нөлөөг дага” (*Conference Report*, 1995 оны 10-р сар, 120; *Ensign*, 1995 оны 11-р сар, 89).

- Хүүхдүүддээ заах эцэг эхчүүдийн хүч чармайлтад бурханлиг нөлөө яагаад хэрэгтэй байдаг вэ? Эцэг эхчүүд хүүхдүүддээ заах үед Ариун Сүнсний нөлөөг урихын тулд юу хийж болох вэ?

Далын Ахлагч Ф.Энзио Бускийн өгүүлсэн дараах түүхийг хуваалц:

“Нөхцөл байдал намайг ердийн бус цагаар гэртээ ирэх шаардлагатай болгосон нэг өдөр, дөнгөж сая сургуулиас эргэж ирсэн арваннэгэн настай хүү маань эмэгтэй дүүгийнхээ өөдөөс муухай үгс хэлэхийг би өөр өрөөнөөс сонсон гэрчилсэн юм. Тэр үгс намайг гомдоход хүргэв—манай хүү тийм үгс хэрэглэх юм гэж би огт боддоггүй байлаа. Би босч, түүний хойноос явсан нь уурласандаа болоод миний үзүүлсэн миний эхний зүй ёсны хариу үйлдэл байлаа. Аз болоход, би түүнд хүрч очих хүртлээ нөгөөх өрөөгөөр дамжиж, нэг хаалга нээх ёстой байлаа, ингээд би тэр хэдхэн хормын дотор, Тэнгэрлэг Эцэгт хандан энэхүү нөхцөл байдлыг шийдвэрлэхэд надад туслаач хэмээн эрч хүчтэйгээр залбирснаа санадаг. Амар амгалан надад ирэх нь тэр. Миний уур гарсан байлаа.

“Манай хүү, намайг гэртээ байгааг хараад, тэвдэн сандарч, намайг түүн рүү хүрч очиход айдсаар дүүрсэн байлаа. Гайхалтай нь гэвэл, ‘Гэртээ тавтай морил, миний хүү!’ хэмээн өөрийгөө хэлэхийг би сонсоод, мэндлэх гэж гараа сунгав. Ингээд дараа нь би түүнтэй ганцаарчлан ярилцахын тулд түүнийг суудаг өрөөнд дэргэдээ ойрхон суухыг албан ёсоор урив. Би хүүдээ хайртай гэж хэлснээ сонсов. Бид хоёр хоорондоо өдөр бүр хийх ёстой байсан тэмцэлдээний тухай би түүнтэй ярилцлаа.

“Би түүнд итгэдгээ илэрхийлэхэд, түүний нүдэнд нулимс цийлэгнэж, зохисгүй байдлаа гэмшин хүлээж, өөрийгөө хэмжээлшгүй ихээр зэмлэн буруутгав. Одоо түүний зөрчлийг зохих ёсонд нь тавьж, улмаар түүнийг тайтгаруулах нь миний үүрэг байлаа. Бидэн дээр гайхамшигт сүнс ирж, бид хоёул уйлснаар энэ үйл явдал өндөрлөж, бид хоёр хайраар, эцэст нь баяр хөөртэйгөөр би биенээ чанга тэврэв. Эцэг хүү хоёрын хооронд гарч болох байсан хор уршигтай сөргөлдөөн, дээрээс ирдэг хүчний тусламжтайгаар, бид хоёрын аль алинд нь хэзээ ч мартах аргагүй, бидний харилцааны хамгийн сайхан тохиолдлуудын нэг болсон юм” (Conference Report, 1982 оны 4-р сар, 98–99; *Ensign*, 1982 оны 5-р сар, 70).

- Хэрэв энэ аав уурандаа цочмог сэтгэл хөдлөлөө дагасан бол ямар үр дагаварт хүргэж болох байсан бэ?

Хүүхдэд тодорхой арга замаар—магадгүй тэд эхлээд төлөвлөөгүй байсан тийм арга замаар заах буюу туслахад Ариун Сүнс тэднийг удирдан хөтөлсөн туршлагаасаа хуваалцахыг оролцогчдоос хүс.

- Эцэг эхчүүд Ариун Сүнсний удирдамжийг хүлээн авахад өөрсдийгөө бэлтгэхийн тулд юу хийж болох вэ? (Оролцогчид энэ асуултыг ярилцах үед дараах судрын хэсгүүдийн заримыг буюу бүгдийг нь уншихад тэднийг урь: Алма 17:2–3; С ба Г 11:21; 20:77; 121:45–46; 136:33.)

Эцэг эхчүүд үлгэр жишээ хийгээд заавраар дамжуулан заадаг.

Эцэг эхчүүд хүүхдүүддээ хоёр ерөнхий арга замаар: өөрсдийн үлгэр жишээ, үг хэлээр дамжуулан заадгийг тайлбарла.

- Эцэг эхчүүдийн үлгэр жишээ хүүхдүүддээ заах тэдний үгсэд ямар байдалаар утга учир нэмдэг вэ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад үйлчилж байхдаа Ахлагч Жеймс Е. Фаустын хийсэн дараах мэдэгдлийг оролцогчдоор уншуул (*Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага*, хуудас 00 (49)):

“Эцэг эхчүүд аюулаас зайлсхийхийн тулд хүүхдүүдээ заахыг хичээх үед, ‘Бид туршлагажсан, бас дэлхийн арга замуудад ухаан суусан, иймээс бид та нарыг бодвол цохио хадны ирмэгт илүү ойрхон очиж чадна’ хэмээн хүүхдүүдээ хэлэх нь эцэг эхчүүдийн хувьд хариулт биш юм. Жишээ нь, эцэг эхчүүд кинонд явахдаа, хүүхдүүдээ кино үзэхийг нь хориглох юм бол, эцэг эхийн үнэлэмж буурна. Хэрэв хүүхдүүдээ шударга байхыг хүсэн хүлээдэг бол, эцэг эхчүүд шударга байх ёстой. Хэрэв хүүхдүүдээ ариун журамтай байхыг хүсэн хүлээдэг бол, эцэг эхчүүд ариун журамтай байх ёстой. Хэрэв та хүүхдүүдээ нэр төртэй байхыг хүсэн хүлээдэг бол, та өөрөө нэр төртэй байх ёстой” (Conference Report, 1990 оны 10-р сар, 41; *Ensign*, 1990 оны 11-р сар, 33–34).

- Сайн мэдээний зарчмуудыг үлгэр жишээгээр заахын тулд эцэг эхчүүд юу хийж болох вэ?

Бишоп Роберт Д.Хейлс Тэргүүлэх Бишопоор үйлчилж байхдаа, “Миний бодлоор, би гэр бүлтэйгээ харилцах харилцаандаа. . . , өөрийхөө эцэг эхээс хүлээж авсан үлгэр жишээг аргагүй даган дуурайхад хүрдэг байсан” хэмээн хэлжээ (Conference Report, 1993 оны 10-р сар, 8; *Ensign*, 1993 оны 11-р сар, 8). Бишоп Хейлс эцэг эхээсээ хэрхэн суралцдаг байсныг дараах дурсамж харуулж байна:

“Санваарыг хүндлэхийг аав маань надад заадаг байлаа. Бид Аароны Санваарт үйлчилж байх үедээ ариун ёслолын зэвэрдэггүй ган тосгуур хэрэглэн ариун ёслолыг түгээдэг байв. Ус дуссаны улмаас тосгуурууд дээр саарал толбо тогтох нь олонтаа байдаг байв. Би Аароны Санваар атгагчийн хувьд ариун ёслолыг бэлтгэхэд туслах үүрэгтэй байлаа. Тосгууруудыг гэртээ авчрахыг аав надаас хүсэхэд, бид хамтдаа ган тосгууруудыг ноосоор гялалзтал нь зүлгэн цэвэрлэв. Би ариун ёслол түгээж байхдаа, бид ариун ёслолын ёслолыг бага ч гэсэн илүү ариун болгоход оролцсоноо санаж байлаа” (Conference Report, 1993 оны 10-р сар, 8; *Ensign*, 1993 оны 11-р сар, 8).

“Өөрийн нөхөр, хүүхдүүдэд бүхнээ зориулсан нэг эхэд—үлгэр жишээгээрээ заадаг байсан нэг эхэд би талархал илэрхийлж байна. Гуч гаруй жилийн турш Халамжийн Нийгэмлэгт түүний бүхнээ зориулсан үйлчлэлийн төлөө би түүнд талархал илэрхийлж байна. Арван зургаан настайдаа, жолооны үнэмлэхээ хүлээн авсны дараа тэрээр бишопыг ядуус хийгээд гачигдалтай хүмүүст анхаарал халамж тавихад тусалж байхдаа намайг өөртэйгөө хамт авч явахад түүнээс суралцах онцгой боломж надад тохиосон билээ” (Conference Report, 1992 оны 4-р сар, 90; *Ensign*, 1992 оны 5-р сар, 65).

- Өөрсдийн үг яриагаар дамжуулан хүүхдүүдээ заах ямар боломжууд эцэг эхчүүдэд байдаг вэ?

Оролцогчид энэ асуултын талаар ярилцах үед, гэр бүлийн залбирал, гэр бүлээрээ судар судлах, түүнчлэн гэр бүлийн үдшийн тухай хичээл 16-д ярилцах болно гэдгийг тайлбарла. Заахад бий болсон эдгээр боломжуудаас гадна, өдөр тутмын амьдралын явцад төлөвлөгдөөгүй үеүдэд заах

олон боломж гарч ирдэг. Эдгээр боломжууд нь заах боломжийн сайхан агшнууд болж болно, учир нь эдгээр нь хүүхдүүдийн хувьд туршлагатай нягт холбоотой байдаг. Ийм туршлагууд хурдан ирж, хурдан байхгүй болж болох учраас, эцэг эхчүүд тэдгээрийг танин мэдэж, хүүхдүүд нь сурахад бэлэн байгаа зарчмуудыг заахад бэлтгэлтэй байх хэрэгтэй.

- Эцэг эхчүүд ажиглан харж болох, төлөвлөгдөөгүй заах зарим агшнууд юу вэ? (Хэрэв энэ асуултад хариулах нь оролцогчдод хүнд байвал, шуурхай ярилцахын тулд дараах зөвлөмжүүдийг хуваалцахыг бод.)

Хүүхдүүд асуулт асуух буюу санаа нь ямар нэг зүйлд зовж байгаа үед, хүүхдүүд болон тэдний найз нарт асуудал бий болсон үед, шийдвэр гаргах болсон үед, эсвэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан санаануудын тухайд анхаарал татагдсан үед эцэг эхчүүд эдгээр заах агшнуудыг ашиглаж болно. Хүүхдүүд алдаанаасаа суралцах хэрэгтэй болсон үед, тэд үйлчлэлд оролцох үед, тэд уур уцаараа хянах хэрэгтэй болсон үед, эсвэл Ариун Сүнсний нөлөөг танин мэдсэн үед заах бусад боломжууд гарч ирдэг.

- Хоолны цаг болон унтах цаг зэрэг гэр бүлийн хэвшлүүд ямар арга замаар заах боломжуудаар хангагдаж болох вэ?
- Хүүхдүүдтэйгээ ганцаарчлан уулзах цаг нь ямар байдлаар эцэг эхчүүдэд заах боломж олгодог вэ? Эцэг эхчүүд хүүхэд нэг бүртэйгээ хамт өнгөрүүлэх цаг гаргахын тулд юу хийж болох вэ?
- Төлөвлөгдөөгүй заах агшнуудын үед та юуг хүүхдүүддээ заах боломжтой байсан бэ?

Энэ цуврал хичээлийн дараагийн дөрвөн хичээлээр эцэг эхчүүд хүүхдүүддээ заах ёстой зарчмууд, түүнчлэн заахад эцэг эхчүүд ашиглах ёстой боломжуудын талаар ярилцах болно гэдгийг тайлбарла.

Дүгнэлт

Эцэг эхчүүд Их Эзэнээс удирдамж эрэлхийлэх үед Тэрээр хүүхдүүддээ заах тэдний хүч чармайлтуудад тэднийг удирдах болно гэдгийг онцлон хэл. Эцэг эхчүүд өөрсдийн үлгэр жишээ хийгээд үг яриагаар дамжуулан хүүхдүүддээ заах хүч чармайлтууддаа байнгын хичээл зүтгэл гаргадаг байх ёстой.

Сүнсээр өдөөгдсөний дагуу, энэ хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Гэр Бүл ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын хуудас 48–53–ыг үз. Оролцогчдыг (1) “Хэрэгжүүлэхэд Зориулсан Санаанууд” дахь зөвлөмжүүдээс доод тал нь нэгийг дагаж, (2) Ахлагч Жеймс Е. Фаустын “Сайн Эцэг Эх Байх нь—Дэлхий Хамгийн Хүч Сорьсон Зүйл,” Ахлагч ЛеГрандын “Хайраар Хүрээлэгдсэн Ширээ” өгүүлүүдийг уншиж энэ хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудыг нэгтгэн дүгнэхэд нь урамшуул. Гэрлэсэн хосууд судлах гарын авлага дахь өгүүлүүдийг хамтдаа уншиж, ярилцсанаар ашиг тусыг олж болохыг онцлон хэл.

САЙН МЭДЭЭНИЙ ЗАРЧМУУДЫГ ХҮҮХДҮҮДЭД ЗААХ НЬ

Хичээл
13

Хэсэг 1

Зорилго

Сайн мэдээний үндсэн зарчмууд хийгээд ёслолуудыг хүүхдүүддээ заах хүсэл, чадвараа дээшлүүлэхэд нь оролцогчдоод туслах.


Бэлтгэл

1. “Багшийн Хувьд Таны Үүрэг Хариуцлагууд” дахь (энэ гарын авлагын хуудас х–хiii) зарчмуудыг хэрэглэж болох арга замуудыг бод.
2. Хичээлийн тод гарчгуудад тоймлогдсон сургаалууд хийгээд зарчмуудыг тунгаан бод. Эдгээр сургаалууд болон зарчмуудыг заах арга замуудыг долоо хоногийн туршид эрж хай. Оролцогчдын хэрэгцээг хангахын тулд та юуг онцлон хэлэх ёстойг шийдэхэд Сүнсний удирдамжийг эрэлхийл.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Эцэг эхчүүдийн заадаг зүйлүүд нь хүүхдүүдийг бат бөх итгэлтэй байхад нь тусалж чадна.

Дараах зургуудыг самбар дээр зур:



- Энэ хоёр зураг юуг төлөөлж байна вэ? Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх тухай эдгээр зургууд юу зааж байна вэ?

Хэрэв эдгээр асуултуудад хариулах нь оролцогчдоод хүнд байвал, мод тарьсан тухай Ерөнхийлөгч Хинклийн түүхийг хичээл 12-оос тэдэнд сануул. (Хэрэв та энэ хичээлийг дангаар нь зааж байгаа бөгөөд хичээл 12-ыг заагаагүй бол, та самбар дээрх зургуудын тухай ярилцахаасаа өмнө хуудас 68–69) дээрх түүхийг хуваалц.)

Зүүн талд байгаа мод нь сайн мэдээнээс зайлсхийж байгаа хүүхдийг төлөөлж байна, учир нь түүний эцэг эх сайн мэдээг гэртээ заагаагүй, мөн сайн мэдээгээр амьдардаггүй аж. Баруун талын мод нь сайн мэдээг эцэг эхийнхээ үг яриа, үлгэр жишээнээс сурч байгаа хүүхдийг төлөөлж байна. Хүчтэй салхи үлээхэд, уяагаар удирдагдсан зулзган мод, шулуун чигээрээ өссөөр байх болно. Үүнчлэн, эцэг эх нь хүүхдүүддээ сайн мэдээний

энгийн зарчмуудыг заасан үед хүүхдүүд итгэлдээ бат бөх үлдэх илүү их магадлалтай байдаг.

Сургаал ба Гэрээ 68:25–28-ыг оролцогчидтой хамт унш.

- Судрын энэ хэсгүүдээр, хүүхдүүдэд юу заахыг Их Эзэн эцэг эхчүүдээс шаарддаг вэ? (Оролцогчдын хариултуудыг доор харуулснаар самбар дээр жагсаан бич.)

Есүс Христэд итгэх итгэл
Наманчлал
Баптисм
Ариун Сүнсний бэлэг хүлээн авах
Залбирал
Их Эзэний өмнө цэх шулуунаар алхлах

- Яагаад эцэг эхчүүд эдгээр зарчмууд болон ёслолуудыг хүүхдүүдэд бага байхад заах нь чухал вэ?

Бишоп Роберт Д.Хейлс Тэргүүлэх Бишопоор үйлчилж байхдаа: “Залбиралыг заалгасан бөгөөд бага байхдаа эцэг эхчүүдэд хамт залбирдаг байсан хүүхдүүд том болсон хойноо илүү их залбирдаг ажээ. Бага байхдаа Их Эзэнийг хайрлахыг заалгаж, Тэрээр амьдардаг гэдэгт итгэсэн хүүхдүүд насанд хүрсэн хойноо өөрсдийн сүнслэг байдлыг үргэлжлүүлэн хөгжүүлж, хайрын мэдрэмжүүдээ өсгөн нэмэгдүүлэх нь илүү олонтаа байдаг ажээ” хэмээн тайлбарлажээ (Conference Report, 1993 оны 10-р сар, 10; *Ensign*, 1993 оны 11-р сар, 10).

Эцэг эхчүүд сайн мэдээний анхны зарчмууд хийгээд ёслолуудыг хүүхдүүдэд заах ёстой.

Итгэлийн хийгээд наманчлалын, түүнчлэн баптисм хүртэхэд бэлтгэх болон Ариун Сүнсний бэлэг хүлээн авах зарчмуудыг хүүхдүүд нь хэрэгжүүлэхэд эцэг эхчүүд тэдэнд тусалж болох арга замуудыг ярилцахад дараах асуултуудыг ашигла. Та ярилцлагыг хөтлөн явуулахдаа, өөрсдийнхөө амьдралын жишээнүүдээс хуваалцахад оролцогчдыг урамшуулан дэмж.

- Есүс Христэд итгэх итгэлийг хөгжүүлэхийн тулд бид Түүний зан төлөв, харьцаа хандлагын тухай зөв ойлголттой байх ёстой. Аврагчийн зан төлөв, харьцаа хандлагыг ойлгоход нь хүүхдүүдэд туслахын тулд эцэг эхчүүд юу хийж болох вэ?
- Есүс Иайрын охиныг эдгээс тухай (Марк 5:21–24, 35–43) түүнчлэн гуулин ялтсуудыг олж авах тухай зарлигт Нифай хариулсан тухай (1 Нифай 3:1–7) шастируудыг товч нэгтгэн дүгнэ. Судрын эдгээр шастирууд Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэхэд нь хүүхдүүдэд хэрхэн тусалж чадах вэ?

- Өөрсдийн амьдралын туршлагаас хуваалцах нь хүүхдийн итгэлийг бэхжүүлэхэд хэрхэн тусалж болох вэ?

Амьдралын сорилт бэрхшээлүүдийг даван туулахад итгэл бидэнд тусалдгийг хүүхдүүдээ заах боломжуудыг эцэг эхчүүд эрж хайх хэрэгтэйг тэмдэглэн хэл. Жишээ нь, хэрэв хүүхдэд хичээл сурлагад нь юм уу, эсвэл найзынх нь хувьд ямар нэг бэрхшээл тохиолдвол, эцэг эхчүүд судрын аль нэг хэсгийг хүүхэдтэйгээ хамт уншиж, удирдамж хийгээд тайтгарлын төлөө залбирахад нь түүнд тусалж, дараа нь Их Эзэн хэрхэн тусалцаа өгдөгийг ойлгоход нь уг хүүхдэд тусалж болно.

- Эцэг эхчүүд наманчлалын тухай хүүхдүүдээ заахыг хичээх үедээ, өдөр тутмын амьдралд заах агшнуудыг эрж хайх нь тэдний хувьд яагаад чухал байдаг вэ?

Хүүхдүүд нь ухаалаг бус шийдвэр гаргахыг харсан үед эцэг эхчүүд уг шийдвэрийн талаар хүүхдүүд нь юу гэж бодож байгааг асууж, энэ тохиолдолд тэд юуг өөрөөр хийж болох байсныг асууж болно гэдгийг тайлбарла. Тэд алдаагаа залруулах боломжийг хүүхдүүдэд олгож, хэрэгтэй бол, Их Эзэнд, түүнчлэн гомдсон буюу хохирсон хүмүүст харамсал илэрхийлж болно. Үнэн наманчлалаар дамжин ирдэг аз жаргал, амар амгаланг танин мэдэхэд нь эцэг эхчүүд бас хүүхдүүдээ тусалж чадна.

- Залуу Алма (Мозая 27; Алма 36) болон Антай-нифай-лихайчуудын (Алма 23) хөрвүүлгүүдийг товч нэгтгэн дүгнэ. Наманчлал болон уучлалын адислалуудыг үнэлэхэд нь судрын эдгээр шастирууд хүүхдүүдэд хэрхэн тусалж чадах вэ?
- Мозая 18:8–10, Сургаал ба Гэрээ 20:37-г оролцогчидтой хамт уншиж, баптисмын гэрээг нэгтгэн дүгнэ. Баптисмын гэрээ хийхэд бэлтгэх болон түүнийг сахихад эцэг эхчүүд хүүхдүүдээ хэрхэн тусалж чадах вэ?
- Баптисм хүртэх хийгээд Ариун Сүнсний бэлэг хүлээн авахыг хүсэн хүлээж байгаа үед нь эцэг эхчүүд ямар арга замаар хүүхдүүдээ тусалж болох вэ?

Эцэг эхчүүд “хүүхдүүдээ залбирахыг, мөн Их Эзэний өмнө тууштай алхахыг заах” ёстой.

- Хүүхдүүд залбирлыг амьдралынхаа байнгын хэсэг болгоход нь туслахад эцэг эхийн үлгэр жишээ яагаад хамгийн агуу багш байдаг вэ?
- Залбирлын загвар бий болгохоос гадна, эцэг эхчүүд залбирлын тухай хүүхдүүдээ зааж болох зарим зарчим юу вэ? (Оролцогчид энэ асуултад хариулах үед, дараах судрын хэсгүүд болон ишлэлийг уншиж, ярилц. Эдгээр заасан зүйлүүдэд холбогдох туршлагаудыг хуваалцахад нь оролцогчдыг урамшуулан дэмж.
 - а. Иаков 1:5–6 (Хэрэв бид Түүнээс итгэлээр гуйх юм бол Бурхан бидэнд мэргэн ухааныг соёрхох болно.)
 - б. 2 Нифай 32:9 (Бид байнга залбирах ёстой. Бид Эцэгт хандан Есүс Христийн нэрээр залбирдаг.)
 - в. Алма 37:37 (Бид өөрсдийн хийдэг бүх зүйлд Их Эзэнтэй зөвлөлдвөл, Тэрээр биднийг сайны төлөө удирдах болно.)

- г. 3 Нифай 18:19–21 (Бид Эцэгт хандан Есүс Христийн нэрээр залбирвал, бид хүссэн зөв зүйлээ хүлээн авах болно. Бид гэр бүлээрээ залбирах ёстой.)
- д. Сургаал ба Гэрээ 112:10 (Бид даруу байх юм бол, Их Эзэн бидний залбирлуудад хариулах болно.)

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс “залбирлын хэлийг” ашиглахын ач холбогдлын тухай өгүүлсэн байдаг. Хүүхдүүд энэ хэлийг эцэг эхчүүдээсээ сурч чадна хэмээн тэрээр хэлжээ:

“Бид ярьж байгаа хүмүүсийг сонсох энгийн арга замаар төрөлх хэлээ сурдаг. Бид Тэнгэрлэг Эцэгтээ хандах үед ярьдаг хэлний хувьд ч энэ нь бас адил юм. Залбирлын хэл бол сурахад бусад ямар ч хэлнээс илүү амархан, илүү аятай сайхан юм. Бид гэр орондоо өдөр тутам хэлдэг янз бүрийн залбирлуудад эцэг эхчүүд нь энэ хэлийг хэрхэн ашигладгийг сонссоноор үүнийг сурах онцгой боломжийг бид хүүхдүүддээ олгох ёстой” (Conference Report, 1993 оны 4-р сар, 20; *Ensign*, 1993 оны 5-р сар, 18).

- Эцэг эхчүүд гэр бүлийн залбирлыг хүүхдүүддээ заах цаг болгон хэрхэн ашиглаж болох вэ?
- Хүүхдүүдийг хувиараа залбирахад нь урамшуулан дэмжихийн тулд эцэг эхчүүд юу хийж болох вэ?
- Их Эзэний өмнө “цэх шулуун алхахыг” эцэг эхчүүд хүүхдүүддээ заах ёстой хэмээн Тэрээр хэлсэн юм (С ба Г 68:28). Хүүхдүүдээ “Их Эзэний өмнө цэх шулуун алхахад” нь урамшуулан дэмжихийн тулд эцэг эхчүүд гэр орон, гэр бүлийн дадал хэвшлүүдээ ямар арга замаар ашиглаж болох вэ? (Сайн мэдээний хуулиуд хийгээд ёслолуудыг дуулгавартай дагах болон бүх цаг үед бүх газарт Бурханы гэрчүүд болон зогсохыг эцэг эхчүүд хүүхдүүддээ заах нь хариултуудад байж болно.)
- Өвөө эмээ болон гэр бүлийн ураг төрлийн бусад гишүүд сайн мэдээний зарчмуудыг хүүхдүүддээ заахад нь эцэг эхчүүдэд туслахын тулд юу хийж болох вэ? Та нар гэр бүлийн ураг төрлийн гишүүдийн сайн үлгэр жишээ ямар байдлаар хүүхдүүдэд тусалж болохыг үзсэн бэ?

Дүгнэлт

Зөв шударга ёсны зарчмуудыг хүүхдүүддээ заах үүрэг хариуцлагыг Бурхан эцэг эхчүүдэд ноогдуулсныг онцлон хэл. Энэ хичээлээр заагдсан зарчмуудаар амьдрахыг хичээж, эдгээр зарчмуудыг хүүхдүүдэд илүү сайнаар зааж болох арга замуудыг тодорхойлоход нь оролцогчдыг урамшуулан дэмж.

Сүнсээр өдөөгдсөний дагуу, энэ хичээлээр ярилцсан үнэнүүдийн тухай өөрийн итгэл үнэмшлийг хуваалц.

Гэр Бүл ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын хуудас 54–57-г үз. Оролцогчдыг (1) “Хэрэгжүүлэхэд Зориулсан Санаанууд” дахь зөвлөмжүүдээс наад тал нь нэгийг дагаж, (2) Ахлагч Роберт Хейлсийн “Гэр Бүлүүдийг Бэхжүүлэх нь: Бидний Нандин Үүрэг” өгүүллийг уншиж энэ хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудыг нэгтгэн дүгнэхэд нь урамшуулан дэмж. Гэрлэсэн хосууд судлах гарын авлага дахь өгүүлүүдийг хамтдаа уншиж, ярилцсанаар ашиг тус олж болохыг онцлон хэл.

САЙН МЭДЭЭНИЙ ЗАРЧМУУДЫГ ХҮҮХДҮҮДЭД ЗААХ НЬ

Хичээл
14

Хэсэг 2

Зорилго Өрөвч сэтгэл, үйлчлэл, шударга зан чанар хийгээд бусдын өмчийг хүндэтгэх, шударга хөдөлмөрийн баяр хөөр, ёс суртахууны цэвэр ариун байдлыг хүүхдүүдэд заах хүсэл, чадвараа дээшлүүлүүлэхэд нь оролцогчдод туслах.

Бэлтгэл

1. “Багшийн Хувьд Таны Үүрэг Хариуцлагууд” дахь зарчмуудыг нэгтгэн дүгнэ (энэ гарын авлагын хуудас х–хiii). Эдгээр зарчмуудыг заах бэлтгэлдээ хэрэглэх арга замуудыг эрж хай.
2. Энэ хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудыг тоймлосон хичээлийн тод гарчгуудыг унш. Бэлтгэлийнхээ нэг хэсэг болгон эдгээр сургаалууд болон зарчмуудыг хэрэглэхэд нь оролцогчдод туслах арга замуудыг долоо хоногийн турш тунгаан бод, оролцогчдын хэрэгцээг хангахын тулд та юуг онцлон хэлэх ёстойг шийдэхэд Сүнсний удирдамжийг эрэлхийл. Хэрэв шаардлагатай бол, эдгээр зарчмуудыг заахад хоёр хичээлийн хугацаа гарга.
3. Хэрэв дараах материалууд байдаг бол, эдгээрийг ангид авчирч, нэгтгэн дүгнэ:
 - а. *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* (34285).
 - б. *Эцэг Эхчүүдийн Гарын Авлага* (31125).

Энэ хичээлийг заах зөвлөмж

Эцэг эхчүүд хүүхдүүддээ заах үед тэдэнд хайраа харуулдаг.

Далын Ахлагч Лорен К.Даннын өгүүлсэн дараах туршлагыг хуваалц:

“Биднийг нэг багахан хамт олны дунд өсч байх үед ах бид хоёр ажлын зарчимд суралцах хэрэгтэй байсныг аав маань олж харсан юм. Үүний дүнд тэрээр өөрөө тэнд өссөн хотын зах дахь нэг жижгхэн фермд бид хоёрыг ажилд оруулав. Аав маань орон нутгийн сонин эрхлэн гаргадаг байв, тиймээс тэрээр өглөө эрт юм уу үдэш орой л биш бол бидэнтэй хамт олон цагийг өнгөрүүлж чаддаггүй байв. Энэ бол идэр насны хоёр залуугийн хувьд яггүй үүрэг хариуцлага байсан учраас бид заримдаа алдаа гаргадаг байлаа.

“Манай жижигхэн фермийн эргэн тойронд бусад фермүүд байдаг байв, тэгээд фермчдийн нэг нь нэг өдөр аавтай уулзаж, түүний бодсон зүйлүүдийг бид буруу хийж байгааг аавд хэлэхээр ирэв. Аав маань түүнийг анхааралтай сонсоод, ‘Жийм, та ойлгосонгүй. Үхэр биш, хөвгүүдийг өсгөн хүмүүжүүлж байна шүү дээ’ гэж хэлж билээ. Аавыг өөд болсны дараа, Жийм энэ түүхийг бидэнд ярьсан юм. Үхэр биш, хөвгүүдийг өсгөн хүмүүжүүлэхээр шийдсэн аавынхаа төлөө би хичнээн их талархалтай байв аа. Алдаагаа үл хайхран, бид тэр жижигхэн ферм дээр хэрхэн ажиллахыг сурсан, ийнхүү тэд үүнийг олон үгээр хэлээгүй ч гэсэн, бид Ээждээ бас Аавдаа

талархалтай байдаг байлаа, учир нь үхэр, эсвэл өөр ямар ч юмнаас тухайн асуудал илүү чухал байсныг бид ямагт мэддэг байсан гэж би боддог” (Conference Report, 1974 оны 10-р сар, 12; *Ensign*, 1974 оны 11-р сар, 11).

- Энэ түүхийн юу нь та нарын сэтгэлийг хөдөлгөсөн бэ?

Ахлагч Данн, түүний ах хоёр эцэг эх нь тэдэнд хайртайг ямагт мэддэг байсныг онцлон хэл. Эцэг эхчүүд хүүхдүүдээ хайрлах хайраа харуулах нэг хэлбэр бол сайн мэдээний зарчмуудыг хүүхдүүд нь сурч, хэрэглэхэд тэдэнд туслахын тулд цаг гаргах явдал юм. Сайн мэдээгээр амьдрах үндсэн таван зарчим: өрөвч сэтгэл ба үйлчлэл, шударга зан чанар, бусдын өмчийг хүндэтгэх, шударга хөдөлмөрийн баяр хөөр, ёс суртахууны цэвэр ариун байдлыг хүүхдүүдэд хэрхэн заах тухай энэ хичээлээр ярилцдаг.

Эцэг эхчүүд өрөвч сэтгэл, үйлчлэлийг хүүхдүүдэд заах ёстой.

Аврагч Өөрийн тохинууллын туршид, бусдыг хайрлан, тэдэнд үйлчлэхийн ач холбогдлыг заадаг байлаа. Тэрээр энэ зарчмыг үг яриа, үлгэр жишээгээр заадаг байв.

- Бусдыг хайрлаж, тэдэнд үйлчлэхийг эцэг эхчүүдээсээ сурсан хүүхдүүдэд ямар ашиг тус ирдэг вэ? (Оролцогчдын хариултуудыг хүсэхийн хамт, дараах жишээнүүдийг хуваалц.)

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Гүйцэтгэх Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Боид К.Пакер:

“Заах буюу Сүмд удирдах гэхчлэн олон янзын дуудлагад үйлчилсэн нэг ялдамхан эгчийг би олон жилийн турш ажиглаж байна. Тэрбээр хэрэгцээг харж тэгээд үйлчлэхдээ, ‘Хэрэв танд тусламж хэрэгтэй бол надад утасдаарай’ гэдэггүй, харин ‘Би энд байна; би юу хийж болох вэ?’ гэдэг. Цуглаан дээр хэн нэгний хүүхдийг харах, автобуснаас хоцорсон хүүхдийг сургуульд нь хүргэж өгөх гэхчлэн үй олон жижиг зүйлүүдийг тэрээр хийдэг ажээ. Тэрээр Сүмд шинээр ирсэн хүмүүсийг үргэлж хайж, тэгээд тэдэнд баяр хүргэхээр урагш алхдаг. . . .

“Үйлчлэлийн сүнс ээжээс нь түүнд ирснийг тэр мэддэг байв. Үйлчлэлийн сүнс гэр оронд хамгийн сайнаар заагддаг. Бид хүүхдүүддээ үлгэр жишээгээр заах ёстой, мөн амин хувиа үл хичээдэг сүнс аз жаргалд зайлшгүй шаардлагатайг тэдэнд хэлэх ёстойг” ажиглажээ (Conference Report, 1997 оны 10-р сар, 5; *Ensign*, 1997 оны 11-р сар, 6).

Нэг гэр бүлд нэг хүүхдэд хүнд цаг үе тохиожээ. Түүнд учирсан сорилтыг даван туулахад түүнд туслахын тулд гэр бүлийн өөр нэг гишүүнд өдөр бүр үйлчлэлийн нууц үйл ажиллагаа гүйцэтгэхэд нь түүнийг эцэг эх нь урамшуулан дэмжсэн аж. Долоо хоногийн сүүлч гэхэд тэрээр өөртөө учирсан бэрхшээлийн тухайд санаа зовох нь багасч, бусдад анхаарал халамж тавьснаас ирсэн адислалууд хийгээд амар амгаланг эдэлж эхэлжээ.

- Бид өөр хаа нэгтээ сурч чадахгүй ямар үйлчлэлийг гэр орондоо сурч болох вэ?
- Бусдад үйлчлэхийг хүүхдүүддээ заахад эцэг эхчүүдэд тусалж чадах ямар зөвлөмжүүдийг та нар хуваалцаж чадах вэ?

Оролцогчдын хариултуудыг самбар дээр бичихийг бод. Өөрсдийнхөө амьдралын жишээнүүдээс хуваалцахад нь оролцогчдыг урамшуулан дэмж. Түүнчлэн гэр бүлийн үйлчлэлийн санаануудыг хуваалцахыг тэднээс хүс. Та ярилцлагыг хөтлөн явуулахдаа, дараах санаануудыг гарга:

- а. Эцэг эхчүүд гэр бүлийн гишүүдэд үйлчилж, Сүмийн үүрэгт ажлуудыг биелүүлэн, эргэн тойрныхоо бусад хүмүүст туслахад гараа сунгаснаар үлгэр жишээг бий болгож чадна.
- б. Хүүхдүүд нь гэр бүлийн гишүүд болон эргэн тойрныхоо бусад хүмүүст үйлчлэх боломжуудыг хайж болно. Бүр бага насны хүүхдүүд ч гэсэн үйлчлэлийн баяр хөөрийг мэдэрч чадна.

Бусдын өмч хөрөнгөнд үнэнч хүндэтгэлтэй хандахыг эцэг эхчүүд хүүхдүүдэд заах ёстой.

Тэргүүн Зөвлөлд Нэгдүгээр зөвлөхөөр үйлчилж асан, Ерөнхийлөгч Н.Элдон Таннерын дараах зөвлөгөөг хуваалц:

“Шударга занд сургах нь гэр оронд эхэлдэг. Бид бүгдээрээ зөвхөн бидний өөрсдийнх болох хувийн эд юмстай байдаг. Тоглоомууд түүнчлэн бие биендээ үйлчлэх үйлчлэл мэтийн зүйлүүдийг бид хуваалцаж болно, хуваалцах ёстой; гэвч хувийн өмч болох мөнгө буюу үнэт эдлэлүүд эсвэл хувцас хунар зэргийг эзэнийх нь зөвшөөрөлгүйгээр авч болдоггүй зүйлүүд бидэнд байдаг. Ийм шударга занг гэр орондоо хүндэтгэн үздэг хүүхэд гэр орноосоо гадуур уг зарчмыг зөрчдөггүй. Нөгөө талаар, ийм сургалт дутагдах нь бусдын эрх хийгээд бусдын өмч хөрөнгөнд хүндэтгэлгүй хандахад түлхэц үзүүлдэг” (Conference Report, 1978 оны 4-р сар, 64; *Ensign*, 1978 оны 5-р сар, 44).

- Бусдын өмч хөрөнгөнд хүндэтгэлтэй хандахыг хүүхдүүдэд заагаагүй үед юу тохиолдож болох вэ?
- Шударга зантай байж, бусдын өмч хөрөнгөнд хүндэтгэлтэй хандахыг хүүхдүүд ямар арга замаар гэр орондоо сурч болох вэ? Эдгээр зарчмуудыг эцэг эхчүүд хүүхдүүддээ хэзээ зааж эхлэх ёстой вэ?

Эцэг эхчүүд шударга хөдөлмөрийн шагналын талаар хүүхдүүдэд заах ёстой.

Эцэг эхчүүд ажиллахыг хүүхдүүддээ заахын ач холбогдлын талаар Сүмийн удирдагчид эцэг эхчүүдэд байнга зөвлөдгийг тайлбарла. Ажиллахыг хүүхдүүдэд заах нь заримдаа хэцүү байдаг ч гэсэн, эцэг эхчүүд энэхүү оролдлогодоо шаргуу байх ёстой. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Л.Тоом Перри, “Шударга хөдөлмөрийн баяр хөөрийг хүүхдүүдэд заах нь тэдэнд таны хүртээж болох бүх бэлгүүдээс хамгийн агуу нь юм” хэмээн зөвлөжээ (Conference Report, 1986 оны 10-р сар, 78; *Ensign*, 1986 оны 11-р сар, 62).

- Хүүхдүүдийг бага байхад нь ажил хөдөлмөрийн зарчмуудыг заахын үнэ цэнэ юу вэ? Ажиллаж сурахад нь эцэг эхчүүд хүүхдүүддээ хэрхэн тусалж болох вэ? (Оролцогчид энэ асуултыг ярилцах үед, өөрсдийнхөө амьдралын жишээнүүдээс хуваалцахад нь тэднийг урамшуулан дэмж. Ярилцлагыг идэвхжүүлэхийн тулд дараах санаануудыг дурдахыг бод.)

- а. Гэрийн ажилд баяр хөөртэйгөөр туслах замаар хүүхдүүдэд үлгэр жишээ үзүүл.
- б. Чадварт нь тохирсон ажил үүргүүдийг хүүхдүүдэд өг.
- в. Ажил үүрэгтээ хэрхэн амжилт гаргахыг хүүхдүүдэд заах цаг гарга.
- г. Тусалсных нь төлөө хүүхдүүдэд талархал илэрхийл.

Дараах мэдэгдлүүдээс нэгийг нь, эсвэл хоёуланг нь унш:

Сүмийн 15 дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли, “Хүүхдүүд эцэг эхчүүдтэйгээ хамт—сав суулга угаах, шал арчих, зүлэг хадах, мод, бут сөөг тайрч засах, будах, засах, цэвэрлэх зэрэг хэдэн зуун бусад зүйлийг хийх хэрэгтэй, ингэснээр тэд ажил хөдөлмөр бол цэвэр цэмцгэр байдал, өсөлт дэвшил хийгээд цэцэглэл хөгжилтийн үнэ цэнэ болохыг мэдэх болно” гэж зөвлөжээ (*Teachings of Gordon B. Hinckley* [1997], 707).

Ахлагч Жеймс Е.Фауст Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад үйлчилж байхдаа: “Сахилгатай, хариуцлагатай байхыг хүүхдүүдэд зааж сургахын нэн чухал хэсэг нь тэднийг ажиллаж сургах явдал мөн. . . . Ажлын зарчмын шилдэг багш бол эцэг эхчүүд өөрсдөө юм. Миний хувьд, би анх удаа аав, өвөг эцэг, авга ах нар болон ах нарынхаа дэргэд ажиллаж байсан үед ажил миний баяр хөөр болсон юм. Би нэмэр болохоосоо илүүгээр олонтаа нэрмээс болж байснаа мэддэг байсан ч, аятай сайхан дурдатгалууд үлдэж, үнэт сургамжууд авсан билээ. Хүүхдүүд хариуцлага, бие даасан байдалд суралцах хэрэгтэй. Лихай сургасанчлан, хүүхдүүд ‘өөрсдийнхөө төлөө үйлдэх, түүнчлэн . . . дээрээ үйлдүүлэхийн’ (2 Нифай 2:26) тулд эцэг эхчүүд үзүүлэх, харуулах хийгээд тайлбарлах цагийг биечлэн гаргадаг уу?” (Conference Report, 1990 оны 10-р сар, 42; *Ensign*, 1990 оны 11-р сар, 34; мөн түүнчлэн *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага*, хуудас 50-ыг үз).

- Эцэг эх, гэр бүлийн бусад гишүүдийн дэргэд ажиллах нь хүүхдүүдийн хувьд яагаад чухал вэ? Гэр бүлийн гишүүд хамтдаа ажиллах үед харилцаанд ямар байдлаар нөлөөлдөг вэ?
- Шударга хөдөлмөрийн зарим шагнал юу вэ? (Дараах жагсаалтан дахь хариултууд байж болно.)
 - а. Сайн хийгдсэн ажил дахь сэтгэл ханамж хийгээд баяр хөөр
 - б. Амжилт бүтээлийн мэдрэмж
 - в. Чухал шаардлагатай дадлага ур чадвар эзэмших
 - г. Өөрийнхөө үнэ цэнийг мэдрэх
 - д. Онц дүн, санхүүгийн ашиг тус зэрэг материаллаг шагналууд
- Ямар байдлаар ажил нь сүнслэг адислал, мөн түүнчлэн материаллаг адислал болдог вэ?
- Хүүхдүүд нь мөнгө олж, үүнийгээ ухаалгаар ашиглахад нь туслахын тулд эцэг эхчүүд юу хийж болох вэ? Хүүхдүүд нь ажил эрхлэлтийг Сүмийн ажил, сургуулийн ажил, түүнчлэн гэрийн ажил зэрэг бусад төрлийн ажлуудтай уялдуулан зохицуулахад эцэг эхчүүд хэрхэн тусалж болох вэ?
- Ажиллах хариуцлагаас зайлсхийхийг хүүхдүүддээ зөвшөөрдөг эцэг эхчүүдийн аюул юу вэ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Нийл А.Максвелл сургахдаа:

“Сайн мэдээний ажил бол ‘сайн мэдээний бүрэн байдлын’ хэсэг юм. Хэдийгээр баяр баясгалантай ч гэсэн, номлогчийн ажил бол мөн л ажил. Хэдийгээр баяр баясгалантай ч гэсэн, ариун сүмийн ажил бол мөн л ажил. Гэхдээ л, урам муутай манай залуусын цөөн хэдхэн нь дажгүй сайн ажилладаг, харин олонх нь өөрсдийгөө зугаацуулахыг л хичээдэг. . . .

“Хүүхдүүд чинь таны хувьд ямар байгаагаас илүү ихээр юмсыг сайжруулахын тулд хэтэрхий их хүсэхээс . . . болгоомжил. Гэвч, тэдний туршлагын хэсэг болсон ажилд тавих үндэслэлтэй шаардлагуудыг санаандгүйгээр үгүй болгосноор, таныг өөрийг тань хэн бэ гэдгийг бий болгоход тусалдаг чухам тэр зүйлүүдээс хүүхдүүдээ тусгаарлах замаар юмсыг бүү дордуул!” гэжээ (Conference Report, 1998 оны 4-р сар, 50; *Ensign*, 1998 оны 5-р сар, 38).

Эцэг эхчүүд цэвэр ариун ёс суртахууныг хүүхдүүдэд заах ёстой.

Эцэг эхчүүд Их Эзэний цэвэр ариун ёс суртахууны жишгүүдийг хүүхдүүдэд заах үүрэгтэйг онцлон хэл. Энэ уруу таталтыг эсэргүүцэхэд нь хүүхдүүдэд туслах болно.

- Эцэг эхчүүд яагаад цэвэр ариун ёс суртахуун, бэлгийн цэвэр ариун харилцааг хүүхдүүдтэйгээ ярилцах санаачлагыг гаргах ёстой вэ? Эцэг эхчүүд энэ санаачлагыг гаргахгүй байхын эрсдэл юу вэ?

Өнөөгийн дэлхийд, хүүхдүүд бэлгийн харилцааны тухай сонсохоос зайлсхийх аргагүйг анхааруулан хэл. Гэвч, дэлхийд тэдний сонсдог зүйлийн ихэнх нь нөхөн үржихүйн энэхүү ариун нандин хүчийг буруугаар ашиглахыг хөхүүлэн дэмждэг. Хүүхдүүдэд—ялангуяа өсвөр үеийнхэнд—эдгээр сэдвүүдээр үнэн зөв мэдээлэл, үнэн сургаал хэрэгтэй байна. Дэлхийд заагдаг худал хуурмаг зүйлүүдийн эсрэг сөрөн зогсох хүч чадлыг олоход нь эцэг эхчүүд тэдэнд туслах ёстой. Нөхөн үржихүйн хүчийг ашиглах Их Эзэний төлөвлөгөөг тэд хүүхдүүдэд заах ёстой.

Эдгээр сэдвүүдийг хүүхдүүдэд заахад амжилт олсон туршлагауудынхаа талаар ярихыг эцэг эх болсон оролцогчдоос хүс. Оролцогчдын ойлголтуудыг асуухын хамт, дараах зарчмуудыг хуваалц:

Бүр бага насны хүүхдүүдэд тэдний биеийн ариун нандин шинж чанарын тухай энгийн тодорхой мэдээлэл өгөх хэрэгтэй. Ийм ойлголт нь тэднээс давуу талыг олж авахыг хичээж болох хүмүүсээс өөрсдийгөө хамгаалахад нь тэдэнд тусалдаг. Хүүхдүүд бэлгийн хөгжил гүйцэх насанд ойртох үед эцэг эхчүүд тэдний биед гардаг өөрчлөлтүүдийг тэдэнд болгоомжтойгоор тайлбарлаж өгөх ёстой. Бие бялдрын хөгжил гүйцэх нь хэвийн зүйл бөгөөд Бурханы төлөвлөгөөний нэг хэсэг гэдгийг тэд тайлбарлах хэрэгтэй.

Их Эзэний тавьсан хязгаарлалтуудын хүрээнд бэлгийн харилцааг ашиглах нь сайн зүйл, харин үүнийг Их Эзэний зарлигуудыг зөрчиж хэрэглэх нь ноцтой нүгэл гэдгийг хүүхдүүд нь ойлгоход эцэг эхчүүд бас туслах ёстой. Их Эзэний жишгүүдийн талаар өсвөр үеийнхэнд эцэг эхчүүдээс нь тодорхой удирдамж хэрэгтэй.

Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө товхимлыг үзүүл. Энэ товхимол нь залуучууд болон тэдний эцэг эхчүүдэд онцгой хэрэгтэй тусламж өгдгийг тайлбарла. Энэ товхимол нь болзоо, хувцаслалт, хэл яриа, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл түүнчлэн хөжим, бүжгийн тухай Сүмийн жишгүүдээрх

мэдээллийг агуулдаг. Энэ товхимлыг өсвөр насны эхэн үедээ байгаа хүүхэд нэг бүртэйгээ хамт уншиж, ярилцахад нь эцэг эхчүүдийг урамшуулан дэмж. Энэ нь ярилцахад хүнд байж болох сэдвүүдийг хялбар дөхөм байдлаар хөндөн ярих арга замаар хангадаг. Энэ бас ёс суртахууны жишгүүдийн талаар өвөрмөц асуултууд асуух боломжийг залуучуудад олгодог. Уг товхимлын хуудас 26–27 дахь дараах түүвэрлэн авсан хэсгүүдийг хуваалц:

“Бэлгийн харилцааны онцгой дотно байдал нь гэрлэлтийн холбооны хүрээнд хүүхэд төрүүлэхийн тулд хадгалагдан хамгаалагдах ёстой гэж бидний Тэнгэрлэг Эцэг зөвлөдөг. Нөхөр эхнэр хоёрын хоорондох бие махбодийн харилцаа эрхэм сайхан бөгөөд ариун нандин юм. Энэ нь хүүхэд төрүүлэх хийгээд гэрлэлтийн хүрээнд хайр дурлалаа илэрхийлэхийн тулд Бурханаас томилогддог: ‘Тиймээс эр хүн эцэг эхээ орхиод, эхнэртэйгээ нийлэн, тэр хоёр нэгэн бие болох ажгуу’ (Эхлэл 2:24).

“Бэлгийн харилцааны онцгой дотно байдал маш ариун нандин учраас, гэрлэлтийн өмнө өөртөө болон цэвэр ариун байдалд хяналт тавихын хамт бас гэрлэлтийн дараа бие биендээ бүрэн үнэнч байхыг Их Эзэн шаарддаг. Болзоонд, болзоо тавьсан хүндээ хүндэтгэлтэй хандаж, мөн өөртөө ингэж хандахыг болзоо тавьсан хүнээсээ хүсэн хүлээ. Болзоо тавьсан хүндээ хэзээ ч өөрийн тачаангуй хүсэл буюу аминч бодлоо гүйцэлдүүлэхэд ашиглаж болох ямар нэг зүйл мэтээр хэзээ ч бүү ханд. Бие махбодийн зохисгүй харилцаа өөрийгөө хянах хяналтыг алдагдуулж болно. Өөрийгөө болон бие махбодийнхоо мэдрэмжүүдийг үргэлж хянаж бай.

“Зарим тодорхой авир, түүний дотор гэрлэлтийн өмнөх бэлгийн бүхий л харилцаа, илж таалах, бэлгийн гаж буруу зуршил (ижил хүйстэнтэйгээ хурьцах, хүчин, цус ойртолт буюу ойрын садан төрлүүдийн хоорондох бэлгийн харилцаа), бэлэг эрхтнээ гараараа оролдож дур тавих буюу бодол санаа, үг яриа, үйлдлээр бэлгийн харилцааг эгээрэн хүсэхийг Их Эзэн онцгойлон хориглодог. . . .

“Ижил хүйстэнтэйгээ хурьцах болон лесбийн үйлдэл бол нүгэлтэй бөгөөд Их Эзэнд жигшүүртэй юм (Ром 1:26–27, 31-ийг үз). Хэвийн биш хүсэл тэмүүлэл, түүний дотор ижил хүйсийн хүмүүс рүү тэмүүлэх нь өөрийн хүүхдүүдэд зориулсан Бурханы мөнхийн төлөвлөгөөнд харш юм. Та нар зөв сонголтууд хийх үүрэг хариуцлага хүлээдэг. Ижил буюу эсрэг хүйсийн хүмүүст хандсан байна уу ялгаагүй, тачаангуй мэдрэмж хийгээд хүсэл нь илүү ноцтой нүглүүд руу хөтөлж болно. Хожмын үеийн бүх Гэгээнтнүүд өөрсдийгөө хянах болон өөрсдийгөө сахилгажуулахад суралцах ёстой.”

Эцэг эхчүүд бэлгийн харилцааны тухай хүүхдүүдтэйгээ ярилцах үед, цэвэр ариун ёс суртахуун нь баяр хөөр, амар амгалан руу хөтөлдгийг тэд гэрчилж болно.

- Эцэг эхчүүд цэвэр ариун ёс суртахууны тухай заахын хамт энэ талаар үлгэр жишээ үзүүлэх нь яагаад нэн чухал вэ? Эцэг эхчүүд ямар арга замаар цэвэр ариун ёс суртахууны үлгэр жишээ үзүүлж болох вэ?

Эцэг эх нь бие биендээ ханддаг байдлаар, эцэг эх нь гэр орондоо байлгахыг зөвшөөрдөг ном зохиол, олон нийтийн мэдээллийн бусад хэрэгслүүдийн төрлөөр, тэрчлэн эцэг эхчүүд нь нөхөн үржихүйн ариун нандин хүчний талаар ярьдаг байдлаар хүүхдүүд цэвэр ариун ёс суртахууны үнэн зарчмуудыг сурч чадна гэдгийг анхааруулан хэл.

Дүгнэлт

Эцэг эхчүүд шударга ёсны зарчмуудыг хүүхдүүдэд заах үүрэг хариуцлагатайг онцлон хэл. Энэ хичээлээр заагдсан зарчмуудаар амьдрахыг эрмэлзэхэд нь, түүнчлэн эдгээр зарчмуудыг хүүхдүүдэд илүү сайнаар заах арга замуудыг тодорхойлоход нь оролцогчдыг урамшуулан дэмж.

Сүнсээр өдөөгдсөний дагуу, энэ хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай өөрийн итгэл үнэмшлийг хуваалц.

Гэр Бүл ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын хуудас 58–63-ыг үз. Оролцогчдыг (1) “Хэрэгжүүлэхэд Зориулсан Санаанууд” дахь зөвлөмжүүдээс доод тал нь нэгийг дагаж, (2) Ерөнхийлөгч Бойд К.Пакерын “Хүүхдүүдэд Зааж Сурга” өгүүллийг уншиж энэ хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудыг нэгтгэн дүгнэхэд нь урамшуулан дэмж. Гэрлэсэн хосууд судлах гарын авлага дахь өгүүлүүдийг хамтдаа уншиж, ярилцсанаар ашиг тус олж болохыг онцлон хэл.

Зорилго

Хүүхдүүдээ шийдвэр гаргахад нь эцэг эхчүүдэд туслах зарчмуудыг заах.

Бэлтгэл

1. Та өөрийгөө заахад бэлтгэж байхдаа “Багшийн Хувьд Таны Үүрэг Хариуц-лагууд” дахь (энэ гарын авлагын хуудас х–xiii) зарчмуудыг хэрэглэж болох арга замуудыг эрж хай.
 2. Хичээлийн тод гарчгуудыг унш. Эдгээр гарчгууд энэ хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудын тоймыг өгдөг. Бэлтгэлийнхээ нэг хэсэг болгон эдгээр сургаалууд болон зарчмуудыг хэрэглэхэд нь оролцогчдод туслах арга замуудыг тунгаан бод. Оролцогчдын хэрэгцээг хангахын тулд та юу онцлон хэлэх ёстойг шийдэхэд Сүнсний удирдамжийг эрэлхийл.
 4. Хичээл дээр нэг жижигхэн хайрга авчир. Та үүнийг хичээлийн сүүлчийн хэсэгт ашиглах болно.
-

**Энэ хичээлийг
заах зөвлөмж**

Хүүхдүүдэд шийдвэр гаргахад нь удирдамж хэрэгтэй.

Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Томас С.Монсон ерөнхий чуулган дээр хуваалцсан дараах шүлгийг унш:

Салаа зам дээр орь ганцаар зогсоно тэр,
Сайхь дэлхийн талаар юу ч үл төсөөлнө тэр.
Ээх нарны гэрэл нүүрэнд нь тусна—
Эрийн ёсоор уралдаад үзье гэж шийдсэн гэнэ тэр.
Зүүн тийш зам одно, баруун тийш зам одно,
Зүгээр ч үгүй хамгийн сайныг нь эс мэднэ тэр;
Доош нь хөтлөх замыг тэгээд сонгож гэнэ тэр,
Доройтон уралдаанд хожигдож, ялагчийн титмийг алдаж гэнэ.
Сайхь эр эцэст нь муухай занганд орж гэнэ
Салаа зам дээр тэнд хэн ч байсангүйнх гэнэ
Сайн замыг түүнд заах хэн ч байсангүйнх гэнэ.

Өөр нэг өдөр яг тэнд,
Өөдрөг бодолтой хөвгүүн ирж гэнэ.
Эрийн ёсоор уралдаад үзэхээр тэр ч бас шийдэж гэнэ;
Эрсээр байсан гэнэ, тэр ч бас сайныг;
Аль ч замыг мэддэг нэгэн тэнд байсан гэнэ,
Алинаар нь явахыг тэгээд түүнд зааж гэнэ.
Доош нь хөтөлж мэдэх замаас эргэж гэнэ тэр,
Доройтолгүй уралдаанд түрүүлж, ялагчийн титмийг хүртэж гэнэ.
Сайхь хөвгүүн өргөн дардан замаар өөдрөгхөн алхана, өнөөдөр
Салаа зам дээр тэнд хэн нэгэн байсных гэнэ.
Сайн замыг тэр түүнд заасных гэнэ.

[Central Christian Monitor-оос иш татав, Conference Report, 1993 оны 10-р сар, 66–67; Ensign, 1993 оны 11-р сар, 48]

Хүүхэд залуучууд салаа зам дээр байх—өөрөөр хэлбэл амьдралд нь урт удаан хугацаанд нөлөөлөх шийдвэр гаргах үетэй олонтаа тулгардгийг тайлбарла. Арга замуудыг мэддэг эцэг эхчүүд зөв шийдвэр гаргахад нь хүүхдүүд дээ туслахын тулд тэнд байх ёстой. Тэр ч байтугай хүүхдүүд шийдвэр гаргах агшинд эцэг эхчүүд тэдэнтэй хамт байж чадахгүй үед, тэд эцэг эхийнхээ заадаг зүйлүүдийг санан, Ариун Сүнсний өдөөлтүүдэд найдвар тавин, удирдамж хүлээн авдаг байх ёстой.

Эцэг эхчүүд хүүхдүүдэд сонгох эрхээ зөвөөр хэрэгжүүлэхэд нь тусалж чадна.

Сонгох эрх бол Тэнгэрлэг Эцэгээс бидэнд соёрхсон хамгийн агуу бэлгүүдийн нэг гэдгийг тайлбарла. Сонгох эрх бол өөрсдийнхөө төлөө сонголт хийж, үйлдэх хүч буюу эрх мөн. Бид сонгох эрхээр дамжуулан Аврагчийг дагахаар, түүнчлэн мөнх амьдралын адислалыг хүлээж авахаар сонгосон билээ (2 Нифай 2:25–28-ыг үз).

Сургаал ба Гэрээ 58:27–28-ыг оролцогчидтой хамт унш.

- Судрын энэ хэсэг хүүхдүүд нь шийдвэр гаргах үед эцэг эхчүүд тэдэнд ямар арга замаар туслах тухайд холбогдох вэ?
- Шийдвэр гаргахыг хүүхдүүдэд зөвшөөрөхийн ашиг тус юу вэ?

Хүүхдүүд сонгох эрхээ зөвөөр хэрэгжүүлэхэд эцэг эхчүүд тэдэнд туслахын тулд баримталж болох зарчмуудыг дараах материал тоймлон харуулдаг. Эдгээр зарчмуудыг оролцогчидтой хамт ярилц.

Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын агуу төлөвлөгөөг хүүхдүүдэд заа.

Алма 12:32-ын дараах хэсгийг оролцогчидтой хамт унш:

“Тиймийн тул Бурхан тэдэнд гэтэлгэлийн төлөвлөгөөг мэдүүлсний дараа тэдэнд зарлигуудыг өгсөн юм.”

- Бурхан гэтэлгэлийн төлөвлөгөөг мэдүүлсний дараа зарлигуудыг өгсөн нь яагаад чухал ач холбогдолтой болсон бэ? Хүүхдүүд нь зарлигуудыг дуулгавартай дагахад урамшуулан дэмжих эцэг эхчүүдийн хүч чармайлтад энэ зарчим ямар арга замаар холбогдох вэ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Боид К.Пакер сургахдаа:

“Залуу хүмүүс ‘яагаад?’ хэмээн гайхдаг—Яагаад бид зарим зүйлийг *хийхээр* зарлиг болгогддог вэ, мөн бид яагаад бусад зүйлүүдийг *хийхгүй* байхаар зарлиг болгогддог вэ? Аз жаргалын төлөвлөгөөний тухай мэдлэг . . . ‘яагаад’ гэдгийг залуу оюун ухаанд өгч чадна . . .

“Уруу таталтынх нь үед та хүүхдүүдтэйгээ хамт байдаггүй. Тийм аюултай мөчүүдэд тэд өөрсдийнхөө боломжууд дээр тулгуурлах болно. Хэрэв тэд сайн мэдээний төлөвлөгөөний хүрэн дотор өөрсдийгөө байрлуулж чадах юм бол, тэд бат бөхөөр хүчирхэгжих болно.

“Уг төлөвлөгөөг дахин дахин давтах ёстой. Тэгвэл амьдралын зорилго, Гэтэлгэгчийн бодит байдал, зарлигуудын учир шалтгаан тэдэнтэй хамт байх болно.

“Тэд сайн мэдээг судлах нь, тэдний амьдралын туршлага нь Христийн тухай, Цагаатгалын тухай, сайн мэдээний сэргээлтийн тухай ямагт өсөн нэмэгдэх гэрчлэл дээр нэмэгдэх болно” (*The Great Plan of Happiness* [шашны боловсролынхонд хандаж хэлсэн үг, 1993 оны 8-р сарын 10], 3).

Сайн мэдээний зарчмууд дээр тулгуурласан тодорхой удирдамжуудыг хүүхдүүдэд өг.

Шийдвэр гаргахад баримтлах тодорхой удирдамжуудыг эцэг эхчүүд хүүхдүүдэд өгөх ёстойг тайлбарла. Энэхүү хүч чармайлт нь гэр оронд сайн мэдээг заах болон зан төлвийн жишгүүдийг бий болгох явдлыг хамардаг. Далын Ахлагч Жөү Ж.Кристенсен сургахдаа:

*“Ёс суртахууны тодорхой жишгүүд болон удирдамжуудыг бий болгохоос эмээх хэрэггүй. Хэрэгтэй үед үгүй гэж хэлэхэд шийдвэртэй бай. . . . Гэр бүлийн чинь гишүүдийн хувьд, таньд хийж болохгүй зарим зүйл байдгийг [өөрийнхөө хүүхдүүдэд] мэдэгд. Зарим эцэг эхчүүд хүүхдүүдээ нийгмийн дунд нэрд гаргахын төлөө, бэл бэнчингээ харуулах цамаан зан, даруу биш хувцас, хэт оройтох, арван зургаан наснаас өмнө болзоо тавих, хүчирхийллийн кино үзүүлэх зэрэг олон зүйлд бараг л хөл алдан санаа тавьдаг нь хэрэг дээрээ тэдний эрүүл саруул үнэлэлт дүгнэлтийн эсрэг хандсан зүйл юм. Зөв зүйлийн төлөө зогсдог хүүхдүүд болон эцэг эхчүүдийн хувьд зарим үед ганцаардах явдал байж болно. Үдэш орой ганцаараа байж, үдэшлэгт явахгүй, кино үзэхгүй байж болно. Энэ нь дандаа ч хөгжилтэй байдаггүй. Гэвч эцэг эх байна гэдэг бол нэрд гарахын төлөө өрсөлдөөн биш” гэжээ(Conference Report, 1993 оны 10-р сар, 13; *Ensign*, 1993 оны 11-р сар, 11).*

- Гэр бүлдээ зориулж ёс суртахууны тодорхой удирдамжууд бий болгохын тулд эцэг эхчүүд юу хийж болох вэ? (Энэ асуултыг оролцогчид ярилцах үед амьдралынхаа жишээнүүдээс хуваалцахад нь тэднийг урамшуулан дэмж.)

Моронай 7:15–19-ийг оролцогчидтой хамт унш.

- Муугаас сайныг хэрхэн ялгаж мэдэх талаар судрын энэ хэсэг ямар зөвлөгөө өгч байна вэ? Эцэг эхчүүд хүүхдүүдэд зориулж удирдамжууд бий болгоход энэ зөвлөгөөг ямар арга замаар хэрэглэж болох вэ?
- Хүүхэд залуучуудын амьдралын ямар зүйлүүдэд сайн ба мууг шүүн тунгаахад зарим үед тэдэнд тусламж хэрэгтэй байдаг вэ? Зөв шийдвэр гаргахад нь хүүхдүүдэд туслахын тулд Моронай 7:15–19-ийг эцэг эхчүүд ямар хэлбэрээр ашиглаж болох вэ?

Амьдралд нь Ариун Сүнсний үзүүлэх нөлөөг танин мэдэхэд нь хүүхдүүдэд тусал.

Моронай 7:15–19 бол муугаас сайныг ялган танихад бидэнд тусалдаг Христийн Гэрлийн тухай юм. Бид Христийн Гэрлийг дагахаас гадна, “[бидний] хийвэл зохих бүх зүйлийг [бидэнд] үзүүлэх” (2Нифай 32:5) түүнчлэн “бүх зүйлийн үнэнийг мэдэж болох” (Моронай 10:5) Ариун Сүнснээс удирдамж хүлээн авч болно. Хүүхдүүд Ариун Сүнсний өдөөлтүүдийг танин мэдэж, дагаж сурсан үед, тэд шийдвэр гаргах үедээ цаашдын тусалцаа хүлээн авах болно. Хүүхдүүд Ариун Сүнсний бэлэг хүлээн авсны дараа Ариун Сүнснээс байнга нөхөрлөхүйц зохистой байх хүслийг тэдэнд хөгжүүлэхэд эцэг эхчүүд тусалж чадна.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Роберт Д.Хейлс Ариун Сүнсний нөлөөг танихад нь ээж нь түүнд хэрхэн тусалсан тухай ярихдаа:

“Миний баптисм болон гишүүний баталгааны дараа, ээж маань намайг дэргэдээ аваачаад, ‘За чамд ямар санагдав?’ гэж асуув. Надад байсан амар амгалан, тайтгарлын хийгээд аз жаргалын дулаахан мэдрэмжийг би чадах чинээгээрээ л дүрслэв. Надад байсан тэрхүү мэдрэмж бол миний дөнгөж саяхан хүлээж авсан бэлэг, Ариун Сүнсний бэлэг байсныг ээж минь тайлбарлаж билээ. Хэрэв би үүний хувьд зохистой амьдрах юм бол, тэрхүү бэлэг надад үргэлж байх болно гэж ээж минь хэллээ. Энэ бол миний бүх амьдралын туршид надтай хамт байсан заах мөч байлаа” гэжээ (Conference Report, 1999 оны 4-р сар, 42; *Ensign*, 1999 оны 5-р сар, 33).

- Ариун Сүнсний нөлөөг мэдэрч, танин мэдэхэд нь хүүхдүүддээ туслахын тулд эцэг эхчүүд юу хийж болох вэ? (Судрууд судлах, ариун хөгжим сонсох, зарлигуудыг сахих хийгээд үнэн бодолтойгоор залбирахад нь эцэг эхчүүд хүүхдүүдээ урамшуулан дэмжих нь хариултууд байж болно. Тэд бас сүнслэг туршлагаудаа хүүхдүүдтэйгээ хуваалцаж, мөн тэдэнд хайраа илэрхийлж болно.)

Хувиараа судар судлах, залбирал, мацаг барилт зэрэг хүүхдүүдийнхээ шүтлэг бишрэлийн хувийн дадал зуршлыг эцэг эхчүүд урамшуулан дэмжих нь чухлыг онцлон хэл. Гэр бүлийн шүтлэг бишрэлийн үйл ажиллагаанд оролцох нь чухал боловч, ганц энэ нь хангалтгүй юм.

Энгийн шийдвэр гаргах боломжуудыг бага насны хүүхдүүдэд олго.

Шийдвэр гаргах боломжуудыг эцэг эхчүүд бага насны хүүхдүүдэд олгож болно гэдгийг анхааруулан хэл. Тэд ихэвчлэн ердөө хоёр сонголт, тэгэхдээ хоёулаа хүлээн авч болохуйц сонголтыг санал болгоход, энгийн шийдвэрүүдийг гаргаж чадна. Жишээ нь, “Чи өнөөдөр цэнхэр цамцаа өмсөх үү, эсвэл улаан цамцаа өмсөх үү?” эсвэл “Чи унтах хүртлээ түүх сонсох уу эсвэл тоглохоо үргэлжлүүлэх үү?” гэж эцэг эх асууж болно. Эцэг эхчүүд ийм сонголтыг санал болгосон учраас, хүүхдийн шийдвэрийг тэд хүлээж авах ёстой.

- Ийм энгийн шийдвэрүүд хожим нь хүүхдүүдийг өөрсдийн амьдралд илүү том, хэцүү шийдвэрүүд гаргахад нь хүүхдүүдийг бэлтгэхэд хэрхэн тусалж болох вэ?

Зарим шийдвэр мөнхийн үр дагавруудтай байдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.

Хүндэтгэлийн өдрийн арга хэмжээнүүдийг сонгох, найз нараа сонгох, боловсролын төлөвлөгөө хийх, эсвэл ажил албан тушаалын зорилго дэвшүүлэх гэхчлэн хүнд хэцүү шийдвэрүүдийг хүүхдүүд гаргах үед сайн мэдээний үнэнүүд дээр тулгуурласан үнэлэлт дүгнэлт хэрхэн хийдгийг тэд мэддэг байх нь чухал гэдгийг тайлбарла. Тэдний шийдвэрүүд мөнхийн үр дагавруудтай байж болно гэдгийг тэд ойлгох нь зайлшгүй чухал юм. Эдгээр зарчмуудын тухай тэдэнтэй ярилцах цагийг эцэг эхчүүд хүүхдүүдийн амьдралын эхэн үеэс эхлэн гаргах ёстой.

- Эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ зөвлөлдөхөд тэднийг удирдаж болох зарим арга зам юу вэ? (Эцэг эхчүүд өөрсдийн туршлагыг хүүхдүүдтэйгээ хуваалцах, Их Эзэний зарлигуудыг хүүхдүүдэд сануулах, түүнчлэн хүүхдүүд нь хэцүү сонголтуудын мөнхийн үр дагавруудыг хүүхдүүд нь авч үзэхэд тэдэнд туслах нь хариултуудад байж болно.)

- Хүүхэд зөв биш шийдвэр гаргасан үед эцэг буюу эх хөндлөнгөөс оролцохыг шаадсан ямар нөхцөл байдлууд байж болох вэ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Рассел Баллардын дараах зөвлөгөөг уншихыг нэг оролцогчоос хүс (Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага, хуудас 66):

“Эцэг эхчүүд буруу сонголт хийгдсэнийг харсан үедээ хөндлөнгөөс оролцох нь тэдний үүрэг мөн. Энэ нь эцэг эхчүүд хүүхдүүдээсээ сонгох эрхийн үнэт бэлгийг нь булаан авах ёстой гэсэн үг биш. Сонгох эрх бол Бурханаас соёрхсон бэлэг учраас тэд юу хийх, биеэ хэрхэн авч явах хийгээд юунд итгэхийг сонгох нь ямагт тэдний өөрсдийнх нь хэрэг байх болно. Гэвч бид эцэг эхчүүдийн хувьд, хүүхдүүд маань зохих зан авирыг, мөн хэрэв тэд буруу замаар орвол тэдэнд тохиолдож болох үр дагавруудыг ойлгодог байхад анхаарах хэрэгтэй. Хууль бус хянан цагдалт мэтийн зүйл гэр оронд байдаггүйг санагтун. Кино, сэтгүүлүүд, телевиз, видео, интернет болон мэдээллийн бусад хэрэгслүүд энд зочид лугаа адил бөгөөд тэдгээр нь гагцхүү гэр бүлд зохих ёсоор таалагдаж байвал сайн хэрэг. Гэр орноо амар амгалан хийгээд зөв шударга байдлын газар болгогтун. Хилэнцэт нөлөө таны сүнслэг байдлын онцгой орчныг бохирдуулах боломж бүү олго. Нинжин сэтгэлтэй, ухаалаг хэрсүү, үг хэлээрээ, бие биендээ хандах харьцаа хандлагадаа дотроо бодолтой бай. Тэгвэл сайн мэдээний жишгүүд дээр тулгуурласан гэр бүлийн зорилгууд сайн шийдвэр гаргах явдлыг амар хялбар болгоно” (Conference Report, 1999 оны 4-р сар, 114; *Ensign*, 1999 оны 5-р сар, 87).

Эцэг эхчүүд хүүхдүүдэд ухаалаг бус шийдвэрийн үр дагавруудаас сургамж авах боломжийг олгох ёстой.

Эцэг эхчүүд хэдийгээр зарим үед зөв шийдвэр гаргахад нь хүүхдүүддээ туслахын тулд хөндлөнгөөс оролцох хэрэгтэй ч гэсэн, хүүхдүүдийнхээ ухаалаг бус шийдвэрүүдийн үр дагавруудаас сэргийлэхэд хөндлөнгөөс оролцох ёсгүй.

- Эцэг эхчүүд хүүхдүүдээ тэдний шийдвэрүүдийн үр дагавруудаас хамгаалахад ямар үр дүн гарч болох вэ? Тэдний шийдвэрүүдийн зүй ёсны үр дүнг хүүхдүүдэд зөвшөөрснөөс ямар сайн үр дүн гарч болох вэ? (Амьдралынхаа жишээнүүдээс хуваалцахад нь оролцогчдыг урамшуулан дэмж. Дараа нь доорх мэдэгдлүүдийг унш.)

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г.Скотт хэлэхдээ: “Эцэг эхчүүд ээ, зарлигуудыг зөрчихийн тулд хүүхдийнхээ зориудаар гаргасан шийдвэрүүдийн зүй ёсны үр дүнг зөөлрүүлэх буюу ингэхийн тулд зориудаар хөндлөнгөөс оролцож бүү алдаа гарга. Ийм үйлдэл нь хуурмаг зарчмуудыг хүчтэй болгож, илүү ноцтой нүгэлд үүд хаалгыг нээн, наманчлалын магадлалыг багасгадаг” гэжээ (Conference Report, 1993 оны 4-р сар, 43; *Ensign*, 1993 оны 5-р сар, 34).

“Хүүхдүүдийнхээ гаргаж болох алдаанаас сургамж авах боломжийг тэдэнд олгоно гэдэг цочирдмоор хэдий ч, Их Эзэний замыг болон гэр бүлийнхээ үнэт зүйлсийг сонгох тэдний хүсэл, сонголт энэ хүрээн дотор хийгдэж байгаа тохиолдолд, эдгээр үнэт зүйлсийг бид тэдэнд хүчээр тулгах гэж оролдохоос хавьгүй илүү байдаг. Их Эзэний хайр хийгээд хүлээн

зөвшөөрөлтийн зам Сатаны хүчлэлт хийгээд албадлагын замаас, ялангуяа өсвөр насныхныг хүмүүжүүлэхэд илүү дээр юм” хэмээн Ахлагч Роберт Д.Хейлс сургамжилжээ (Conference Report, 1999 оны, 4-р сар 43; буюу *Ensign*, 1999 оны 5-р сар, 34).

Эцэг эхчүүд буруу замд орж байгаа хүүхдүүдэд унтаршгүй хайраа үзүүлэх ёстой.

Бүр эцэг эхчүүдийн шилдэг хүч чармайлтын дараа ч гэсэн, зарим хүүхдүүд өөрсдийнхөө хувьд бас бусдын хувьд их харуусалд хүргэх алдаа гаргаж болно. Эцэг эхчүүд буруу замаар орж байгаа хүүхдүүдийг хайрлахаа хэзээ ч болих ёсгүй. Ахлагч Ричард Г.Скотт хэлэхдээ:

“Та нарын зарим нь бүхэлдээ өөр замыг сонгон, та нарт хариулдаггүй хүүхдүүдтэй байгаа. Энэхүү туршлага Тэнгэр дэх Эцэгт ч дахин давтан тохиож байлаа. Түүний хүүхдүүдийн зарим нь Түүний сонгох эрхийн бэлгийг Түүний зөвлөгөөний эсрэг сонголт хийхэд ашигласан хэдий ч, Тэрээр тэднийг үргэлжлүүлэн хайрласаар байдаг. Гэвч, Тэрээр тэдний ухаалаг бус сонголтуудын төлөө Өөрийгөө хэзээ ч буруутгаж байгаагүйд би итгэлтэй байна” (Conference Report, 1993 оны 4-р сар, 43; *Ensign*, 1993 оны 5-р сар, 34).

Ахлагч Ховард В.Хантер Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад үйлчилж байхдаа, чадах бүхнээ хийсэн боловч хүүхдийнхээ алдаануудаас болж, сэтгэлийн зовлон амссан эцэг эхчүүдэд дараах зөвлөгөөг өгчээ:

“Амжилттай эцэг эх бол хүүхдээ хайрладаг, золиослол хийдэг, анхаарал халамж тавьдаг, заадаг хүүхдийнхээ хэрэгцээг хангадаг эцэг эх байдаг. Хэрэв та энэ бүгдийг хийсээр байхад хүүхэд чинь адармаатай, яршиг уддаг, эсвэл дэлхийн зан авиртай байлаа ч гэсэн, та амжилттай эцэг эх байх л ёстой. Магадгүй ямар ч нөхцөл байдалд, ямар ч эцэг эхтэй байсан дэлхийд ирэхдээ төвөг бэрхшээл удах учиртай хүүхдүүд байдаг бололтой. Үүнчлэн, бараг л ямар ч эцэг эхтэй байсан, амьдралыг адислах учиртай, баяр хөөр авчрах учиртай өөр хүүхдүүд байдаг ажээ” (Conference Report, 1983 оны 10-р сар, 94; *Ensign*, 1983 оны 11-р сар, 65).

Хичээлд өөрийнхөө авчирсан хайргыг нэг оролцогчид өг (“Бэлтгэл,” зүйл 4-ийг үз). Хайргыг нүднийхээ яг өмнө байрлуулахыг оролцогчоос хүс. Тэгээд тэрээр харж байгаа зүйлээ дүрслэхийг уг оролцогчоос хүс. Ахлагч Ричард Г.Скотт Далд үйлчилж байхдаа хуваалцсан дараах адил төстэй зүйлийг унш:

“Би жижиг хайрга авч үүнийг нүднийхээ яг өмнө байрлуулахад энэ нь том гэгчийн үхэр чулуу мэт санагдаж билээ. Энэ бол миний харж чадсан бүх зүйл. Хайртай хэн нэгэн маань бидний амьдралын сэрүүн мөч болгонд асуудал учруулдаг шиг энэ нь тийм, бүхнийг цочирдуулам байдаг. Таны бодитойгоор хийж чадах зүйлүүд хийгдсэн үед, уг асуудлыг Их Эзэний мутарт даатган үлдээж, тэгээд цаашид санаа зовох хэрэггүй. Та үүнээс илүү зүйл хийж чадаагүй учраас гэмтэй хэмээн бүү бод. Дэмий санаа зовж, эрч хүчээ бүү үр. Таны мэлмийг таглаж байгаа хайргыг Их Эзэн авч, та мөнхийн дэвшилдээ тулгарах сорилт бэрхшээлүүдийн дунд үүнийг хаях болно. Тэгээд энэ нь хэтийн төлөвт харагдах болно. Хэсэг хугацааны дараа, танд санаа төрж, цаашид хэрхэн туслахаа мэдэх болно. Та илүү их амар амгалан хийгээд аз жаргалыг олох болно, бусдыг үл тоомсорлохоо больж, тэрхүү мөнхийн хэтийн төлвийн улмаас илүү агуу туслалцаа үзүүлэх

боломжтой болно” (Conference Report, 1988 оны 4-р сар, 70; *Ensign*, 1988 оны 5-р сар, 60).

- Эцэг эхчүүд буруу замд орсон хүү буюу охиндоо ямар арга замаар байнгын хайраа үзүүлж чадах вэ? Тэд хүү буюу охиныхоо үйлдлүүдийг хайхрахгүйгээр ийм хайрыг хэрхэн харуулж чадах вэ?

Лук 15:11–32-ыг оролцогчидтой хамт унш. Энэ хэсгийг үрэлгэн хүүгийн тухай сургаалт зүйрлэл хэмээн олонтаа нэрлэдгийг тайлбарла. Гэвч, энэ нь бас хайрлагч эцгийн тухай сургаалт зүйрлэл байж болно.

- Эцэг эхийн хайр адармаатай хүүхдүүдэд хэрхэн нөлөөлдөг тухай бид энэ сургаалт зүйрлэлээс юу сурч болох вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр Зөвлөхөөр үйлчилж байхдаа:

“Хүмүүний олон үеийнхний түүхийн туршид, эсэргүүцэгч хүүхдүүдийн үйлдлүүд уй гашуу хийгээд сэтгэлийн зовлонгоор хүндэрч байсан хэдий ч, тэр ч байтугай эсэргүүцэл тохиолдоход ч, гэр бүлийн амьдралын хүчирхэг хэлхээ холбоо эсэргүүцэгч нэгнийг хүрээлэн түүнд хүрсээр ирсэн юм.

“Лукийн арвантавдугаар бүлэгт цэдэглэгдсэнчлэн, Их Эзэний хүүрнэсэн тэрхүү түүхээс илүү эрхэм сайхан түүхийг бүх утга зохиолд би мэдэхгүй. Энэ бол тэрээр юу ч үлдэхгүй болтол нь үрэн таран хийсэн, түүний өв хөрөнгийг шаардсан болчимгүй, шунахай хүүгийн тухай түүх юм. Тэр гэмшин эцэгтээ эргэж ирэхэд, эцэг нь түүнийг холоос хараад, түүн рүү гүйж очин, түүнийг тэвэрч аван, түүнийг үнсчээ” хэмээн сургамжилжээ (Conference Report, 1991 оны 4-р сар, 95; *Ensign*, 1991 оны 5-р сар, 72).

Дүгнэлт

Шийдвэр гаргах үед нь хүүхдүүдийг удирдаж, дараа нь өөрсдийнхөө үйлдлүүдийн үр дагавруудаас сургамж авах боломжийг тэдэнд олгохын ач холбогдлыг онцлон хэл. Тэд хүүхдүүдээ хайрлаж, тэдэнтэй ажиллахаа үргэлжлүүлэх юм бол Их Эзэн эцэг эхчүүдийг адислах болно гэдгийг оролцогчдод сануул. Дараа нь Бишоп Роберт Д.Хейлс Тэргүүлэх Бишопоор үйлчилж байхдаа хийсэн дараах мэдэгдлийг унш:

“Мэдээж хэрэг эцэг эхчүүд эцэг эхийн үүргээ биелүүлэх явцад алдаа гаргах болно, гэвч даруу байдал, итгэл, залбирал, суралцахаар дамжуулан хүн бүр илүү сайн арга замыг сурч, ингэснээрээ эдүгээ гэр бүлийнхээ гишүүдийн амьдралыг адисалж, ирэх үеийнхэнд зөв уламжлалуудыг зааж чадна” (Conference Report, 1993 оны 10-р сар, 10–11; *Ensign*, 1993 оны 11-р сар, 10).

Сүнсээр өдөөгдсөний дагуу, энэ хичээлийн үеэр ярилцсан зарчмуудын тухай гэрчил.

Гэр Бүл ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын хуудас 64–67-г үз. Оролцогчдыг (1) “Хэрэгжүүлэхэд Зориулсан Санаанууд” дахь зөвлөмжүүдээс доод тал нь нэгийг дагаж, (2) Ахлагч М.Рассел Баллардын “Унтаршгүй Гал Мэт” өгүүллийг уншиж энэ хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудыг нэгтгэн дүгнэхэд нь урамшуулан дэмж. Гэрлэсэн хосууд судлах гарын авлага дахь өгүүллүүдийг хамтдаа уншиж, ярилцсанаар ашиг тусыг олж болохыг онцлон хэл.

ГЭР БҮЛИЙН ЗАЛБИРАЛ, ГЭР БҮЛЭЭРЭЭ СУДАР СУДЛАХ БОЛОН ГЭР БҮЛИЙН ҮДЭШ

Хичээл

16

Зорилго	Гэр бүлүүдийг гэр бүлийн залбирал, гэр бүлээрээ судар судлах хийгээд гэр бүлийн үдшийг тогтмол хийж байхад нь, түүнчлэн эдгээр үйл ажиллагаанууд тус бүрд сайн мэдээг заахад нь урамшуулан дэмжих.
Бэлтгэл	<ol style="list-style-type: none">1. “Багшийн Хувьд Таны Үүрэг Хариуцлагууд” дахь (энэ гарын авлагын хуудас х–хiii) зарчмуудыг хэрэглэж болох арга замуудыг бод.2. Хичээл дэх сургаалууд болон зарчмуудыг тоймлон харуулсан тод гарчгуудыг унш. Бэлтгэлийнхээ нэг хэсэг болгон эдгээр сургаалууд болон зарчмуудыг долоо хоногийн турш эргэцүүлэн бодоод, оролцогчдын хэрэгцээнд тохируулан юуг онцлон хэлэх ёстойг шийдэхэд Сүнсний удирдамжийг эрэлхийл.3. Хэрэв дараах материалуд байдаг бол тэдгээрийг бүгдийг нь буюу заримыг нь ангид авчир. Та нар гэр бүлийн үдшийн тухай ярилцахдаа эдгээрийг үзүүлэхээр бэлтгэ.<ol style="list-style-type: none">а. Судрууд.б. <i>Сайн Мэдээний Зарчмууд</i> (31110).в. Сүмийн сэтгүүлүүд.г. <i>Бидний өв: Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Товч Түүх</i> (35448).д. Мелкизедек Санваартнуудын болон Халамжийн Нийгэмлэгийн гарын авлагууд.ё. <i>Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө</i> (34285).ж. <i>Мормоны Номын Түүхүүд</i> (35666) мэтийн Сүмээс нийтлүүлсэн судрын түүхийн номнууд.з. <i>Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга</i> (34730).4. Хэрэв та нар хуудас 97 дахь дэх нэгтгэн дүгнэх дасгалыг ашиглах бол, оролцогч бүрд хуудас цаас, үзэг буюу харандаа авчир.

Энэ хичээлийг заах зөвлөмж

Гэр бүлийн залбирал, судар судлах болон гэр бүлийн үдэш нь Хожмын Үеийн Гэгээнтэн гэр бүл бүрийн эн тэргүүнд тавих зүйл байх ёстой.

1999 оны хоёрдугаар сард Тэргүүн Зөвлөл дэлхий даяарх Сүмийн гишүүдэд захидал илгээснийг тайлбарла. Уг захидал дараах зааврыг агуулсан ажээ:

“Гэр бүлийн залбирал, гэр бүлийн үдэш, сайн мэдээг судлах болон заах, түүнчлэн гэр бүлийн ашиг тустай үйл ажиллагаануудад тэргүүлэх ач холбогдол өгч байхыг бид эцэг эхчүүд, хүүхдүүдэд зөвлөж байна. Зохистой, тохиромжтой бусад шаардлагууд буюу үйл ажиллагаанууд байж болох хэдий ч, тэдгээр нь гагцхүү эцэг эхчүүд хийгээд гэр бүлүүд зохих ёсоор гүйцэтгэж

болох бурханлигаар томилогдсон үүргүүдийг орлох ёсгүй” (Тэргүүн Зөвлөлийн захидал, 1999 оны 2-р сарын 11).

- Энэ захидал өнөөдөр яагаад онцгой ач холбогдолтой вэ?

Гэр бүлийн залбирал, гэр бүлээрээ судар судлах болон долоо хоног тутмын гэр бүлийн үдшүүдийг хийж байхын тулд эцэг эхчүүд юу хийж болохыг энэ хичээлээр ярилцдагийг тайлбарла.

Гэр бүлүүд хамтдаа залбирах үедээ агуу адислалууд хүлээн авдаг.

3 Нифай 18:21-ийг оролцогчидтой хамт унш. Дараа нь Сүмийн 15 дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн дараах зөвлөгөөг хуваалц:

“Энэ Сүм дэх гэр бүл бүр хамтдаа залбирдаг. Эдүгээ, хувиараа залбирал хийх нь чухал ч гэсэн, гэр бүлээрээ залбирах нь гайхамшигтай сайхан зүйл мөн. Тэнгэр дэх өөрсдийнхөө Эцэгт итгэлээр залбирагтун. Их Эзэн Есүс Христийн нэрээр залбирагтун. Өөрсдийнхөө залбирлуудын төлөө талархал илэрхийлж, хүүхдүүдээрээ гэр бүлийн залбирлыг ээлжээр хийлгэхээс өөр илүү чухал зүйлийг та нар хүүхдүүдийнхээ төлөө хийж чадахгүй. Хэрэв тэд үүнийг бага байхдаа хийх юм бол, тэд зүрх сэтгэлдээ талархлын сүнстэйгээр өсөх болно” (“Inspirational Thoughts,” *Ensign*, 1997 оны 8-р сар, 5).

- Гэр бүлийн өдөр тутмын залбирлыг хэвшил болгохын тулд гэр бүлүүд юу хийж болох вэ? Өдөр тутам гэр бүлийн залбирлыг хийхэд та нар ямар бэрхшээлтэй тулгардаг вэ, түүнчлэн тэдгээрийг шийдвэрлэхийн тулд та нар хэрхэн ажилласан бэ?
- Гэр бүлийн залбирлыг өөрсдийнхөө хувьд утга учиртай болгохын тулд гэр бүлүүд юу хийж болох вэ? (Оролцогчдын хариултуудаас гадна, дараах зөвлөмжүүдийг бүгдийг нь буюу заримыг нь хуваалц.)
 - а. Гэр бүл Тэнгэрлэг Эцэгт тусгайлан талархах ёстой ямар нэг зүйл байгаа эсэхийг, түүнчлэн залбиралдаа дурдах ёстой ямар нэгэн санаа тавих зүйл байгаа эсэхийг залбирлын өмнө асуух цагийг эцэг эхчүүд гаргах хэрэгтэй.
 - б. Гэр бүлийн залбирал хэлэх боломжийг хүүхдүүдэд тогтмол олгож байхад эцэг эхчүүд анхаарах хэрэгтэй.
 - в. Сүмийн удирдагчид, номлогчид, түүнчлэн тусгай адислалууд хэрэгтэй байгаа гэр бүлийн гишүүдийн төлөө залбирахыг гэр бүл санаж болно.
 - г. Эцэг эхчүүд өөрсдийн залбирлыг заах цаг болгон ашиглаж болно. Жишээ нь, тэдний талархал илэрхийлэлт хүүхдүүдэд нь мөн тийм мэд-рэмжүүдийг хөгжүүлэхэд түлхэц өгч чадна.
 - д. Тэнгэрлэг Эцэг болон дэлхийн эцэг эхчүүд нь тэднийг хайрладгийг мэд-рэхэд нь хүүхдүүдэд туслахын тулд эцэг эхчүүд өөрсдийн залбиралд хүүхэд нэг бүрийнхээ нэрийг дурдаж болно.
- Гэр бүлийн залбирлын улмаас та болон таны гэр бүл ямар адислалууд хүлээн авсан бэ?

Гэр бүлээрээ судар судлах нь гэр бүлүүдийг Бурхантай илүү ойр болоход тусалдаг.

Дараах өгүүлбэрүүдийг самбар дээр бичих буюу эсвэл тэдгээрийг чанга унш:

Өсөн нэмэгдсэн хүндэтгэл бишрэл
Өсөн нэмэгдсэн хүндлэл хийгээд бусдын сэтгэлийг ойлгохуй
Маргаан зөрчил бага байх
Илүү их хайр, мэргэн ухаанаар хүүхдэд зөвлөх чадвар
Эцэг эхчүүдийн зөвлөгөөнд илүү ихээр хариулах
Өсөн нэмэгдсэн зөв шударга байдал
Элбэг арвин итгэл, найдвар хийгээд энэрэл
Амар амгалан, баяр хөөр хийгээд аз жаргал

Чангаар хариулалгүйгээр дараах асуултыг тунгаан бодохыг оролцогчдоос хүс:

- Эдгээр адислалуудыг гэр орондоо илүү элбэг арвинаар авчрахын тулд та юу хийж болох вэ?

Бид судруудыг, ялангуяа Мормоны Номыг судалснаар эдгээр адислалууд бидний гэр оронд элбэг арвинаар ирж болохыг Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч асан Марион Г.Ромни гэрчилснийг тайлбарла:

“Хэрэв бидний гэр орнуудад эцэг эхчүүд Мормоны Номноос өөрсдөө болон хүүхдүүдтэйгээ хамт залбирч, тогтмол унших юм бол, энэхүү агуу номны сүнс бидний гэр орнууд болоод тэнд амьдардаг бүгдэд нэвтрэн ирэх болно гэж би яриангүй боддог. Хүндэтгэл бишрэлийн сүнс өсөн нэмэгдэх болно; харилцан хүндлэл хийгээд бие биенийхээ сэтгэлийг ойлгох нь өсөн нэмэгдэх болно. Маргаан зөрчлийн сүнс зайлан одох болно. Эцэг эхчүүд илүү агуу хайр хийгээд мэргэн ухаанаар хүүхдүүддээ зөвлөх болно. Хүүхдүүд эцэг эхчүүдийнхээ зөвлөгөөнд илүү хариуламтгай, илүү захирагдамтгай болно. Зөв шударга байдал өсөн нэмэгдэх болно. Итгэл, найдвар хийгээд энэрэл—Христийн цэвэр хайр—бидний гэр оронд хийгээд бидний амьдралд элбэг дэлбэг байж, тэдний оршихуйд амар амгалан, баяр хөөр хийгээд аз жаргалыг авчрах болно” (Conference Report, 1980 оны 4-р сар, 90; *Ensign*, 1980 оны 5-р сар, 67).

Сүмийн 13 дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон Ерөнхийлөгч Ромнийн амлалтуудыг дурдан хэлэхдээ: “Эдгээр амлалтууд—гэр орон дахь өсөн нэмэгдсэн хайр хийгээд эв нийц, эцэг эх хийгээд хүүхдийн хоорондох илүү агуу хүндлэл, өсөн нэмэгдсэн сүнслэг байдал хийгээд зөв шударга ёс нь—үхмэл амлалтууд биш, харин Мормоны Ном Бурханд илүү ойр байхад бидэнд туслах болно гэж Бошиглогч Иосеф Смитийн хэлсэн чухам гэр зүйл мөн” гэжээ (Conference Report, 1986 оны 4-р сар, 6; *Ensign*, 1986 оны 11-р сар, 7).

Гэр бүлээрээ судар судалснаас гэр бүлүүдэд нь ирдэг адислалуудын тухай ярихад оролцогчдыг урь.

- Гэр бүлээрээ судар судлахыг амжилттай болгохын тулд та нар юу хийдэг вэ? Та нарт ямар бэрхшээл тулгарсан, мөн тэдгээрийг шийдвэрлэхийн тулд та нар хэрхэн ажилласан бэ? (Оролцогчдын хариултуудаас гадна, дараах зөвлөмжүүдийг бүгдийг нь буоу заримыг нь хуваалц.)
 - а. Гэр бүлээрээ судруудыг өдөр бүр судлах цаг бий болгохын тулд хамтдаа ажилла. Энэ бол гэр бүлээрээ судар судлахад хамгийн хэцүү хэсэг нь юм. Гэвч, тэдний нөхцөл байдалд юу хамгийн сайн тохирохыг тодорхойлох үед гэр бүлүүд Сүнсний удирдамжийг эрж болно.

- б. Өдөр бүр унших шүлгийн, бүлгийн эсвэл хуудасны тоо буюу эсвэл тодорхой хугацаа тогтоож уншихыг бод.
- в. Хэрэв боломжтой бол, гэр бүлийн гишүүн бүр иж бүрдэл судруудтай байхыг бод. Тэр ч байтугай, уншиж чаддаггүй хүүхдүүд өөрсдийн судруудтай байхаас ашиг тус олох болно. Баптисмынх нь үед, төрсөн өдрөөр нь, эсвэл бусад тусгай үйл явдлуудыг тохиолдуулан эцэг эх нь хүүхдүүдэд судрууд өгч болно. Эсвэл хүүхдүүд өөрсдөдөө судрууд худалдан авахын тулд ажил хийж мөнгө олж болно.
- г. Хэрэгтэй бол бага насны хүүхдүүдэд туслан, ээлжээр уншдаг бай. Нэг хэсгийг уншсаны дараа, уншсан зүйлийг нэгтгэн дүгнэхдээ бага насны хүүхдүүд үүнийг ойлгох арга хэлбэрийг анхаар.
- д. Судрын түүхүүдийн тухай зургуудыг хүүхдүүдээрээ зуруул. Жишээ нь, амьдралын модны тухай Лихайн үзэгдлийг дүрсэлсэн ханын зургийг гэр бүлээрээ хийж болно.
- е. Дуртай шүлгүүдээ хамтдаа цээжил.
- ё. Улаан Өндөгний Баяр, Христийн Мэндэлсний Баяр, баптисм, санваарт томилогдох буюу ариун сүмийн онцгойлон адислалт зэрэг тусгай үйл явдлуудыг тохиолдуулан судруудыг унш.
- ж. Сайн мэдээний тухайлан сонгосон сэдвүүдийг хамтдаа судал.
- з. Судар судалсантай холбоотойгоор гарсан асуултууд, зорилгууд буюу сэтгэгдлүүдийг тэмдэглэх гэр бүлийн тэмдэглэлийн дэвтэр хөтөл.

Судар судлахын тулд гэр бүлээрээ цуглах нь хэцүү байвал, өөрсдийнх нь хүч чармайлтууд өөрсдийнх нь төсөөлснөөс илүү урт удаан хугацаанд үргэлжлэх үр дагавартай байж болохыг эцэг эхчүүд санах ёстойг анхааруулан хэл. Хүүхдийн Хэсгийн Ерөнхий Ерөнхийлөгчийн зөвлөлд хоёрдугаар зөвлөхөөр үйлчилж асан Сюзан Л.Уорнер Эгч хэлэхдээ:

“Манай гэр бүлд бид өглөө эрт судар судлахыг чармайдаг. Гэвч нэг хүү маань дургүйцэж, тэгээд түүнийг орноос нь босгохын тулд аргадах гэж бидэнд олонтаа бэрхшээл учирдаг байлаа. Эцэст нь тэр хүрч ирээд, шууд л ширээн дээр толгойгоо тавиад хэвтээд өгөх нь олонтаа байлаа. Олон жилийн дараа тэрээр номлолд үйлчилж байхдаа, гэртээ ирүүлсэн нэг захидалд: ‘Надад судруудыг зааж байсанд тань баярлалаа. Би унтаж байгаа мэтээр аашилдаг байсан тэр бүх цагуудад би нүдээ аниад үнэхээр сонсдог байсан юм шүү гэдгийг би таныг мэдээсэй гэж хүснэ’ ” хэмээн бичсэн юм гэжээ (Conference Report, 1996 оны 4-р сар, 109; *Ensign*, 1996 оны 5-р сар, 79).

Гэр бүлийн үдэш нь өөрсдийгөө дэлхийн нөлөөний эсрэг хүчирхэг болгоход гэр бүлүүдэд тусалдаг.

1915 онд Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит болон Тэргүүн Зөвлөл дэх түүний зөвлөхүүд “Гэр Бүлийн Үдшийг” тогтмол явуулж эхлэхийг эцэг эхчүүдэд зааварлажээ. Үүний дагуу сайн мэдээний зарчмуудыг эцэг эхчүүд гэр бүлдээ заах цаг гаргах ёстой байлаа. “Хэрэв Гэгээнтнүүд энэ зөвлөгөөг дуулгавартай дагах юм бол, үр дүн нь агуу адислалууд байх болно гэдгийг бид амлаж байна. Гэр доторх хайр, эцэг эхдээ дуулгавартай байх байдал өсөх болно. Израилын залуучуудын зүрх сэтгэлд итгэл хөгжиж, тийнхүү өөрсдөд нь саад бэрхшээл учруулдаг хилэнцэт нөлөө хийгээд уруу таталтуудыг сөрөн зогсох хүчийг тэд олж авах болно” хэмээн Тэргүүн Зөвлөл бичжээ (Жеймс Р.Кларк түүвэрлэсэн, *Messages of the First Presidency of The Church of Jesus Christ of Latter-day Saints*, 6 боть. [1965–75], 4:339).

Ерөнхийлөгч Смитийн зөвлөгөөг өөрийнх нь эцэг эх хэрхэн дагадаг байсан тухай Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли өгүүлэхдээ:

“1915 онд Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит гэр бүлийн үдэш хийж байхыг Сүмийн хүмүүсээс хүссэн юм. Бид үүнийг хийх болно гэж аавыг хэлэхэд, бид ээжийн төгөлдөр хуур байдаг байсан зочны өрөөг галлан, Сүмийн Ерөнхийлөгчийн хүссэн зүйлийг хийж билээ.

“Хүүхдүүд бид ч хөөрхийлөлтэй тоглогчид байсан даа. Бид тоглохдоо бүх зүйлийг хамтдаа хийж чаддаг байв, харин бидний нэг нь бусдынхаа өмнө ганцаараа дуулах гэж хичээх үед, гал тогооны пийшин дээр үлдээхийн тулд мөхөөлдөс гуйхтай адилархуу юм болдог байв. Эхлээд бид инээлдэж, нэг нэгнийхээ тоглолтыг донжтойхон шүүмжилдэг байлаа. Гэвч үүнийг эцэг эх маань эсэргүүцдэг байв. Бид хамтдаа дуулдаг байлаа. Бид хамтдаа залбирдаг байв. Ээж маань Библийн болон Мормоны Номны түүхүүдийг уншихад бид нам чимээгүй сонсдог байлаа. Аав маань өөрийнхөө дурсамжуудаас олон түүх ярьдаг байв. . . .

“Манай хуучин гэрийн зочны өрөөнд болдог байсан эдгээр энгийн жижигхэн цуглаануудаас ямар нэгэн дүрслэх аргагүй, гайхамшигтай зүйл ирдэг байлаа. Эцэг эхээ хайрлах бидний хайр бэхэжсэн юм. Ах эгч дүүсээ хайрлах бидний хайр өргөжин тэлсэн юм. Их Эзэнийг хайрлах бидний хайр өсөн нэмэгдсэн юм. Энгийн нинжин сэтгэлийг үнэлэх бидний үнэлгээ бидний зүрх сэтгэлд өссөн юм. Бидний эцэг эх Сүмийн Ерөнхийлөгчийн зөвлөгөөг дагасны улмаас эдгээр гайхамшигтай зүйлүүд бидэнд ирсэн юм. Үүнээс би ямар нэгэн аугаа гайхамшигтай зүйлийг мэдэж авсан билээ” (*Teachings of Gordon B. Hinckley* [1997], 211–12).

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитээс хойш Сүмийн Ерөнхийлөгч бүр гэр бүлийн үдшийн ач холбогдлын талаар онцлон хэлсээр ирсэн юм. Өнөөдөр Тэргүүн Зөвлөл гэр бүлийн үдшийг Даваа гараг бүрийн орой хийж байхыг гэр бүлүүдэд зөвлөж байна.

Гэр бүлийн үдэш нь гэр бүлийн залбирал болон эцэг эх буюу хүүхдүүдийн нэг нь зааж болох хичээлийг үргэлж өөртөө багтаах ёстойг анхааруулан хэл. Хичээлд бэлтгэх болон заахад нь эцэг эхчүүд бага насны хүүхдүүдэд тусалж болно.

Гэр бүлийн амжилттай үдшүүдийг явуулахад гэр бүлүүдэд тусалж чадах материалуудыг Сүм хэвлэн гаргадгийг тайлбарла. Ангид авчирсан Сүмээс хэвлэн гаргасан материалуудыг үзүүл.

- Залбирал болон хичээлээс гадна, өөр ямар үйл ажиллагаануудыг гэр бүлүүд гэр бүлийн үдшүүддээ оруулж болох вэ? (Тоглоомууд тоглох, судар унших, сүмийн дуулал буюу дуу дуулах, гэр бүлийн зөвлөгөөн хийх тэрчлэн хоолоор дайлах зэрэг нь хариултууд байж болно.)
- Эцэг эхчүүд гэр бүлийнхээ хэрэгцээг шийдвэрлэхэд туслахын тулд гэр бүлийн үдшийг хэрхэн ашиглаж болох вэ? (Оролцогчдын санаануудыг асуухаас гадна, дараах жишээг хуваалц.)

Нэг аав хүүхдүүдтэйгээ нэг бүрчлэн ярилцах замаар гэр бүлийн үдшийн хичээлүүдийг заадаг байжээ. Тэрээр хүүхдүүдтэйгээ ярилцахдаа, “Сургууль дээр эрэгтэй хүүхдүүд охидын талаар юу гэж ярьдаг вэ?” эсвэл “Хэн нэг нь хууль бус мансууруулах бодисуудын талаар ярьж байх юм уу?” гэх

мэтийн, санаа тавих ёстой ямар нэг өвөрмөц сэдвээр олонтаа асуудаг байв. Хүүхдүүдийн өгдөг хариултууд тэд юуны тухай мэдэж, ярилцах хэрэгтэйг мэдэхэд түүнд тусалдаг байжээ. Гэр болон эхнэр нь тэгээд хамтдаа сууж эдгээр хэрэгцээнүүд дээр тулгуурласан хичээлүүдийг төлөвлөдөг байлаа. Хүүхдүүд өөрсдийн санаануудыг хуваалцаж, бодит амьдрал дээр тулгардаг нөхцөл байдлуудад бэлтгэгдэхдээ дуртай байдаг байв.

- Гэр бүлийн гишүүн бүрийг гэр бүлийн үдэшт оролцоход нь урамшуулахын тулд эцэг эхчүүд юу хийж болох вэ?
- Гэр бүлийн үдшүүдийг явуулсны үр дүнд ямар адислалууд танай гэр бүлд ирсэн бэ?

Дүгнэлт

Гэр бүлийн өдөр тутмын залбирал болон гэр бүлээрээ судар судлах түүнчлэн долоо хоног тутмын гэр бүлийн үдэш нь гэр бүлийн харилцааг бэхжүүлж, гэр бүлийн гишүүдийн гэрчлэлийг хүчирхэгжүүлж, амьдралын бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд гэр бүлийн гишүүдийг бэлтгэдгийг онцлон хэл.

Сүнсээр өдөөгдсөний дагуу гэр бүлээ хайрладаг хайраа илэрхийлж, энэ хичээлээр нийт цуврал хичээлээр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Гэр Бүл ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын хуудас 68–72-ыг үз. Оролцогчдыг (1) “Хэрэгжүүлэхэд Зориулсан Санаанууд” дахь зөвлөмжүүдээс доод тал нь нэгийг дагаж, (2) Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн “Гэр Бүлийн Залбирлын Адислалууд,” Ахлагч Л.Тоом Перрийн “Би Заалгасан Учраас” өгүүлүүдийг уншиж энэ хичээл дэх сургаалууд хийгээд зарчмуудыг нэгтгэн дүгнэхэд нь урамшуулан дэмж. Гэрлэсэн хосууд судлах гарын авлага дахь өгүүлүүдийг хамтдаа уншиж, ярилцсанаар ашиг тус олж болохыг онцлон хэл.

Нэмэлт Эх Сурвалж Материал

Амралтын ашиг тустай үйл ажиллагаануудад гэр бүлээрээ оролцох нь

Гэр бүлийн залбирал, гэр бүлээрээ судар судлах болон гэр бүлийн үдшээс гадна, амралтын ашиг тустай үйл ажиллагаанууд нь хайр хийгээд эв нэгдлийн бат бөх хэлхээ холбоогоо хөгжүүлэхэд нь гэр бүлүүдэд тусалж чаддагийг тайлбарла. Ийм үйл ажиллагаануудад гэр бүлээрээ хамт оролцож болох цаг хугацааг эцэг эхчүүд төлөвлөх хэрэгтэй. “Гэр бүлийн амралт, аялал зугаалгыг уламжлал болгон хэвшүүл. Хүүхдүүд чинь эдгээр дурдатгалуудыг хэзээ ч мартажгүй” хэмээн Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон зөвлөжээ (Conference Report, 1987 оны 10-р сар, 63; *Ensign*, 1987 оны 11-р сар, 51).

- Амралтын үйл ажиллагаануудад гэр бүлээрээ оролцох нь ямар ашиг тустай вэ?

Ярилцлагыг идэвхжүүлэхийн тулд дараах зөвлөмжүүдийг, тэрчлэн өөрийнхөө зарим зөвлөмжийг хуваалцахыг бод:

- а. Үйл ажиллагаануудад хамтдаа оролцдог гэр бүлийн гишүүд илүү их хайр, эв нийцийг хөгжүүлэх болно.
 - б. Тэд хамтдаа хөгжилтэй байж, амьдралынхаа туршид үргэлжлэх харилцааг төлөвшүүлэх болно.
 - в. Эцэг эхтэйгээ хамт байх цаг хүүхдүүдэд таалагдаж, эцэг эхийнхээ зөвлөгөөг сонсож дагах илүү их хүсэлтэй байх болно.
- Өөрийг чинь хүүхэд байх үед зохиодог байсан гэр бүлийн ямар үйл ажиллагааны тухай дурдатгал та нарт байдаг вэ? Эдгээр үйл ажиллагаанууд ямар байдлаар амьдралд чинь нөлөөлсөн бэ?

Бага зардлаар буюу зардал гаргахгүйгээр хөгжилтэй, сонирхолтой, дурсгалтай гэр бүлийн үйл ажиллагаанууд зохион байгуулах талаар санаагаа хуваалцахад оролцогчдыг урь.

Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцааны тухай цуврал хичээлийн Б хэсгийн тойм

Энэ хичээл Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцааны тухай цуврал хичээлийн Б хэсгийг нэгтгэн дүгнэдэг. Хэрэв та цуврал хичээлийг бүхэлд нь зааж байгаа бол, дараах дасгалыг ашиглахыг бод:

Оролцогч бүрд хуудас цаас, үзэг буюу харандаа өг. Энэ цуврал хичээлийн 9–16-г дуусталх хичээлүүдээс өөрсдийн санаж байгаа сургаалууд болон зарчмуудыг жагсаан бичихэд гурван минут зарцуулахыг оролцогчдоос хүс. Өөрсдийнх нь хувьд хамгийн их учир холбогдолтой сургаалууд буюу зарчмуудыг тэднээр доогуур нь зуруул. Доогуур нь зурсан зарим зүйлүүдийнхээ тухай ярихад бэлтгэхэд нь тэднийг урамшуулан дэмж. Хэрэв тэдэнд тусалцаа хэрэгтэй бол, энэ гарын авлагын агуулгын хуудас v–viii-г, эсвэл *Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлагын vii–viii* хуудсан дахь тоймыг ашигла.

Гурван минутын дараа, өөрийн хийсэн жагсаалтаас нэг зүйлийг уншихыг, түүнчлэн энэ нь яагаад онцгой учир холбогдолтойг оролцогч бүрээс хүс. Оролцогчдын ойлголтуудыг самбар дээр хураангуйлж, тайлбар бүрийн ач холбогдлыг хүлээн зөвшөөр. Дараа нь өөрийнхөө ойлголтыг хуваалц. Цаг гарвал, энэ дасгалыг давтан хий.

Энэ цуврал хичээлд оролцсоных нь төлөө заадаг хүмүүстээ талархал илэрхийл, мөн цуврал хичээлийн туршид өөрсдийн ярилцсан сургаалууд хийгээд зарчмуудын дагуу амьдрахаа үргэлжлүүлэхэд нь тэднийг урамшуулан дэмж. “Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”-ийг гэр бүлийн гишүүдтэйгээ хамт үе үе уншихыг нь, түүнчлэн гэр орондоо үүний зөвлөгөөг дагахад нь бас тэднийг урамшуулан дэмж.

